ДХИС-ИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АСУУДЛУУД



Навааны Гантулга
ШШГС-ийн захирал, хууль зүйн ухааны
доктор, дэд профессор, хурандаа

ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн сургалтын өнөөгийн ерөнхий төлөв байдал, онцлог болон бодлогын түвшинд нэгдсэн шийдэлд хүрч эрх зүйн хувьд баталгаажуулан мөрдвөл зохих тулгамдсан зарим асуудлаар байр сууриа илэрхийлэх хэлбэрээр илтгэл (өгүүлэл)-ийг бэлтгэлээ[1].

Монгол улсын Засгийн газрын 2011 оны "ДХИС-ийг байгуулах тухай" 229 дүгээр тогтоолыг удирдлага болгон хууль зүй, дотоод хэргийн сайд 2011 оны 140, 173, 2012 оны А/37 дугаар тушаалаар ДХИС-ийн дүрэм, бүтэц, орон тооны дээд хязгаарыг баталж сургалтыг Удирдлагын, Цагдаагийн, Хилийн албаны, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн, Онцгой байдлын, Ахлагчийн сургуулиудад түшиглэн явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн.

Иймээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль нь D860200 индекс бүхий "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажил-эрх зүй" мэргэжлийн бакалаврын, E380000, F380000 индекс бүхий "Эрх зүй" мэргэжлийн магистрантур, докторантурын шүүхийн шийдвэр гүйцэтгэлд хамаарах сонгон судлах-мэргэшүүлэх сургалтыг хариуцан явуулж байна.

Өнөөдөр манай сургуулийн бакалаврын өдрийн ангид 139, эчнээ ангид 112, магистрантурт 9, докторантурт 8 сонсогч-алба хаагч суралцдаг[2].

Иймд сургалтын гол ачаалал бакалаврын түвшинд ноогддог байдлыг харгалзан илтгэлээ энэ сургалттай холбон боловсруулаа.

Сургалтыг тодорхой зорилгод хүрэх, зорилтуудыг хангахад чиглэсэн үйл явц гэж үзвэл уг харилцааны агуулгыг илэрхийлэгч гол элемент нь

- Мэргэжлийн тодорхойлолт
- Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, сургалтын заах арга зүй, зохион

[1] ШШГЕГ, ШШГС-иас хамтран 2012 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр "ШШГБ-ын алба хаагчдын сургалтын тогтолцоо, анхаарах асуудлууд" сэдвээр зохион байгуулсан эрдэм шинжилгээний онол практикийн бага хуралд тавьсан илтгэл.
Дугаар хэвлэгдэх энэ цаг мөчид "ШШГБА-эрх зүй" мэргэжлийн тодорхойлолт, сургалтын хөтөлбөр-төлөвлөгөө зохих хэмжээнд шинэчлэгдсэн тул сэтгүүлийн дараагийн дугаарт өөрчлөлтийн талаар бичнэ.

[2] 2012 оны 4 дүгээр сарын 25-ны байдлаар бакалаврын 1-р дамжаанд 31, 2-р дамжаанд 33, 3-р дамжаанд 40, 4-р дамжаанд 35 сонсогч, магистрантурын 1-р дамжаанд, 2-р дамжаанд (төгссөн), докторантурын 1-р дамжаанд 1, 2-р дамжаанд 2, 3-р дамжаанд 5 суралцаж байна.

байгууллалт, технологи

- Багшлах бүрэлдэхүүний чадамж
- Суралцагчдын үүрэг-хариуцлага
- Сургалтын материаллаг бааз, орчин нөхцөл болно.

Иймээс илтгэлийнхээ бүтцийг Сургалтын өнөөгийн байдал, Шийдвэрлэх асуудал гэсэн 2 дэд хэсэгт хуваан агуулгаа эдгээр 5 элементүүдэд суурилан илэрхийлье.

I

1.1. Мэргэжлийн тодорхойлолт бол сургалтын агуулгыг тодорхойлогч анхдагч баримт бичиг мөн. Чухамхүү энэ баримт бичигт мэргэжлийн зориулалт, төгсөгчдөд тавих нийтлэг, үндсэн, тусгай шаардлагыг эзэмших мэдлэг, дадал чадвар, хандлага гэсэн үзүүлэлтээр тодорхойлдог.

Иймээс сургууль, элсэгч (суралцагч, төгсөгч), ажил олгогчдын зүгээс энэ баримт бичигт онцгой анхаарал хандуулдаг.

Өнөөдөр мөрдөж буй "ШШГБА-Эрх зүй" мэргэжлийн тодорхойлолтыг Цагдаагийн академийн (хуучнаар) Эрдмийн Зөвлөлөөс дэмжиж Захирлын 2010 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн Б/329 дүгээр тушаалын 2-р хавсралтаар албажуулсан.

Түүнд "...ШШГБА-Эрх зүй мэргэжлээр төгсөгч нь ШШГБ-ын төрөл мэргэжлийн албадын анхан шатны нэгжид эрүү, иргэний чиглэлээр гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх цогц үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулах мэдлэг, дадал, чадварыг эзэмшсэн байна" хэмээн тодорхойлжээ.

Гэвч манай төгсөгчдийг ШШГЕГ-ын даргын тушаалаар ШШГБ-ын эрх зүйн өнөөгийн орчны онцлог[3], суралцагчдын судалсан хичээлүүдийн нэр төрөл, агуулга, сургалтыг удирдан зохион байгуулж ирсэн багш, төгсөгчдийн мэргэжил, мэргэшлийн бэлтгэл, тухайн мэргэжлээр төгсөгчдийг томилж ирсэн хүний нөөцийн бодлого, өнөөгийн хангамж зэрэг бусад хүчин зүйлсийг харгалзан хорих байгууллагад ээлжийн дарга, ерөнхий жижүүр, дэглэм, харуул хамгаалалтын ажилтан, нийгмийн ажилтан, төлөөлөгчийн албан тушаалд томилон ажиллуулж байна.

1.2. ШШГБА-Эрх зүй мэргэжлийн өнөөгийн мөрдөж буй сургалтын төлөвлөгөө 2010 онд шинэчлэн батлагдсан бөгөөд түүнд орсон өөрчлөлтийн гол онцлог нь:

а) Дээд боловсролын болон мэргэжлийн суурь хичээлүүдийг D380000 индекс бүхий "Эрх зүй" мэргэжлийн стандартад тусгагдсан багц цагын хэмжээнд тусгахыг эрмэлзсэн.

б) Мэргэшлийн, түүн дотроос Ялтны сэтгэл судлал[4], Нийгмийн ажил, Хорих байгууллагад явуулах гүйцэтгэх ажил зэрэг хичээлийн агуулгын багтаамжийг 5 багц цагтай болгон нэмэгдүүлсэн.

---

[3] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 132-р зүйлийн 132.4-д "Шийдвэр гүйцэтгэгч нь ял шийтгэлгүй, шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн Монгол улсын иргэн байна".

[4] Пенитенциар сэтгэл судлал хэмээх нэр томьеог өргөн утгаар нь ялтны сэтгэл судлал бус "Хорих ял эдлүүлэх харилцааны сэтгэл судлал" гэж нэрлэж болох юм. (илтгэгч)

в) Төрийн тусгай алба хаагчийн ёс зүй, бие бялдар, сэтгэлзүйн болон албаны шуурхай бэлэн байдлын талаархи мэдлэг, дадал, ур чадварын төлөвшлийг хангахад чиглэсэн зарим хичээлийг (тухайлбал: Хуульчийн ба ШШГБ-ын алба хаагчийн ёс зүй, Хүний эрх, Галын бэлтгэл, Албаны тусгай бэлтгэл, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэс) зайлшгүй судлахаар нэмж оруулсан.

г) Ангийн ажлыг мэргэжлийн чиглэлээр[5] бичиж хамгаалах журамд шилжүүлэн, төгсөлтийн шалгалтын уламжлалт төрөл, хэлбэрийг халж төгсөгчийн эрх зүй, мэргэшлийн мэдлэгийг тестээр, ур чадварыг тохиолдол-нөхцөл (кейс-бодлого) –ийг үнэлэн анализ хийж хууль, эрх зүйн бусад эх сурвалжийг ашиглан хэрхэн шийдвэр гаргаж буй байдлаар нь дүгнэх болсон.

Ийнхүү сургалтын төлөвлөгөөнд зарчмын шинжтэй өөрчлөлтүүд орсон ч багшлах бүрэлдэхүүний идэвхи-зүтгэл, санаачлага, зохион байгуулалт, ур чадвар, мэргэшлийн бэлтгэл, хүртээмжээс шалтгаалан түүнийг амилуулагч араа-шүд (механизм) болсон хичээлийн хөтөлбөр, сургалтын заах арга зүй, зохион байгуулалт, технологид төлөвлөсөн хэмжээний дорвитой ахиц дэвшил гараагүй ба үүнийг дараах баримтууд харуулж байна. Энэ нь:

а) Манай сургуульд (өмнө нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн тэнхимд) шууд хамаарах мэргэжлийн суурь-6, мэргэшүүлэх-12 хичээлийн 6-аас бусад хичээлийн хөтөлбөр жишиг стандарт-загварын дагуу боловсрогдоогүйн улмаас сургалтын хэрэгцээнд ашиглагдалгүй явж иржээ.

б) Хичээл хоорондын агуулгын уялдаа холбоо, залгамж чанарыг тэдгээрийн хөтөлбөр, цаг сэдвийн төлөвлөгөөгөөр нарийвчлан, оновчтой зохицуулж чадаагүйгээс цагдан хорих, баривчлах байр, согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, практик, хорих байгууллагын ажилтан, шийдвэр гүйцэтгэгчээс тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх техник-тактик, эрсдэл бүхий нөхцөлд[6] ялтантай харьцах, хэлэлцээр хийх, зөвшилцөлд хүрэх, эмнэлэгийн тусламж үзүүлэх, холбоо, бусад тусгай техник хэрэгсэл ашиглах зэрэг мэдлэг, дадал, чадвар олгоход чиглэсэн хичээл, хичээлийн сэдвүүд орхигдон сургалт зохион байгуулагдаж иржээ.

в) Хичээл-сургалтыг зохион байгуулж ирсэн багш нарын заах арга барил нь өнөөг хүртэл дийлэнхи тохиолдолд лекцлэх, асуулт асууж хариулт авах, бичгийн ажил-даалгавар хийлгэж дүгнэх уламжлалт хэв маягтай байна.

Энэ бүхнийг мөн бүрэлдэхүүн сургуулийн захиргаанаас 2011 оны 9-11 дүгээр сард ШШГБ-ын 29 анги, салбарын 248 офицер алба хаагчаас авсан санал асуулгын дүн давхар нотолж байна[7].

---

[5] ШШГЭЗ, Нийгмийн ажил хичээлээс сонгож бичин хамгаалах үүрэгтэй.

[6] Ялтан олеголон зарласан, бусдыг барьцаанд авсан, өөрийгөө боомилох, судсаа ханах, галдан шатаахыг завдаж буй зэрэг бусад нөхцөл, мөн эрэлд явах үедээ унаагүй, усгүй, халуун, хүйтэн орчинд зохимжтой бус хувцастай үед хэрхэн амь зуух гэх мэт.

[7] Төгсөгчдийн сурлагын чанарт нөлөөлж буй хамгийн гол хүчин зүйлс асуултын 10 гаруй хариултын хувилбараас судалгаанд оролцогчдын 70 орчим хувь нь сурах хичээлийн төрөл, агуулгын багтаамж, сургалтын зохион байгуулалтын хэлбэр (лекц, семинар, дасгал, дадлагын харьцаа), бүтээмжийг сонгон авсан.

1.3. ШШГЕГ, ДХИС-ийн удирдлагын зүгээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль байгуулах шийдвэр гарах цаг мөчөөс эхлэн сургуулийг чадварлаг, мэргэшсэн алба хаагчдаар бүрдүүлэх явдалд онцгой анхаарал хандуулсны дүнд өнөөдөр тэнхимийн эрхлэгч, багш нарын хувьд бакалаврын боловсрол эзэмшснээс хойш хорих байгууллага, шийдвэр гүйцэтгэх албад ерөнхий жижүүр, цэглэм-харуул хамгаалалтын ажилтан, нийгмийн ажилтан, ахлах төлөөлөгч, хорих ангийн дэд дарга, шийдвэр гүйцэтгэх албаны дарга зэрэг албан түшаалд 3-12 жил ажилласан алба хаагчид[8] хүсэлтээрээ болон бодлогоор томилогдон ажиллаж байна.

Мөн бүрэлдэхүүн сургуулиас алба хаагчдыг багшийн ажлын байрны шаардлагыг хангах, багшлах ажилдаа богино хугацаанд дадлагажин сурахад нь зохион байгуулалт, мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаа, зөвлөмжөөр зохих хэмжээнд ханган ажиллаж ирлээ. Тухайлбал: томилогдсон 7 багш-ажилтан энэ хугацаанд БСШУЯ-ны Боловсролын Хүрээлэнгийн дэргэдэх сурган заах арга зүйн сургалтад хамрагдан их, дээд сургуульд багшлах эрхийн гэрчилгээ авсан.

2012 оны 4 дүгээр сард тэнхимийн эрхлэгч, х/ч Б.Нямгомбо ДХИС-ийн айлчлалын багт орж Оросын холбооны улс, Турк улсын адил төстэй хөтөлбөр хэрэгжүүлдэг их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагаатай танилцаж туршлага судалж мэдээлэл авсан. Мөн ДХИС-ийн захиргаанаас 2011 оны 12 дугаар сард нийт багш нарт 1 сарын цалинтай тэмцэх мөнгөн урамшуулал олгосон.

Багш, а/х О.Батсайхан, а/х Ш.Энхжаргал нар 2012 оны 4-р сард ХЗҮХ-ээс зохион байгуулсан "Багшийн ёс зүй" сургалтад, багш, а/х Б.Баярсайхан ШШГЕГ, ШУТИС-иас хамтран зохион байгуулсан "Хорих байгууллагын нийгмийн ажил" сэдэвт 4 сарын сургалтад тус тус хамрагдан гэрчилгээ авсан.

Тэрчлэн бүрэлдэхүүн сургуулийн захирлын зүгээс тэнхимийн эрхлэгч, багш нарыг үндсэн үүргээс бусад захиргаа, олон нийт, аж ахуй, үйлчилгээний ажилд аль болох оролцуулахгүй байх, хурал цуглааны тоог багасган үр дүнг эрхэмлэх, биеэр үлгэрлэн манлайлж, зааж зөвлөн, хүн нэг бүрт хүрч ажиллах бодлогыг баримтлан ажиллаж байна.

1.4. ШШГБА-Эрх зүй мэргэжлээр суралцдаг өдрийн ангийн сонсогчид 100% 11-р анги төгссөн, эчнээ ангид –ШШГБ-ын системд 2-8 хүртэл жил ажиллаж буй алба хаагчид хамрагддаг.

Сонсогчид, тэдний ар гэрийнхний ШШГБ-ын үйл ажиллагааны талаархи мэдээлэл, харьцааг авч үзвэл өдрийн ангид суралцагчдын 20-30 орчим хувийнх нь ойр дотны төрөл

[8] -Тэнхимийн эрхлэгч, х/ч Б.Нямгомбо Хэнтий аймаг дахь Хорих 419 дүгээр ангийн дэд даргаар
- Тэнхимийн эрхлэгч, х/ч П.Гантөмөр Хорих 409-р ангийн ГАХХЭ дэд даргаар
- Багш, х/ч Н.Батдорж Хорих 409 дүгээр ангийн дэглэм, харуул хамгаалалтын байцаагчаар
- Багш, а/х О.Батсайхан ШШГЕГ-ын ерөнхий жижүүрээр
- Багш, а/х Б.Баярсайхан Хорих 407-р ангийн нийгмийн ажилтнаар
- Багш, а/х Ш.Энхжаргал ШШГЕГ-ын ХНСХ-ийн мэргэжилтнээр
- Багш, а/д М.Хүрэлбат Хорих 433-р ангид ахлах төлөөлөгчөөр ажиллаж байсан.

садангийн хүмүүс[9] тус салбарын байгууллагад ажилладаг байна.

Иймд сонсогчдын 70 гаруй хувь нь сургуульд элсэхдээ ирээдүйн (төгсөөд) ажилалбан тушаалын талаархи мэдлэг-мэдээлэл нь төсөөллийн шинжтэй байдаг судалгаа бий.

Мөн ШШГБА-эрх зүй мэргэжлээр элсэгчдийн[10] 28-30% нь л ерөнхий мэдлэгийн шалгалтын босго оноог хангаж иржээ[11]. Өөрөөр хэлбэл элсэгчдийн 70 орчим хувь нь ерөнхий мэдлэгийн шалгалтаар авбал зохих дундаж үзүүлэлтийн 50%-ийг хангасан байна.





[9] Аав, ээж, ах, эгч, өвөө, эмээ, авга, нагац ах, эгч гэх мэт

[10] Өдрийн ангид 2010 онд 40, 2011 онд 30 сонсогч элссэн.

[11] Элсэлтийн 2 шалгалтын босго оноог хангасан элсэгчид 2010 онд 28%, 2011 онд 30%-ийг эзэлжээ.



Түүнчлэн элсэгчдийн ерөнхий боловсролын гэрчилгээн дэх хичээлийн үнэлгээ "А", "В" боловч тэд сургуулиас жил бүр зохион байгуулж ирсэн түвшин тогтоох шалгалтанд ЕМШ болон ЕБ-ын гэрчилгээний үнэлгээгээ баталгаажуулж чадалгүй харинч бүгд хангалтгүй (F) дүгнэгдсэн.

ШШГБА-Эрх зүй мэргэжлээр суралцагчдын идэвхи-чармайлтыг бусад бүрэлдэхүүн сургуулиудтай харьцуулбал манай сонсогчид спорт (гардан тулаан, гар, сагсан, хөл бөмбөг, марш-тактик зэрэг), олон нийтийн ажилд илүү идэвхи чармайлттай оролцон, сургуулийн захиргаанаас өгсөн үүрэг даалгаврыг сайн биелүүлж, харин мэдлэг чадвар сорих тэмцээн, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд (хурал-зөвөлгөөн) дундаж түвшинд оролцож ирсэн.

1.5. ДХИС, ШШГЕГ-аас тус сургуулийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж буйн дүнд сургалтын орчин, материаллаг бааз зохих түвшинд бүрдсэн гэж хэлж болно. Тухайлбал:

а) Сургууль хичээлийн 1-р байрны 4 давхарт 14 нэгж өрөө-тасалгаа, анги-танхим бүхий бие даасан орчинд үйл ажиллагаагаа явуулдаг.

б) Сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгчид харъяа агентлагын хэлтсийн даргын, багш нар мэргэжилтнүүдийн түвшиний хангамж болох суурин компьютер, хувцас, номын шүүгээ, ширээ, сандал, бусад техник хэрэгслийг хүн нэг бүр эзэмшин ашигладаг.

в) Мөн сонсогч, суралцагчдын хандив тусламжийн дүнд манай сургууль "Бие даалтын иж бүрэн тохижилттой интернэт сүлжээнд холбогдсон танхим"-тай болж сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна.

II

Одоо илтгэлийн хоёрдугаар хэсэгт шилжиж нэгдсэн шийдэлд хүрэх зарим асуудлыг томьёолон, шийдвэрлэх гарц, боломж-нөхцлийн талаархи байр суурыа илэрхийлье.

2.1. ДХИС-ийн захиргааны зүгээс сургуулийн статусыг их сургуулийн түвшинд хүргэх, цаашид суралцагчдыг мэргэшүүлэн бэлтгэх стратегийн бодлого-зорилтыг

дэвшлүүлэн эхний алхамуудыг хийж байгааг та бүхэн мэднэ. Тодруулбал БСШУ-ны сайдын 2011 оны 497-р тушаалаар "Дээд боловсролын сургалтын байгууллагад бэлтгэх мэргэжлийн чиглэл, индекс"-ийн жагсаалтад манай үйл ажиллагаанд хамаарах

- ШШГБ-ын нийгмийн ажил /D860201/,
- ШШГБ-ын сэтгэл зүйч /D860202/,
- ШШГБ-ын аюулгүй байдлыг хангах алба /D860203/ гэсэн 3 мэргэжлийн индексийг шинээр тусган албажуулсан. Мөн ДХИС-ийн зүгээс БСШУЯ-ны МБГ-д эдгээр мэргэжлээр сургалт явуулах тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг тавьж асуудал үндсэндээ шийдвэрлэгдэх шатандаа хүрсэн.

ШШГЕГ хэдийгээр ДХИС-д (өмнө нь Цагдаагийн академид) суралцагчдыг ийнхүү мэргэшүүлэн сургах явдлыг дэмждэг[12] боловч ШШГБ-ын бакалаврын боловсролтой офицер, түүнтэй адилтгах албан тушаалтнаас ажиллах өнөөгийн хүний нөөцийн хангалттай уялдан ойрын жилүүдэд ШШГБ-ын чиглэлээр суралцагчдыг ШШГБА-Эрх зүй гэсэн нийтлэг мэргэжлээрээ бэлтгэх санал захиалгыг 2012 оны 2 дугаар сарын 14-ны өдрийн 1/618 албан бичгээр[13] өгсөн.

Энэ тохиолдолд захиалагч болон мэргэжилтнийг бэлтгэдэг байгууллагын бодлого зөрүүтэй мэт харагдавч энэ нь тэдний практик хэрэгцээг хангах чанартай хөрвөх чадвар бүхий хүний нөөцийг бэлтгэх, хүлээн авах гэсэн нийтлэг зорилго, боловсон хүчний өнөөгийн хангалттай уялдан нэгдмэл байдлаар тайлбарлагдаж болох юм.

Иймд энэ асуудлыг дараах арга замаар шийдвэрлэж болох юм.

Нэгдүгээр хувилбар: Сургалтын хугацааг хөндөлгүй өнөөгийн мөрдөж буй сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан мэргэшүүлэх хэсэгт сонгон судлах хичээлийг "Тогтоол гүйцэтгэл[14]" "Шийдвэр гүйцэтгэл[15]" гэсэн 2 багц хэсгээр хуваан ШШГЕГ-ын хүний нөөцийн захиалгыг үндэслэн 2-р дамжааны эцэст сонгон шалгаруулалт явуулж 3-р дамжааны 1-р хагасаас мэргэшүүлэн сургах тогтолцоонд шилжих.

Мөн энэ зарчмын хүрээнд сургалтыг 5 жил болгон үйлдвэрлэлийн дадлагын хугацааг (6-8 сар) нэмэгдүүлэн чадвар-дадал олгох явдалд илүү ач холбогдол өгч болох юм. Энэ нь төгсөгчдөөс гадаадын өндөр хөгжилтэй оронд үргэлжлэн сурахад нь ихээхэн дэмжлэг болно.

Хоёрдугаар хувилбар: Өнөөгийн мөрдөж буй сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулалгүй ШШГБА-Эрх зүйн мэргэжлийн 4 жилийн сургалтыг төгсч дээд боловсролын үнэмлэхээ авсны дараа богино хугацааны (45 хүртэлх хоногийн) томилогдохын өмнөх

---

[12] ШШГЕГ-ын дарга ДХИС-ийн захиралд хандан 2011 оны 11-р сарын 18-ны өдрийн 1/4444 албан бичгээр ийнхүү мэргэшүүлэн сургахыг дэмжиж саналаа ирүүлсэн.

[13] ШШГЕГ-ын дарга, бригадын генерал М.Ганхүү даргын гарын үсгээр албажсан.

[14] Хорих байгууллагын аюулгүй байдал-харуул хамгаалалтын ажилтан, Нийгмийн ажилтан, Сэтгэл зүйч

[15] Шийдвэр гүйцэтгэгч

мэргэшүүлэх сургалтад хамрагдснаар албан тушаалд томилогдох тогтолцоонд шилжих[16]. Энэ тохиолдолд ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн 4 жилийн сургалт мэргэжилтнийг бус, дээд боловсролтой алба хаагч бэлтгэдэг гэсэн ойлголт нийтэд хүрэх болно.

Санал болгож буй хувилбарын алийг нь ч сонгосон цаашид Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль төгсөгчдийн "Мэргэжлийн тодорхойлолт"-ыг (мэргэжлийн загвар) томилох боломжит бүх ажлын байрны шаардлагыг харгалзан дахин шинэчлэн боловсруулж батлуулах шаардлага байна. Учир нь төгсөгч сургалтын явцад ямар түвшний мэдлэг, дадал, чадварыг бүрэн эзэмшиж төлөвшсөн байх ёстой, ямар зүйлийг ажлын байран дээрээ бататган хөгжүүлэх вэ гэдэг зааг ялгааг мэргэжлийн тодорхойлолт, ШШГБ-ын боловсон хүчний зааврын алинд ч нарийвчлан тодорхойлж өгөлгүй ерөнхийлж тусгасан байдаг.

Мөн хүн бүх насаараа суралцан төлөвшдөг гэсэн амьдралын философитой практик байгууллагаас хүсэмжилдэг "бүрэн төлөвшсөн мэргэжилтэн"-ий шаардлага зөрчилдөөнийг бий болгодог. Үнэндээ хүний хөгжлийн дундаж түвшин, сургалтын эрх зүйн орчин, хугацаа, төлөвлөлт, багшлах бүрэлдэхүүний чадамж, санаачлага, материаллаг бааз, хангамж зэрэг олон хүчин зүйлсээр сургалтын болон төгсөгчдийн чанар тодорхойлогддог. Тэрчлэн зарим мэдлэг, чадвар, ажлын арга барилаа бид сургалтын дараа практикаас олж авснаа мартаж,үгүйсгэж болохгүй.

2.2. Сургалтын технологи-арга зүйд дараах өөрчлөлтүүдийг хийж болох юм. Энэ нь:

а) Мэргэжлийн тодорхойлолт (мэргэжилтний загвар)-д үндэслэн сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, цаг сэдвийн төлөвлөгөөгөөр төгсөгчдийн эзэмших мэдлэг, дадал, чадварыг сургалтын үе шатуудад нарийвчлан хуваах тухайн цаг хугацаанд нь үнэлж байвал зохино.

Мөн энэ хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн тэнхимийн эрхлэгч, ШШГЕГ-ын ХНСХ-ийн дарга нар хариуцан хичээлийн хөтөлбөрүүдийн агуулгын уялдаа холбоо, залгамж чанар, алдаа хийдэл, давхардал, зөрчилдөөний талаарх судалгаа дүгнэлтийг хичээлийн улирал бүр хийж хамтарсан онол, арга зүйн өргөтгөсөн хурал[17], ярилцлагын түвшинд хэлэлцэн шийдвэр гарган холбогдох ажил-арга хэмжээг авч явуулах журам-практикт шилжих ёстой.

б) Мэдлэг-мэдээллийг мэдрэхүйн 5 эрхтэнээр нь дамжуулан олгох сургалтын үндсэн технологийг удирдлага болгон сургалтыг зөвхөн нэг талаас ярьж нөгөө хэсэг нь сонсох идэвхгүй хэлбэрээр бус, техник хэрэгсэл, сургалтын интерактив аргуудыг өргөнөөр ашиглан нүдэнд харагдаж, сэтгэлд хоногших жишээ баримтаар баталгаажуулан, боломжтой бүх тохиолдолд суралцагч бүр гараараа барьж, биеэрээ давтан хийх, амт, үнэрийг нь мэдэрч суралцах хэв маягт шилжих ёстой.

---

[16] Өнөөдөр хорих байгууллагын төлөөлөгчдийг энэ журмаар томилж байна.

[17] Хуралд ШШГБ-ын холбогдох албан тушаалд ажиллаж буй алба хаагчдыг татан оролцуулж санал бодлыг нь сонсож хэлэлцэх.

Иймд мэргэжлийн ялангуяа мэргэшүүлэх хичээлийн сургалтын кабинетуудыг байгуулах, сургалтад ашиглах төрөл бүрийн хавтаст хэрэг, зураг, схем, макет, төлөвлөгөө, сургалтын кино, бодлого, эд зүйлс зэрэг хэрэглэгдэхүүний өргөн фондтой болох шаардлага байна.

в) Мэргэжлийн онцлогыг харгалзан танхимын болон танхимын бус сургалт, түүний хүрээнд хичээлийн хэлбэр болсон лекц, семинар, дасгал, дадлага, бие даалтын агууламж, харьцааг зөв тогтооход зарчмын шинжтэй өөрчлөлтүүдийг хийх ёстой.

Учир нь дээд боловсролын суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлүүдийн хувьд багц цагын хэмжүүр /харьцаа/ нь өөр байхыг амьдрал шаарддаг. Тодруулбал онолын хичээлийн хувьд лекцийн цаг, мэргэшүүлэх хичээлд семинар, дасгал, дадлагын цаг нь бусад сургалтын хэлбэрээсээ илүү цагаар зохион байгуулагдан энэ хирээр Сургалтын төлөвлөгөө, Сонсогчийн мэдлэг чадварыг үнэлэх журам, Профессор багшийн ажлыг багц цагаар үнэлэх журамд холбогдох өөрчлөлтүүд орвол сургалтын чанарт мэдрэгдэхүйц ахиц дэвшил гарах магадлалтай.

г) Мэргэжлийн, мэргэшүүлэх хичээлийг бодит орчинд нь явуулахыг чухалчлан клиникийн орчинг бүрдүүлэх талаар ШШГЕГ, хорих анги, шийдвэр гүйцэтгэлийн албатай харилцан зөвшилцөж зохион байгуулалтын арга хэмжээ авах.

2.3. Багшлах бүрэлдэхүүний хувьд илтгэлийн 1-р хэсэгт дурьдсан давуу талаас гадна цаашид анхаарч шийдвэрлэх бодлогын шинж чанартай асуудлууд бий. Энэ нь:

а) Шинээр томилогдсон багш нарыг сурган хүмүүжүүлэх ажилд сурган дадлагажуулах. Учир нь тэд цэргийн алба хаагч, ялтантай шууд харьцаж ажлаа захирамжлах, үүрэг болгох замаар зохион байгуулж ирсэн. Гэтэл сургалтын байгууллагын хувьд багш бол суралцагчын хамгийн дотны удирдагч, хамтрагч, найз, аав, ээж нь байдаг. Иймд тэд ажлаа итгэн үнэмшүүлэх, биеэр үлгэрлэх, зөвлөх арга барилаар явуулдаг. Мөн шинэ багш нарын хувьд сургалтын техник хэрэгсэлийг чадварлаг эзэмшин хичээлийг интерактив идэвхитэй аргаар төрөл, хэлбэр, онцлогт тохируулан зохион байгуулах дадал, чадварт сурах явдал онцгой ач холбогдолтой.

б) Багш нарын гадаад хэлний, нэн ялангуяа англи, орос хэлний мэдлэг, чадварыг шаардлагын түвшинд хүргэх.

в) Багш бол мэргэшсэн судлаач, эрдэм шинжилгээний ажилтан тул судалгаа шинжилгээний арга зүйд суралцан бүтээл тууривах ажилд онцгой ач холбогдол өгвөл зохино.

"Амьдрал ямагт хууль эрх зүйгээс өргөн баян байдаг", "Хоёр толгой нэгээс илүү" зэрэг амьдралаар шалгагдсан үнэн болон асуудлыг бодит нөхцөлд шийдвэрлэхэд хүний, бусад олон хүчин зүйл нөлөөлдөг явдлыг иш үндэс болгон ажлын арвин дадал туршлагатай, ур чадвартай ажилтнуудаар[18] мэргэшсэн тодорхой сэдэв-асуудлаар нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн мэргэжлийн, мэргэшүүлэх хичээлийг тодорхой цагаар зайлшгүй

[18] Зайлшгүй ахмад настай, олон жил ажиллаж байгаа гэж явцуурахгүй байх нь чухал

заалгах журам, практик тогтоох нь ач холбогдолтой. Учир нь: миний бие Цагдаагийн академийн тэргүүн дэд захирлаар ажиллах хугацаанд бидний санал-санаачилагаар нийслэлд ажиллаж буй Цагдаагийн байгууллагын тасгийн дарга, түүнээс дээшхи албан тушаалтан бүр Цагдаагийн сургуульд нэг хичээлийн жилд 2-оос доошгүй багц цагын хичээл заах үүргийг ажлын байрны тодорхойлолт үр дүнгийн гэрээгээр хүлээж ирсэн ба өнөөдөрч мөрдөж байна.

2.4. Суралцагчдыг чанаржуулах хүрээнд эрсэлтийн шалгалтын онооны босгыг бууруулахгүй байх, шалгуур хангаагүй тохиолдолд элсүүлэхгүй байх бодлогыг нэг мөр баримтлах шаардлагатай.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуульд төгсөгчдийн томилолтын практикт зарим нэг журмыг тогтоож болох юм. Тухайлбал: БНТУ-ын Цагдаагийн академийг төгсөгчид сурлагын амжилтаараа бэлэн ажлын байрнаас 72 цагын дотор сонголт хийж өөрс хоорондоо солих боломжтой байдаг.

Иймд энэ журмаас санаа авч манай сургуулийг бүх хичээлээр "А", "В" үнэлгээтэй төгсөгчид зөвхөн сурлагын амжилтын дараалаар санал болгож байгаа ажлын байрнаас сонголт хийх, "D" үнэлгээтэй төгсөгчийг 1 жил хүртэл хугацаагаар ахлагчаар холбогдох албан тушаалд томилох журамд шилжвэл суралцагчдын идэвхи зүтгэл, сурлагадаа хандах хандлагад эрс өөрчлөлт гарна гэсэн бодомж байдаг.

2.5. Сурлагын амжилт, төгсөгчдийн бэлтгэлд нөлөөлөх голлох хүчин зүйлсийн нэн тэргүүнд яахын аргагүй сургалтын ая тухтай орчин мөн.

ШШГБ-ын удирдлагын зүгээс ДХИС, түүний дотор ШШГС анхлан байгуулагдах цаг мөчид бүрэлдэхүүн сургуулийн шинэ барилгыг 2012-2013 оны хичээлийн жилийн өмнө 2012 оны 8-р сард барьж ашиглалтад оруулна гэсэн маш том амлалт, зорилтыг тавьж ажил эхэлснийг хүн бүр мэдэж байгаа. Энэ ажил ихээхэн хөрөнгө мөнгө, зөвшөөрөл, хяналт, зохицуулалт шаардсан гэдгийг ойлгож байгаа бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд сургуульд одоо ажиллаж, суралцаж байгаа бие бүрэлдхүүн маань ямарч хэлбэрээр, бүх талаар дэмжин оролцоход бэлэн байгааг энэ дашрамд хэлье.

Эцэст нь үнэтэй цагаа илтгэлийг минь тэвчээртэй сонсож, үзэл бодлоо илэрхийлэх бололцоо олгосон явдалд оролцогч хүн бүхэнд баярласнаа илэрхийлье.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН СУРГУУЛЬ,
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫГ
ЭРДМИЙН АЧ БУЯН, ӨӨДРӨГ ҮЗЭЛ БОДОЛ БАЙНГА
ТОЙРОН ХҮРЭЭЛЖ ИВЭЭЖ БАЙХ БОЛТУГАЙ.

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ШИНЭЧЛЭЛТ



Ваанчигийн Жавхланцогт
ДХИС, Сургалтын бодлогын газар,
Сургалтын бодлого, үнэлгээний хэлтсийн дарга,
дэд хурандаа, докторант

ХУРААНГУЙ

Монгол Улсын Засгийн Газрын 2011.07.08-ны өдрийн 229-р тогтоолоор Дотоод Хэргийн Их сургууль байгууллагдсанаар ХЗДХЯ-ны харьяа агентлагуудад мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх сургалтын үйл ажиллагааг "СУРГАЛТ-ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ" гэсэн хэлбэрээс "ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ-СУРГАЛТ-ҮЙЛДВЭРЛЭЛ буюу ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ-СУРГАЛТ" гэсэн хэв шинжид шилжүүлэн сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох шаардлага тавигдаж байна.

Төрийн тусгай албаны мэргэжлийн өндөр боловсролтой, үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтэн бэлтгэн гаргах нь ДХИС-ийн эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зорилго бөгөөд дараах үе шат бүхий багц судалгааны ажлыг хэрэгжүүлснээр хангана гэж үзсэн.

Үүнд:

- ДХИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын инноваци, сургалтын шаталсан тогтолцоог бий болгох;
- Төрийн тусгай албаны мэргэжил олгох сургалтын технологийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх тус тус болно.

ДХИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын инновацийн тогтолцоог бий болгосноор ХЗДХЯ-ны харьяа агентлагуудын өнөөгийн эрэлт хэрэгцээ, шаардлага, хэтийн хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэн, судалгаанд суурилсан мэдлэгийг бүтээн бий болгоход чиглүүлнэ.

ДХИС-ийн сургалтын технологийн шинэчлэлийн хүрээнд сургалтаар дэвшүүлсэн зорилгыг бүрэлдэхүүний сургуулиудын эрдэм шинжилгээ, сургалтын үнэт зүйлс дээр суурилан, түүнийг хөгжүүлэн боловсронгуй болгох замаар технологийн шинэчлэлтийг хийнэ. Сургалтын технологи нь дараах бүтэцтэй байхаар төсөөлж байгаа болно.

Үүнд:

1. Онолын мэдлэг олгох хичээлийн технологи;

2. Дадлагажуулах хичээлийн технологи;

3. Төрийн тусгай албадын үйл ажиллагаа, сургалтын хүрээнд хийгдэх эрдэм шинжилгээ, судалгааны ажлын стандарт тус тус болно.

Сургалтын технологийн шинэчлэлтийг Их сургуулийн бүрэлдэхүүн сургуулиуд тус бүрийн албаны онцлогтой уялдуулан хэрэгжүүлснээр эрдэм шинжилгээ-сургалтын үйл ажиллагааны нэгдмэл чанарыг хангаж, сургалтыг салбар шинжлэх ухаан, нийгмийн хөгжлийн чиг хандлага, боловсон хүчин захиалагч байгууллагуудын эрэлт хэрэгцээтэй нийцүүлэн явуулах боломж бүрдэнэ гэж үзэж байгаа болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ХАРЬЯА ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ШИНЭЧЛЭЛТ

Дотоод хэргийн их сургууль (цаашид ДХИС гэх) нь анх 1934 онд Дотоод Явдлын Яамны Төв Сургууль нэртэйгээр байгууллагдсанаар Монгол Улсын аюулгүй байдлыг хангах салбарт өнөөдрийг хүртэлх түүхэн цаг хугацааны туршид мэргэжлийн офицер, боловсон хүчнийг тасралтгүй бэлтгэж, уг салбарын сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагааг хангаж ирлээ. Уг хугацаанд "Төв сургууль", "Дотоод явдлын яамны Хязгаарын ба дотоодын цэргийн нэгдсэн сургууль", "Нийгмийг аюулаас хамгаалах яамны Цэргийн тусгай дунд сургууль", "Нийгмийг аюулаас хамгаалах яамны Цэргийн дээд сургууль" гэсэн нэрээр 1990 оны эхэн үеийг хүртэл үйл ажиллагаагаа явуулж ирсэн бөгөөд тухайн үеийн нийгмийн өөрчлөлтэй уялдан "Цагдаагийн дээд сургууль" ба "Хилийн цэргийн дээд сургууль" болон салж 2011 оныг хүртэл бие даасан байдлаар сургалтын үйл ажиллагааг явуулж ирсэн.

Аюулгүй байдлын хангах хэрэгцээ шаардлага Монгол Төрийн анхааралд байнга байсны нэг илрэл нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 229 дугаар тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн салбарын боловсон хүчин бэлтгэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын уялдааг сайжруулах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамны (цаашид ХЗДХЯ гэх) харьяанд Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургуулийг нэгтгэн Дотоод хэргийн их сургуулийг байгуулсан явдал гэж үзэж болно.

Өнөөдөр ДХИС нь Удирдлагын, Цагдаагийн, Хилийн албаны, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн, Онцгой байдлын, Ахлагчийн гэсэн бүрэлдэхүүний 6 сургууль, Ерөнхий эрдмийн 7 тэнхим, Гадаад хэлний төв, "Соёмбо" спорт хороо гэсэн бүтэцтэйгээр нийт 10 мэргэжлээр бакалаврын зэрэг олгох, 6 мэргэжлээр мэргэжлийн боловсрол олгох сургалтыг тус тус зохион байгуулж байна.

Улс орны аюулгүй байдлыг хангах алба, үйл ажиллагаа олон жилийн туршид Төрийн нуцад хамаарч байсан бөгөөд сургалтын онол, арга зүй ч мөн тэр хэмжээгээр хаалттай

байсан. Энэ нь өнгөрсөн зуунд манай улс социалист системийн хамтын нийгэмлэгт багтаж, тухайн үеийн Зөвлөлт Холбоот Улсын аюулгүй байдлыг хангах системыг хуулбарлан хэрэглэж байсантай шууд холбоотой. Тодорхой хэмжээгээр хаалттай байсан ч тухайн цаг үеийн төгсөгчид офицер, мэргэжилтнүүд Монгол Улсын аюулаас хамгаалах, хууль сахиулах салбарын үйл ажиллагааг нэр төртэй хангаж ирсэн нь сургалтын агуулга, арга зүй нь тухайн цаг үеийнхээ нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангаж байжээ гэж үзэж болох юм.

Хүн төрөлхтний хөгжлийн чиг хандлагыг даган 1990-ээд оны эхэн үеэс ардчилсан эрх зүйт нийгмийг сонгон шинэ "Үндсэн хууль"-иараа баталгаажуулсан нь нийгмийн бүхий л салбарт эрс шинэчлэлт хийх суурийг тавьсан. Энэ нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах салбарыг тойроогүй билээ.

Өнөөдөр Монгол Улсын дотоодын аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагаа уг өөрчлөлттэй уялдан эрчимтэй хувьсан хөгжиж байна. Энэ нь ДХИС-ийн эрдэм шинжилгээ-сургалтын үйл ажиллагааг дэлхий дахины болон бүс нутгийн аюулгүй байдлыг хангах үзэл баримтлалд гарч буй хувьсал өөрчлөлттэй зохицуулан шинэчлэх шаардлага бий болж байгаа юм.

ДХИС-ийн сургалтыг эрдэм шинжилгээ-сургалтын тэргүүний чадавх бүхий их сургууль болгон хөгжүүлэх шаардлагыг **"ДХИС-ИЙН СУРГАЛТЫН НЭГДСЭН ТОГТОЛЦОО"** судалгааны ажлыг хэрэгжүүлэх замаар хангана гэж үзсэн болно.

"ДХИС-ийн сургалтын нэгдсэн тогтолцоо" судалгааны ажлыг дараах шатлал бүхий дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар хангана гэсэн таамаглал дэвшүүллээ:Үүнд:

1. "ДХИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын инноваци" дэд хөтөлбөр,

2. "ДХИС-ийн сургалтын технологийн шинэчлэл" судалгааны дэд хөтөлбөр тус тус болно.

"ДХИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын инноваци" дэд хөтөлбөр нь ХЗДХЯ-ны харьяа агентлагуудын өнөөгийн эрэлт хэрэгцээ, шаардлага, хэтийн хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэн, судалгаанд суурилан бүтээсэн мэдлэгийг Их сургуулийн хэмжээнд явагдаж байгаа бүх шатны сургалтын агуулгад нэвтрүүлэх зорилгоор Сургалтын бодлогын газар, Эрдэм шинжилгээний хүрээлэн, Доктор, магистрын сургалтын алба хамтарсан байдлаар хэрэгжүүлнэ.

"ДХИС-ийн сургалтын технологийн шинэчлэл" судалгааны дэд хөтөлбөрийг бүрэлдэхүүний сургуулиудын эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа, эрдэмтэн багш нарын онол, заах арга зүй, мэдлэг боловсрол, ажлын туршлага дээр бий болсон ололт амжилт дээр суурилан, түүнийг хөгжүүлэн боловсронгуй болгох замаар сургалтын технологийн шинэчлэлтийг хийнэ. "Сургалтын технологи" хэмээх ойлголтыг ДХИС-ийн сургалтын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн дараах байдлаар тодорхойлж болно.

Үүнд: ***"Төрийн тусгай албаны мэргэжлийн мэдлэг, дадлага, чадварыг олгох үйлийг зохион байгуулж, явуулах арга, хэлбэр, хэрэглийг хамгийн оновчтой байдлаар ашиглах үйлдлийн эрэмбэ дараалын зохистой хувилбар"*** болох юм.

"ДХИС-ийн сургалтын технологи" нь төрийн тусгай албаны мэргэжлийн мэдлэг олгох хичээлийн агуулга, стандарт, арга зүйн онцлогтой хувилбар байна.

Сургалтын зорилгыг дараах нийтлэг гурван зорилтод хуваан авч үзэх хандлага байна. Үүнд:

1. Суралцагчийн оюуны чадавх, сэтгэлгээг хөгжүүлэх;

2. Ажил, албанд хэрэгцээтэй мэдлэг, дадал, чадварыг олгох;

3. Эрдэм шинжилгээ судалгааны арга зүйг эзэмшүүлэх тус тус болно.

Сургалтын үйл ажиллагааны үр дүн, түүнд өгөгдөж буй үнэлгээ нь сургалтын зорилгыг дахин тодорхойлох эргэх холбоотой байх ба манай сургуулийн сургалтын технологийн онцлог болно.

ДХИС-ийн сургалтын шинэчлэлтийн гол агуулга бол Төрийн тусгай албаны сургалтын технологи бүхий сургалтын шаталсан тогтолцоог бүрдүүлэхэд оршиж байгаа бөгөөд дараах бие даасан нэгж судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэснээр хангах юм.

Үүнд:

- Монгол Улсын болон олон улсын холбогдох эрх зүйн хэм хэмжээ, гадаад дотоодын ижил төстэй сургуулиудын ололт амжилт, туршлагын хүрээнд төрийн тусгай албаны мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах тогтолцоо, агуулга, арга зүй, чиг хандлагыг тодорхойлох;

- Төрийн тусгай албаны мэргэжлийн чиглэлээр төгссөн мэргэжилтний мэдлэг, чадвар, дадлагын шаардлагын өнөөдрийн төвшин, эрэлт хэрэгцээг тодорхойлох;

- Их сургуулийн багш, эрдэмтэд болон боловсон хүчин захиалагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай хамтарсан Төрийн тусгай албаны мэргэжлүүдийн стандарт, мэргэжилтний загвар, сургалтын төлөвлөгөөг боловсруулах тус тус болно.

Их сургуулиас Төрийн тусгай албаны хэрэгцээ шаардлагад тулгуурлан шинээр санал болгосон 27 мэргэжлийн чиглэлийг Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны 12 дугаар сарын 07-ны 497 тоот тушаалаар баталгаажуулсан. Мөн сургуулийн эрдэмтэн, багш нарын хүчээр 2011-2012 оны хичээлийн жилд дээрх судалгааны ажлыг бүрэн хийж дууссан бөгөөд үр дүнд тулгуурлан сургалтын үйл ажиллагааны төвшинд хэрэгжүүлэхээр дараах асуудлуудыг төлөвлөж байна.

Үүнд:

Их сургууль нь Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг, байгууллагуудын

боловсон хүчин бэлтгэх сургалтыг "Хууль зүй", "Цэргийн ухаан", "Хил судлал"-ын шинжлэх ухааны болон "Шүүхийн шинжилгээ зүй", "Гамшиг судлал", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал", "Цагдаа судлал"-ын онол, зарчим, зүй тогтлын хүрээнд ялгамжтай зохион байгуулах шаардлагыг дараах нөхцөл байдал бүрдүүлж байна.

Үүнд:

• Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Шүүх шинжилгээний, Онцгой байдлын байгууллагын сургалт нь "Хууль зүйн шинжлэх ухаан"-нд, Хилийн ба дотоод цэргийн сургалт нь "Цэргийн шинжлэх ухаан"-ны харьяалалд тус тус хамаарч ирсэн уламжлалтай;

• Боловсон хүчин захиалагч байгууллагуудын харилцан адилгүй чиг үүрэгтэй уялдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны 12 дугаар сарын 07-ны 497 дугаар тушаалаар "Шүүхийн шинжилгээ зүй", "Гамшиг судлал", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал", "Цагдаа судлал"-ын докторын зэргийн боловсролын мэргэжлийн индекс олгосон.

Их сургуулийн мэргэжил олгох, давтан, мэргэшүүлэх боловсролын зэрэг дээшлүүлэх сургалтад шинжлэх ухааны цогц мэдлэг олгох уламжлалт "Академик" ба амьдралд хэрэгжих хэрэгцээт мэдлэг, чадамж олгох "Прагматик" сургалтын чиг хандлагын зохистой харьцааг тодорхойлж сургалтын технологид нэвтрүүлэх шаардлага дараах байдлаар илэрч байна.

Үүнд:

• Төрийн тусгай албаны шаардлага тасралтүй хувьсаж байдаг нь сургалтын технологи болон төгсөгчдийн эзэмших мэдлэг, чадварын агуулгад нөлөөлдөг;

• Мэргэжлийн боловсрол олгох сургалтын онолын мэдлэг олгох сургалтыг 30%, дадлагын сургалтыг 70% байхаар Мэргэжлийн боловсрол, сургалтын газраас тогтоосон;

• Монгол Улсын бүрэн дүнд боловсролын сургалтад Кембрижийн сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэхээр Боловсрол соёл, шинжлэх ухааны яамнаас шийдвэрлэсэн;

• "Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө" баримт бичигт "Агентлаг, байгууллагуудын удирдах ажилтныг бэлтгэх академик сургалт явуулах" гэж сургалтын чиг хандлагыг тодорхойлсон тус тус болно.

Төрийн тусгай албаны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Их сургуулийн мэргэжил олгох сургалтыг агуулгын залгамж бүхий дараах хэлбэрээр шатлан эзэмшүүлэх боломжтой.

Үүнд:

• Бүрэн дунд боловсролын сургуулиудыг түшиглэсэн "Нийгмийн ухаан"-ы гүнзгийрүүлсэн сургалтыг "Ахлах сургууль"-ийн хугацаанд;

• Ахлагчийн сургуульд "Мэргэжлийн боловсрол" олгох үндсэн сургалтыг 10 сарын

хугацаагаар /захиалагч байгууллагын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн богино хугацааны сургалт/;

• Бакалаврын зэрэг олгох сургалтыг суурь мэргэжлүүдээр 2 жил, мэргэшүүлэх мэргэжлийн чиглэлээр үргэлжлүүлэн 2 жилээр шаглан нийт 4 жилийн хугацаагаар;

• Удирдлагын сургуулиар магистрын боловсролын төвшний мэргэжил олгох сургалтыг 2 жилийн хугацаагаар тус тус зохион байгуулна.

Их сургууль нь өөрийн сургалтын агуулгаа Монгол Улсын дотоодын аюулгүй байдлыг хангах бодлого, орчин, нөлөөлөх хүчин зүйлсийн хүрээнд судалгаанд суурилан бий болгох онцлогтой байна. Энэ нь суралцагсдад мэдлэг, чадвар эзэмшүүлэх арга зүй, хэлбэр, хэрэглэгдэхүүн, үнэлгээний цогц системтай байх шаардлагыг бий болгож байна. Дээрх шаардлагыг хангах арга замыг Төрийн тусгай албаны мэргэжил олгох сургалтын онцлогт нийцсэн сургалтын технологитой байх гэж үзэж байгаа бөгөөд мэргэжил олгох шаталсан сургалттай уялдсан харилцан хамаарал бүхий дараах 3 хэсгээр тодорхойлогдоно.

Үүнд:

• Бүрэнд дунд боловсролын сургуульд чийгмийн ухааны гүнзгийрүүлсэн мэдлэг олгох, бие бялдар болон албанд ажиллах хүсэл, сонирхлыг хөгжүүлэх;

• Төрийн тусгай албаны шаардлагад нийцсэн мэргэжлийн мэдлэг чадварыг эзэмшүүлэх;

• Төгсөгчдийг томилгоот албан тушаалд дадлагажих, дасан зохицох, эзэмшсэн мэдлэгээ хэрэглээ болгоход дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааны технологи тус тус болно.

Судалгааны ажлын явц, үйл ажиллагааны үр дүнд:

• ДХИС-ийн сургалтын үзэл баримтлал;

• Сургалтын шаталсан тогтолцооны загвар;

• Мэргэжлийн стандарт;

• Мэргэжилтний загвар;

• Сургалтын төлөвлөгөө, түүний задаргаа шинэчлэгдэн бий болсон нь

Сургалтын Нэгдсэн Тогтолцоо судалгааны ажлын хүрээнд "ДХИС-ийн сургалтын технологийн шинэчлэл" дэд хөтөлбөрийн хэрэгжилт 50%-тай, "ДХИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын инноваци" дэд хөтөлбөр эхлэлийн төдий байна. Их сургуулийн үйл ажиллагааны үр дүнгийн илрэл 4 жилийн давтамжтайгаар байдаг гэж үзвэл 2015-2016 оны хичээлийн жилд судалгааны ажлын эхний үр дүнгүүд гарч эхэлнэ.

Судалгааны ажлын эцсийн үр дүн нь Төрийн тусгай албаны өндөр боловсрол, цогц чадамж бүхий мэргэжилтэн бэлтгэгдэн гарснаар хангагдах болно.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН ШИНЭЧЛЭЛ



Төмөрбаатарын Хишигтогтох
ДХИС-ийн Сургалтын бодлого, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн, доктор, ахлах дэслэгч

Өнөөгийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажил-эрх зүй" гэсэн 1 мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж байна.

Сүүлийн жилүүдэд үйлдэгдэж буй гэмт хэргийн дийлэнх хувийг хүнд буюу онц хүнд гэмт хэрэг тэр дундаа урьд төдийлөн түгээмэл үйлдэгддэггүй байсан албан тушаалын болон хээл хахууль, залилан мэхлэх, мэдээллийн аюулгүй байдал, хүний наймаа, хар тамхи хэрэглэх, тээвэрлэх, бүлэг зохион байгуулалттай аллага, хүчирхийллийн учир гэмт хэрэгт нөлөө бүхий этгээдүүд болон түүний гар хөл бологчид шийтгэгдэх хандлага ихсэж байна.

Өнөөдрийн байдлаар хорих ангид 6500-7500 ялтан, цагдан хорих байранд 1500-2000 сэжигтэн, яллагдагч хоригдож байна. Эдгээр ялтны 40-60 хувь буюу 4200-5800 орчим нь 2 ба түүнээс дээш удаа гэмт хэрэг үйлдсэн, рецедив гэмт хэрэгтнээр тооцогдсон этгээд байна. Түүнчлэн ял эдэлж буй ялтнаас нийгэм, ард иргэдэд 81 орчим тэрбум төгрөгний хохирол учруулсан тоо баримт байна.

Гэмт хэрэгт сэжиглэгдэн хоригдож байгаа сэжигтэн, яллагдагч, ялтан сэтгэлийн түгшүүр айдаст автах, стресст орох. хорих анги, цагдан хорих байрнаас оргох, бие эрхтэндээ санаатай гэмтэл учруулах, амиа хорлох, биенээ дарамтлах, бусдыг заналхийлэх, алба хаагчидтай зүй бус харьцах, хэл амаар доромжлох, эрх чөлөөнд нь халдах зэргээр гэмт хэрэг үйлдэх нийгмийн таагүй орчинг байнга үүсгэж байдаг. Үүний шалтгаан нөхцөл нь:

► Хорих ангид мэргэжлийн нийгмийн ажилтан дутагдалтай байдлаас болж сургалт, судалгааны ажил үр дүнтэй зохион байгуулдаггүй, /Нийт ял эдэлж буй ялтны 60 гаруй хувь нь 2 ба түүнээс дээш удаа гэмт хэрэг үйлдсэн ялтнууд байна/

► Эдийн засгийн тогтворгүй байдал, ядуурал, ажилгүйдлийн төвшин гэмт хэрэг үйлдэх шалтгаан нөхцөл болж байгаад анхаарч тэднийг нийгэмшүүлэх чиглэлээр хорих байгууллагаас төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллахад нийгмийн ажилтны гүйцэтгэх үүргийг хуулчилж өгөөгүйгээс энэ талаарх мэдлэг хомс,

► Боловсрол, мэргэжилгүй ялтнууд гэмт хэрэг үйлдэх явдал ихсэж хоригдогч болон ялтанд хууль эрх зүй, амьдрах арга ухаан, нийгэмшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах ажил тодорхой төвшинд хийдэггүй зэрэг байдлаас ялтнууд бие биенээ дарамтлах, зодох, айлган сүрдүүлэх, амиа хорлох, оргох зэрэг гэмт хэрэг, зөрчлийн тоо жил ирэх тусам өсөх хандлагатай байна. Тухайл ал:

Хорих ангиас оргосон болон оргохыг завдсан:

2007	2008	2009	2010	2011
18	10	14	10	12

Хорих анги, цагдан хорих байранд гарсан гэмт хэрэг, зөрчил:

2007	2008	2009	2010	2011
859	851	1114	1182	1884

Хоригдогч, ялтан амиа хорлож нас барьсан:

2007	2008	2009	2010	2011
17	15	14	20	28

Хорих байгууллагад мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, аюулгүй байдлыг хангах албаны ажилтныг бэлтгэснээр хоригдогч, ялтны дундаас гарч болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хор уршгийг таниулах, нийгэмд учруулсан хохирлоо нөхөн төлөх, үйлдсэн гэмээ ойлгож ухамсарлах боломжийг олгох, нөгөөтэйгүүр хоригдогч, ялтан өөрийгөө хөгжүүлэх, тэдний авьяас, чадварыг нээх, мэргэжил эзэмшүүлэхэд төдийгүй ял эдэлж суллагдаад нийгэмд дасан зохицож, дахин давтан гэмт хэрэг үйлдэх явдал буурах чухал нөлөөтэй юм. Мэргэшсэн нийгмийн ажилтан нь ялтантай хамгийн ойр ажиллаж тэдэнд хууль эрх зүй, амьдрах арга ухааны талаар заавар, зөвлөгөө өгөх, нийгмийн эрэг хандлагыг төлөвшүүлэх байнгын зөвлөгч болох ёстой юм.

Энэ байдлыг харгалзан Хууль зүй дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 2008 оны 08 сарын 20 ны өдрийн 205\94 дугаар тушаалаар жишиг норматив тогтоосон.Үүнд:

1. Төвлөрсөн хорих ангид 75-150 хоригдолд 1 нийгмийн ажилтан, сэтгэл зүйч /100-150 ялтан/ 1,

2. Гянданд нийгмийн ажилтан 75-150 хоригдолд 2 нийгмийн ажилтан, сэтгэл зүйч 1 ажиллахаар тогтоосон.

3. Цагдан хорих байранд 50-100 хоригдогчид 1 нийгмийн ажилтан,, сэтгэл зүйч /50-100 хоригдогч/1байхаар жишиг норматив тогтоосон.

ШШГБайгууллагад өнөөдрийн байдлаар нийгмийн ажилтан албан тушаалд тогтоосон

нормативын хүрээнд 166 ажилтан ажиллахаас 74 албан хаагч ажиллаж байна. Үүнээс нийгмийн ажилтан мэргэжилтэй 19, бусад 55 алба хаагч нь мэргэжлийн бус байна.

ШШГЕГ-аас 2011 онд Хууль зүй дотоод хэргийн яам, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яаманд 20-40 ялтанд 1 нийгмийн ажилтан, 1 сэтгэл зүйч ажиллахаар саналаа уламжилсан байна.

Өнөөдрийн байдлаар Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд ажиллах нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, аюулгүй байдлын ажилтныг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын томилогдохын өмнөх 14 хоногийн хууль эрх зүй. цэргийн хэргийн мэдлэг олгох сургалтанд хамруулж, томилон ажиллуулж байна. Томилогдсон албан хаагчид нь хоригдогч, ялтанд нийгмийн ажил, үйлчилгээг тодорхой төвшинд үзүүлж байгаа боловч дараах хүндрэлүүд гарч байна. Үүнд:

Мэргэжлийн бус сургууль төгссөн боловсон хүчин хорих байгууллагын нөхцөл байдлын талаар болон сэжигтэн, яллагдагч. ялтантай хэрхэн харьцах сэтгэл зүйн бэлтгэл төлөвшөөгүй байдгаас тэр бүр орчиндоо дасан зохицож тогтвор суурьшилтай ажиллаж чаддаггүй

› Хууль эрх зүйн шаардлагын түвшинг хангасан мэдлэггүй байдал нь нийгмийн ажилтнуудын нэр хүндийг унагадаг. /ялтнууд бүгд нийгмийн ажилтнаас хуулийн зөвлөгөө хүсдэг гэвч өгч чаддаггүй/

› Төрийн тусгай албаны бие бялдрын бэлтгэлжилт. бие хамгаалах чадвар эзэмшээгүй.

› Ялтан оргох, үймээн самуун гаргах, бусдыг барьцаанд авах, хорлон сүйтгэх зэрэг онцгой нөхцөл байдал үүссэн үед хэрхэн ажиллах талаар хичээл үзэж судлаагүй байдаг.

› Онцгой учралын үед харуул хамгаалалтыг хэрхэн зохион байгуулах арга, ажиллагааны талаар мэдлэггүй байдаг зэрэг нь хорих байгууллагад мэргэжлийн болон мэргэжлийн бус боловсон хүчин тогтвор суурьшилтай ажиллахгүй байх нэг үндэслэл болж байна. Тухайлбал:

Аюулгүй байдлын албаны ажилтан, албан хаагчдын сүүлийн 6 жилд албан тушаалаас чөлөөлөгдсөн буюу халагдсан судалгаа

д/д	Төрөл	2006	2007	2008	2009	2010	2011
1.	Албанаас чөлөөлөгдсөн буюу халагдсан албан хаагчид	159	194	110	86	100	108

Жишээ нь: 2010 онд хорих анги, цагдан хорих байранд 89 нийгмийн ажилтан ажиллаж байснаас мэргэжлийн мэдлэг, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл дутмаг байдлаас болж 15 албан хаагч өөрийн болон захиргааны санаачлагаар ажлаас чөлөөлөгдсөн байна.

Хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд мэргэжлийн сэтгэл зүйч ажилласнаар ялтан, хоригдогсдын сэтгэл зүйн байдлыг тодорхойлсны үндсэн дээр тэдгээрийн сэтгэл зүйн онцлог байдалд сэтгэл зүйн оношлогоо, үнэлгээ хийх, сэтгэл зүйг тогтворжуулах орчинг бүрдүүлж, сэтгэл зүйн дарамт, стрессээс гарахад нөлөөлөх, нөхөн сэргээх, сэтгэл заслын тусламж үзүүлэх замаар сэтгэл зүйн мэргэжлийн үйлчилгээ үзүүлж гэмт явдлаас татгалзуулах чухал нөлөөтэй юм.

Сэтгэл зүйч нь хоригдогч, ялтан гэмт хэрэг үйлдэх санаа, бодлоосоо татгалзах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хор уршгийг ойлгуулах, нийгэмд учруулсан хохирлоо нөхөн төлөх, үйлдсэн гэмээ ойлгож ухамсарлах эрх чөлөөт амьдралд ажиллаж амьдрах, харилцааны соёл эзэмших боломжийг олгох байнгын зөвлөгч болох ёстой юм.

ШШГБайгууллагад өнөөдрийн байдлаар сэтгэл зүйч албан тушаалд тогтоосон нормативын хүрээнд 100 ажилтан ажиллахаас 24 алба хаагч ажиллаж байна. Үүнээс сэтгэл зүйч мэргэжилтэй 20, мэргэжлийн бус 4 албан хаагч ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгуулагын хэрэгцээ, шаардлагыг харгалзан сэтгэл зүйч ажилтныг ял эдлүүлэх ажиллагаанд мэргэжилтнээр оролцох, тухайлбал: сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих шүүгчийн шийдвэр, ялтныг хорих ял эдлүүлэх явцад тулгарч байгаа орчинтойгоо дасан зохицох чадвар, гэм буруугаа хүлээн зөвшөөрч байгаа шинж, нийгэм, сэтгэл зүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх үндсэн үүрэг бүхий мэргэжлийн сэтгэл зүйч бэлтгэх шаардлага байгааг харуулж байна.

Ялтнууд алба хаагчдын амь биед халдах, нийтээрээ албаны үйл ажиллагааг эсэргүүцэж суулт зохион байгуулах, өлсгөлөн зарлах явдал сүүлийн үед гарч эхэлсэн нь хорих байгууллагад нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болзошгүй байгаа учир шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын аюулгүй байдлын ажилтнуудыг мэргэшүүлэх, чадваржуулах шаардлага туйлын чухал байна.

Аюулгүй байдлын албаны ажилтнууд хорих болон цагдан хорих, баривчлах байрны хэвийн үйл ажиллагааг хангах, хоригдож буй этгээдүүдэд хууль, журмыг сахиулах, тэдэнд зохих журмын дагуу арга хэмжээ авах, тэдний аюулгүй байдлыг хангах үндсэн үүргийг гүйцэтгэнэ.

Энэ байдал нь хорих байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, аюулгүй байдлын ажилтныг тусгайлан бэлтгэж, ял эдлүүлэх ажиллагаанд мэргэжилтнээр оролцох, тухайлбал: хоригдогч, ялтныг ял эдлэх болон хоригдох явцад тулгарч буй нийгэм, сэтгэл зүйн болон орчны хүчин зүйлээс шалтгаалсан бэрхшээлийг даван туулахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих шүүгчийн шийдвэр, ялтныг хорих ял эдлүүлэх явцад тулгарч байгаа орчинтойгоо дасан зохицох чадвар, гэм буруугаа хүлээн зөвшөөрч байгаа шинж, хоригдогч нарын зүгээс гаргаж болзошгүй гэмт санаа бодолд зөв үнэлэлт өгч түргэн шуурхай шийдвэр гаргаж, асуудлыг хуулийн хүрээнд

шийдвэрлэх чадвар эзэмшүүлэх шаардлага байгааг харуулж байна.

Үүнээс үндэслэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажил-эрх зүй болон дээрх гурван мэргэжлээр шинээр индекс авч, 120-128 багц цагийн агууламжтай, бакалаврын зэрэг олгох сургалтын мэргэжлийн стандарт, мэргэжилтний загвар, сургалтын төлөвлөгөөний задаргааг боловсруулж, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий газрын холбогдох мэргэжилтнүүд болон мэргэжлийн хүлээн зөвшөөрөгдсөн эрдэмтэн, мэргэжилтний санал дүгнэлтийг авч тусгасан болно. Суралцах хугацааны багц цаг нь сонсогч оюутныг өдөрт танхимын 6-аас илүүгүй цагийн ачаалалтай байлгаж, бие даан суралцах, өөрийгөө нээн хөгжүүлэх боломжийг олгоход чиглэгдсэн.

Сургалтын баримт бичгүүдийг боловсруулахад баримталсан гол үзэл баримтлал нь бакалаврын зэрэг олгох сургалтын хугацаанд судлах нийт багц цагийн 30 хувь нь дээд боловсролын суурь, 40 хувь нь мэргэжлийн суурь, 30 хувь нь мэргэшүүлэх хичээл байхаар төлөвлөсөн. Шинээр авсан мэргэжлийн индекс нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажил-эрх зүй мэргэжлийн бүл дотор хамаарах учир мэргэжлийн суурь хичээлийн 70 хувь эрх зүйн, 30 хувь нь мэргэжлийн хичээл эзэлж байгаа бол, мэргэшүүлэх хичээлийн 30 хувь эрх зүй, 70 хувь нь мэргэжлийн хичээл байгаа. Сургалтын агуулгын 62,5 хувийг танхимын сургалтаар, үлдсэн агуулгыг сонсогч, оюутан өөрөө бие даан суралцах боломжийг олгосноороо шинэлэг талтай сургалтын баримт бичиг болсноос гадна ажлын байран дээрээ хөрвөх чадвартай боловсон хүчин бэлтгэхийн нэгэн утга учир оршино.

Орчин үеийн их, дээд сургууль нь эрдэм шинжилгээ, сургалтын ажил эрхлэхийн зэрэгцээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахад анхаардаг болсон байна. Энэ хандлага нь зах зээлээ мэдэрсэн, эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалт, эрдэм шинжилгээ судалгаа, үйлдвэрлэл, үйлчилгээг хэрэгжүүлэхэд боловсролын байгууллагын менежмент, санхүү, хүний болон материаллаг нөөцийг чиглүүлэх асуудлыг өөртөө багтаахын хамт, сургалтын технологийн шинэчлэл, өөрчлөлтийг агуулж байдаг.

Сургалт нь зөвхөн мэдлэг чадвар олгох үйл явц гэсэн үндэслэлээр дээд боловсролын сургалтын байгууллагад ажиллагчдын ихэнх нь мэргэжлийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх нь хамгийн чухал гэж ханддаг. Хүнд үүнээс гадна олон талын мэдлэг, чадвар хэрэгтэйн зэрэгцээ бие хүний тодорхой шинж чанарууд бүрэлдэн төлөвшсөн байх шаардлагатай. Боловсрол бол мэдлэг олж авах, хийж бүтээх, бусадтай хамтран ажиллах, амьдрах, хүний ёсоор оршиход суралцах юм. Их дээд сургуульд суралцагчдад мэргэжлийн мэдлэг чадвараас гадна бие хүн болон төлөвшихөд онцгой шаардлагатай өөртөө итгэх, сэтгэлийн хөдөлгөөнөө зохицуулах, бусдыг мэдэрч ойлгох, холбоо тогтоох, харилцах, стрессээ зохицуулах, бүтээлчээр сэтгэх, асуудлыг олж харах, зөв шийдлийг тодорхойлох, шийдвэрлэх, шүүмжлэлтэй сэтгэх, төлөвлөх шиидвэр гаргах, өөрийгөө хөгжүүлэх, мэдээллийг эрж хайх, олох, хэрэглэх, цагийн болон хувийн менежмент сайтай байх, мэргэжлийн боловсрол, ур чадвар, гадаад хэл болон мэдээлэл харилцааны технологийн

боловсролоо байнга дээшлүүлэх, аливаад өөрийн байр сууринаас хандах зэрэг хэрэгцээ шаардлага байдгийг анхаарах нь өнөөгийн дээд боловсролын шинэчлэлийн тулгамдсан асуудал юм. Энэ нь сургалтын агуулгыг шинэчлэх нэн тэргүний шаардлага байгаагийн илрэл болж байна. Өөрөөр хэлбэл, боловсролын хэрэгцээнд тулгуурлах, үйлдвэрлэлтэй холбох, үйл ажиллагааны эргэлтэнд оруулах нь зайлшгүй байна.

Сургалтын агуулгыг тодорхойлох хоёр хандлага байдаг.

Нэг дэх хандлага нь мэдлэг хүнээс илүү үнэ цэнэтэй гэж үзэх хандлага. Агуулгад онолын тал давамгайлах, дундаж суралцагчид зохирсон агуулгыг чухалчилдаг. Энэ хандлагаас орчин үед аль болохоор татгалзаж байна.

Хоёр дахь хандлага нь бие хүнд чиглэсэн хандлага буюу хүн өөрийнхөө оюун санааны, соёлын болон амьдралын хэрэгцээг хангах зорилгоо биелүүлэх бололцоотой байх, боловсролын орон зайд өөрийгөө хөгжүүлэх боломжийг олгох агуулгыг багтаасан байдаг.

Сургалтын агуулгыг бүтцээр нь шугаман, өргөжин тэлэх, ороомог, холимог гэж ангилдаг. Шугаман бүтэц сонгосон үед сургалтын агуулгын саланги хэсгүүд нь тасралтгүй дэс дараалалтай, хоорондоо нягт холбоотой хэсгүүдийг үүсгэн сургалтын хугацаанд нэг л удаа судлагдана. Ийм бүтэц сонгосон үед дэс дараалал, түүхэн, тогтолцоот, хүртээмжтэй байх зарчмыг хангасан байх ёстой. Энэ бүтцээр түүх, хэл, соёл урлаг зэрэг хичээлийн агуулгыг боловсруулах хандлага байна.

Өргөжин тэлэх бүтэц сонгосон үед судалж буй агуулгаа дахин эргэж үздэг. Нэг асуулт нэлээд олон удаа давтагдаж, түүний агуулга нь үргэлж шинэ зүйл уялдаа холбоо, харилцан хамаарлаар сэлбэгдэж байдаг, хялбараас гүнзгий рүү шилжих байгалийн ухааны хичээлийн агуулгыг боловсруулдаг.

Ороомог бүтэц сонгосон үед суралцагчид нь судалж буй асуудлаа орхилгүй түүнийг байнга гүнзгийрүүлэн, түүнтэй холбоотойгоор мэдлэгээ тэлж байдаг нийгмийн ухааны хичээлийг агуулгыг боловсруулах нь нийтлэг байдаг.

Холимог бүтэц нь дээрх бүтцүүдийн нэгдэл бөгөөд агуулгыг тогтоохдоо шугаман, өргөжин тэлэх, ороомог бүтцийг зохицуулан хэрэглэх бөгөөд агуулгын бие даасан хэсгүүдийг янз бүрийн аргаар илэрхийлдэг.

Их сургуулийн “ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ-СУРГАЛТ-ҮЙЛДВЭРЛЭЛ буюу ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ-СУРГАЛТ” гэсэн үйл ажиллагааны хэв шинжтэй байх хуулийн заалт, нийгмийн эрэлт хэрэгцээ нь ДХИС-ийн сургалтын үйл ажиллагааг салбар шинжлэх ухаан, нийгмийн хөгжлийн чиг хандлага, боловсон хүчин захиалагч байгууллагуудын эрэлт хэрэгцээтэй нийцүүлэн шинэчлэлт хийх шаардлагыг зүй ёсоор тавигдсаны улмаас “СУРГАЛТЫН НЭГДСЭН ТОГТОЛЦОО” судалгааны ажлыг эхлүүлсэн билээ

Сургалтын нэгдсэн тогтолцоо судалгааны ажлын хүрээнд боловсруулагдсан шаталсан сургалтын тогтолцоо нь тус сургуулийн эрдмийн зөвлөлөөр 2012.06.08-нд батлагдсан.

Шинэчлэгдсэн сургалтын нэгдсэн тогтолцоонд шилжиж байгаатай холбогдуулан сургалтын агуулгын шинэчлэлийн орчин үеийн чиг хандлагыг авч үзсэн болно. Сургалтын шинэчлэлийн гол хөдөлгөгч хүч болсон эрхэм эрдэмтэн, багш та бүхэн энэ өчүүхэн зүйлийг анхааран, сургалтын шинэчлэлдээ харгалзан үзнэ гэдэгт итгэж байна.

ХАР ТАМХИНЫ ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНИЙ ХОР ХӨНӨӨЛ

Баатарын Болдбаатар
ДХИС-ийн захирал, доктор,
профессор, цагдаагийн хурандаа



Дэлхий нийтэд 250 сая гаруй хүн хар тамхи, мансууруулах бодисын хэрэглэгчээр бүртгэгдэж, тэдгээрийн дийлэнх нь Азид байна. Хил залгаа орших ОХУ, БНХАУ-ын хувьд ундэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээтэй тэмцэх зорилгоор тусгайлсан алба байгуулан ажиллахад хүрээд байна. Манай улс одоогоос хэдэн жилийн өмнө дамжин өнгөрөгч орны тоонд багтдаг байсан бол одоо хэрэглэгч орны тоонд орж, Азиас гаралтай хар тамхины урсгал, худалдааны гол замууд манай улсыгдайран өнгөрч байна.[1]

1995-2005 онд хар тамхи, мансууруулах бодистой холбоотой мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, хураж авах үйлдэлтэй 63 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд 152 хүн сэжигтэн, яллагдагчаар татагдаж байжээ.

Харин сүүлийн таван жилд энэ төрлийн 26 гэмт хэрэгт 64 хүн ял шийтгүүлжээ. 2007 онд гурван гэмт хэрэгт 16 хүн ял шийтгүүлж байсан бол 2010 онд 14 гэмт хэрэгт 27 хүн ял шийтгүүлжээ.[2] Уг гэмт хэргийн гаралт цаашид ч өсөх хандлагатай байна.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис нь хувь хүний эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн байр суурьт сөргөөр нөлөөлөөд зогсохгүй, хүний удмын /генийн/ санд хор уршиг учруулдаг. Эрүүл мэндийн талаас авч үзвэл хэрэглэгч сэтгэцийн болон биеийн бүрэн хамааралд орж, донтох өвчтэй болсноор хүсэл эрмэлзэл, хэрэгцээ нь зөвхөн мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхэд тэмүүлэх байдлаар солигдож, сэтгэл санааны хоосрол, итгэл, зүтгэлийн эрч хүч нь буурч, ой ухаан доройтож, амархан ядрах, үг даах чадваргүй, бухимдуу, түрэмгий болж сэтгэцийн өвчтэй болдог.[3]

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис анхандаа сэтгэлийн хөөрөл, тайвшрал, амирлангуй байдал бий болгодог талтай. Түүнийг хэрэглэхэд дахин хэрэглэх тэсгэлгүй

---

[1] "Хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх олон практикийн зарим асуудал" илтгэл, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэгдэж буй асуудал" олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. 2012 он, 71 дэх тал.

[2] Улсын Дээд Шүүхийн Судалгааны төвөөс гаргасан судалгааны тайлан, 2012 он

[3] Б.Болдбаатар, Ж.Мөнхболд. мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг ажиллагаа. УБ.,2012. 11 дэх тал

хүсэл төрүүлэхээс авахуулаад туйлын муухай санагдах хүртэл янз янзын нөлөө үзүүлнэ. Эдгээр бодис хүний биеийн бодисын солилцооны үйл явцад оролцоод ирэхээр бие махбодын болон сэтгэл зүйн маш хүчтэй хараат байдал богинохон хугацаанд үүсгэдэг. Хэрэглэгч мансууруулах бодисын хүчээр өөрийн эрхгүй сэтгэлийн тэнцвэрээ алдаж, улмаар уг бодисын үйлчилгээг дахин дахин мэдрэхийг эрмэлзсэнээр бие махбодын болон сэтгэл зүйн хараат байдалд ордог.

Бие махбодын хараат байдал гэдэг нь хэрэглэгч этгээдийн бие махбод мансууруулах бодисгүйгээр хэвийн байж чадахаа болиод уг бодис л байхгүй бол оршин тогтнох, хэвийн амьдрах боломжгүй мэт сэтгэгдэл төрөх шинжүүд тод илрэн, улам даамжрах үйл явц мөн. Энэ нь мансууруулах бодис хэрэглэгчийн бие махбодын бодисын солилцооны нэг хэсэг болсонтой холбоо бүхий бие махбод болон сэтгэл санааны гүн гүнзгий хямрал юм.

Хүний уураг тархин дахь эерэг сэтгэл хөдлөлийн төв мансууруулах бодисын үйлчлэлээр идэвхжсэний дүнд үүсдэг мансууран согтох, хөөрлийн байдлыг үгүйлэн хүсэх байдал нь сэтгэл зүйн хараат байдал бий болох үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг судлаачид туршилт, сорилоор тогтоожээ.

Бие махбод хар тамхи, мансууруулах бодис нэхэх дур хүсэл оргилж эхлэх нь хараат байдлын үндэс болдог. Эдгээр бодисыг нэхэх дур хүсэл маш хүчтэй бөгөөд өлсөж цангах зэрэг амин чухал, юугаар ч сольшгүй хэрэгцээг ч үгүйсгэдэг. Эдгээр бодисыг хэтрүүлж хэрэглээд ирэх үед бие махбодын хамгаалалтын үүрэг бүхий хариу үйлдлүүд алга болно. Тухайлбал, бөөлжис хүрэн дотор муухайрах, огиулах, арьс салст загатнах, хөлрөх, зогьсох, шүлс гоожих, нүд гялалзах зэрэг байдал ажиглагдахаа больж улам гүнзгий автана.[4]

Хар тамхи, мансууруулах бодис хэрэглэж дасал болох үед өөдрөг сайхан сэтгэгдэл төрөх, бүх юм биелэж бүтэх талаасаа төсөөлөгдөж, тайван амгалан, өөртөө итгэлтэй болоход чухал үүрэгтэй эндрофиныг судлаачид "баяр баясгалангийн гормон" гэж нэрлэсэн нь санамсаргүй зүйл биш. Ялангуяа, сэтгэлийн хөөрөл, хайр дурлал, амжилт ололтын агшинд уураг тархи уг бодисыг ихээр боловсруулан гаргадаг нь тогтоогдсон зүйл. Хар тамхи, мансууруулах бодис хэрэглэсний үр дүн болох мансуурал нь хэрэглэгчийн арьсны өнгө цонхийсноор илэрнэ. Сав л хийвэл нойрмоглож, ер бусын их нойртой болно, Удаан сунжруу яриатай болж, ярианы сэдэв, чиглэлээсээ байнга "хоцорно", зан ааш эелдэг зөөлөн, дуулгавартай, анхааралтай болно. Санааширч бодлогоширсон мэт харагдах зэрэг шинж тэмдэг илэрнэ. Хар тамхи, мансууруулах бодисын хараат байдлыг биологийн, сэтгэл зүйн, нийгмийн талаас нарийвчлан авч үзэх шаардлагатай.

Эдгээр бодис эхлээд уураг тархийг аажмаар хөнөөдөг. Уг бодисын мэдрэлийн системийг хордуулах нөлөө тархины холтослог буюу доод гадаргуугийн цөм, харааны товгорын үүсвэрүүд, торлог давхарга, бага тархи болон захын мэдрэлийн судал гэмтэх

---

[4] Мансууруулах эм бодис ба түүний зүй бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэлт. УБ ,2003. 5-6 дахь тал

зэргээр илэрдэг. Өөрөөр хэлбэл, уураг тархи бүхэлдээ гэмтдэг. Уураг тархины хэвийн үйл ажиллагаа алдагдахад хөл саа өвчинд нэрвэгдэх, эсхүл бие тал мэдээгүй болно. Эдгээр бодисын хэтэрсэн хэрэглээ эцэстээ бүх дотор эрхтэн, элэг бөөр, уушиг, зүрхийг гэмтээдэг болохоор нэн аюултай үр дагавар үүсгэдэг. Харааг байдлыг сэтгэцийн талаас авч үзвэл, хэрэглэгчийн сэтгэцэд томоохон өөрчлөлт гарда : Тухайлбал,

а/ сэтгэл санаа хоосролд автдаг;

б/ идэвх зүтгэл, чармайлт, эрч хүч суларч дорэйтно;

в/ эрүүл хүсэл эрмэлзэл, эрэлт хэрэгцээ нь мансууруулах бодист тэмүүлэх сэтгэлгээгээр солигдоно;

г/ ой ухаан муудаж, оюуны хөдөлмөрийн чадвар, үр бүтээл буурна;

д/ сэтгэлд түгшүүр, хямрал, цухалдалт нэмэгдэнэ;

е/ үе үе дүрэлзтэл уурлан, түрэмгий зан авир гаргана;

ё/ сонирхлын хүрээ хумигдаж, шинийг танин мэдэх, хүсэл эрмэлзэлгүй болно;

и/ хийж бүтээх хүсэл үгүй болно;

Хар тамхи, мансууруулах бодисын хараат байдлыг нийгмийн талаас авч үзвэл, дор дурдсан хортой үр дагаварт хүргэнэ: Нийгмийн ашигтай хэлхээ холбоо аажмаар алдагдаж, хэрэглэгч ганцаардаж эхэлнэ. Хараат байдал бүрэлдэн тогтох явцад хэрэглэгчийн үнэт зүйлсийн тухай урьдын үнэлэмж эрс өөрчлөгдөнө. Урьд өмнө нь ач холбогдолтой, үнэ цэнэтэй, хайртай дотно, эрхэмлэдэг байсан бүхэн утга учраа алдана.

Ойр дотны хүмүүстэйгээ тогтоосон харилцаа холбоо аажмаар суларч муудаг төдийгүй тэднээсээ алхам алхмаар хөндийрч хүнийрхүү болно.

Мансуурагч этгээд нь амиа хичээх, бусдыг үл тоомсорлох, ойр дотны хүмүүсээ үзэн ядах, шийдвэргүй, зүрх зориг муутай, өөртөө итгэх итгэлгүй, хүсэл эрмэлзэлгүй, түгжигдмэл байдалтай болох зэрэг сэтгэл зүйн онцлогтой.

Хар тамхи мансууруулах бодисын хараат байдлыг оюун санааны талаас авч үзвэл, хараат байдалд орсон хүн ёс суртахууны ноён нуруугаа бүрмөсөн алддаг. Оюун санааны эрхэм дээд зорилго, амьдралын үнэт зүйлс /бурхан шүтэх, эх орноо хайрлах, хүмүүст санаа тавих, өвчтэй дорой хүмүүсийг өрөвдөх, бодь сэтгэлтэй байх, өөрийгөө бусдын төлөө золиослох/ гэх мэт ойлголт түүний хувьд юу ч биш болж хувирдаг.

Борлуулагч, хэрэглэгч этгээдүүд өөрсдөө хэрэглэж, түүний хамааралд орохоороо мансууруулах бодисыг аль болох ихээр, олон хүнд худалдаж, олсон орлогоороо дахин их хэмжээгээр худалдаж авах, энэ зорилгоор мөнгө олохын тулд гэмт хэрэг үйлдэхэд ч бэлэн болно.

Мансуурагч этгээд нь амиа хичээх, бусдыг үл тоомсорлох, ойр дотны хүмүүсээ үзэн ядах, шийдвэргүй, зүрх зориг муутай, өөртөө итгэх итгэлгүй, хүсэл эрмэлзэлгүй, түгжигдмэл байдалтай болох зэрэг сэтгэл зүйн онцлогтой.

Хар тамхи мансууруулах бодисын хараат байдлыг оюун санааны талаас авч үзвэл, хараат байдалд орсон хүн ёс суртахууны ноён нуруугаа бүрмөсөн алддаг. Оюун санааны эрхэм дээд зорилго, амьдралын үнэт зүйлс /бурхан шүтэх, эх орноо хайрлах, хүмүүст санаа тавих, өвчтэй дорой хүмүүсийг өрөвдөх, бодь сэтгэлтэй байх, өөрийгөө бусдын төлөө золиослох/ гэх мэт ойлголт түүний хувьд юу ч биш болж хувирдаг.

Борлуулагч, хэрэглэгч этгээдүүд өөрсдөө хэрэглэж, түүний хамааралд орохоороо мансууруулах бодисыг аль болох ихээр, олон хүнд худалдаж, олсон орлогоороо дахин их хэмжээгээр худалдаж авах, энэ зорилгоор мөнгө олохын тулд гэмт хэрэг үйлдэхэд ч бэлэн болно.

Мансууруулах бодисын бүрэн хамааралд орсон этгээд тийм бодисыг хэрэглэхгүйгээр байж чадахаа байж, багахан хэмжээний морфин олж авахын тулд эд хөрөнгөө үрэн таран хийх болон юу ч хийхээс буцахгүй болдог онцлогтой. Энэ нь яваандаа илүү хор аюултай хэлбэрт шилжиж, хүний амь бие, өмч хөрөнгийн эсрэг хүч хэрэглэх, хулгайлах, залилан мэхлэх хэлбэрээр гэмт хэрэг үйлддэг.

ХОРИХ АНГИ ДАХЬ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ



Дамдинцэрэнгийн Дамдинсүрэн
Хорих 401-р ангийн дарга,
хурандаа, докторант

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал нь гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нийгмийн аюулгүй, амгалан тайван, тогтвортой байдал болон иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолыг хангахад чиглэгдсэн байдаг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг түвшингээр нь ерөнхий ба тусгай арга хэмжээ гэсэн өөр хоорондоо уялдаа бүхий хоёр хэсэгт хуваадаг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ гэдэгт гэмт хэргийг тэжээж тэтгэх байдаг хямрал болон тогтворгүй байдлыг нийгмийн амьдралаас арилгахад чиглэгдсэн, нийгмийн эерэг хөгжлийг бүхэлд нь ойлгоно. Гэхдээ энэ төрлийн арга хэмжээ нь гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгахад шууд чиглэгдэхгүй, харин нийгмийг бүхэлд нь хөгжүүлэх, эрүүлжүүлэх зорилго бүхий илүү өргөн цар хүрээтэй зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байдаг тул гэмт хэрэгт дам нөлөөлдөг онцлогтой.

Харин гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээ нь гэмт хэргийг гаргахгүй байхад шууд чиглэгдсэн зорилготой байдгаараа ерөнхий арга хэмжээнээс ялгаатай. Тусгай арга хэмжээ нь тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг бууруулах, таслан зогсоох, саармагжуулах, арилгах, тухайн гэмт хэрэг ихэвчлэн гардаг нийгмийн бичил орчинг эрүүлжүүлэх, гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдийг хүмүүжүүлэх мэт асуудлуудыг шийдэхэд буюу "гэмт хэрэгт нөлөөлж байгаа сөрөг хүчин зүйлсийг таслан зогсооход" шууд чиглэгдэнэ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээ гэж, гэмт хэргийн шалтгаан, нөхцөл болон бусад детерминантуудыг илрүүлэх, гэмт хэрэг үйлдэж болзошгүй /гэмт хэрэг үйлдэх зан төлөв тогтсон/ этгээдүүдэд хүмүүжлийн зөв нөлөө үзүүлэх, **төлөвлөж байгаа болон бэлтгэж байгаа гэмт хэргээс сайн дураар татгалзуулахад хүргэх,** эхэлсэн болон үргэлжилж байгаа гэмт хэргийг таслан зогсоох зорилгоор явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг ойлгоно.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ нь тусгай арга хэмжээгээ нөхцөлдүүлдэг. "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ хэр төгс сайн байх тусам тусгай арга хэмжээний "хүрээ" тэр хэмжээгээр бага байна. Иймд тусгай арга

хэмжээний тухай ярихдаа түүнд нөлөөлөх ерөнхий арга хэмжээний асуудлыг мөн хөндөх нь зүйтэй.

Урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой холбоотой үйл ажиллагааныудыг агуулсан өргөн хүрээний арга хэмжээнүүдийн шаталсан тогтолцоо буюу "цогц арга хэмжээ байдаг". Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг болох "гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" гэсэн ойлголт нь тодорхой төрлийн гэмт хэрэг гарахад нөлөөлдөг шалтгаан нөхцөл болон, бусад детерминантыг /тодорхой хүчин зүйл/ илрүүлэх, арилгахад чиглэгдсэн үйл ажиллагааны цогц бөгөөд гэмт хэргийг таслан зогсоох арга хэмжээнээс цаг хугацааны хувьд хамаагүй өмнө буюу гэмт хэрэг гарахаас бүр өмнө эхэлдэг онцлогтой. Харин "гэмт хэргийг таслан зогсоох" арга хэмжээ нь бэлтгэж байгаа болон үйлдэж эхэлсэн, үргэлжилж байгаа гэмт хэргийг таслан зогсооход чиглэгдсэн үйл ажиллагаа юм. ОХУ-ын криминологич эрдэмтэд сэдэж байгаа болон бэлтгэж байгаа гэмт хэргийг гаргахгүй байхад чиглэгдсэн үйл ажиллагааг "гэмт хэргийг арилгах /предотвращение/" гэсэн урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээний бие даасан төрөл болгон гаргаж ирсэн байна.

Хорих газрын пенитенциар /шүүхийн шийдвэрийн дагуу хорих ял эдэлж байгаа газар/ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ олон талтай байдаг. Гэхдээ "хуульд түшиглэсэн, шинжлэх ухааны үндэслэлтэй, гэмт хэрэгтэй хийх тэмцэл нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны шинэ шинэ хэлбэрүүдийг бий болгодог" учир тэдгээрийн бүрэн жагсаалтыг гаргах боломжгүй юм. Харин хорих ангийн эрүүгийн нөхцөл байдалд нөлөөлөх хүчин зүйлүүдийг шинж чанараар нь а/ нийгэм-эдийн засгийн, б/ ёс суртахуун-сэтгэл зүйн, в/хууль зүй-зохион байгуулалтын хэмээн ангилж, улмаар гэмт хэрэг гарах шалтгаан нөхцлийг арилгах, багасгах, саармагжуулах арга хэмжээг тодорхойлж болох юм.

А/ Хорих анги дахь нийгэм-эдийн засгийн шинжтэй сөрөг хүчин зүйлийг арилгах, багасгах, саармагжуулахад чиглэсэн арга хэмжээ нь урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээнд хамаардаг. Энэ арга хэмжээ нь өөрийн зорилго, цар хүрээгээрээ хорих байгууллагыг бүхэлд нь хамрах бөгөөд нэн тэргүүнд хорих байгууллагын санхүүжилт, ангийн хүчин чадалтай холбоотой. Гэхдээ судлагдаж буй асуудлын хүрээнд дээрх арга хэмжээг дараах 2 чиглэлд авч үзэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- Төр буюу дээд байгууллагын зүгээс хорих ял эдлэх нөхцлийг сайжруулах /ахуйн нөхцөл, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах болон бусад/

- Ялтнууд өөрсдөө хөдөлмөр эрхэлсний үр дүнд ахуйн нөхцлөө сайжруулах боломжийг бий болгох

Хорих анги нь үйл ажиллагааныхаа санхүүжилтийг улсын төсвөөс авдаг ч **өөрсдийн явуулдаг үйлдвэрлэлийн үр дүнд /манайхны хэлдгээр дотоод нөөц бололцоо/ зарим**

асуудлуудаа шийдэж ирсэн.

Б/ Ёс суртахуун-сэтгэл зүйн шинжтэй сөрөг хүчин зүйлийг арилгах, саармагжуулахад чиглэсэн арга хэмжээнүүд нь өөртөө урьдчилан сэргийлэх ерөнхий болон тусгай арга хэмжээг аль алийг нь багтаасан цогц арга хэмжээ байх шаардлагатай. Урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээнд, ялтнуудын хүмүүжлийн ажлыг боловсронгуй болгох, тэдний ерөнхий болон мэргэжлийн боловсролын түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүд хамаарна. Харин урьдчилан сэргийлэх криминологийн тусгай арга хэмжээнүүдээс ялтнуудын дунд "гэмт хэргийн ертөнцийн уламжлал, ёс заншил гэж хэлж болох зүйл"-ийг дэлгэрүүлэхгүй байхад чиглэсэн арга хэмжээ ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна. Энэ үйл ажиллагааны гол зорилго нь "гэмт хэргийн орчны үзэл суртал-ёс суртахууны үндэс суурийг үгүй хийхэд" чиглэгдэх ёстой. Энэ зорилго нь дараах асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагааны үр дүнд биелэгдэнэ. Үүнд:

- Ялтанд нийгэм, хууль, хүн, хөдөлмөр зэрэг нийгмийн үнэт зүйлст хүндэтгэлтэй хандах, эдгээр нь нийгэмд хөлөө олох, амьдралын суурь тулгуур гэсэн хандлагыг төлөвшүүлэх,
- Өөрийгөө "нийгмийн хог шаар, эсвэл ийм тавилантай" гэсэн ялтны ухамсарт тогтсон ойлголтыг өөрчлөх,
- Рецедив гэмт хэрэгтнүүдийн "сайхнаар" дүрслэн ярьдаг гэмт хэргийн ертөнцийн бодит үнэн, хор уршгийг ойлгуулах .

а/ Ялтнуудын ухамсарт тогтсон байгаа нийгмийн эсрэг харш үзэл бодлыг өөрчилж, нийгмийн үнэт зүйлст хүндэтгэлтэй хандах зан байдал, ёс суртахууны зөв төлөвшлийг бий болгоход боловсрол, шинжлэх ухаан, урлаг соёл, хэвлэл мэдээллийн хэрэгсэл буюу нийгмийн хөгжлийн түвшин бүхэлдээ чухал нөлөөтэй. Иймд энэхүү үйл ажиллагаанд хорих байгууллагын албан хаагчдаас гадна төр, нийгмийн зүтгэлтнүүд, урлаг соёлын алдартнууд, эрдэмтэд, багш сурган хүмүүжүүлэгчид, төрийн болон төрийн бус байгууллагууд оролцох нь ихээхэн ач холбогдолтой юм. Нийгмийн бусад гишүүдийн зүгээс ялтны дунд явуулах хүмүүжлийн ажилд оролцох эрх зүйн үндсийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 124-р зүйлийн 124.2-т тодорхойлсон байдаг.

б/ Ялтанд тогтсон өөрийгөө "нийгмээс тусгаар этгээд" гэсэн үзэл бодлыг нь өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагаа нь 2 чиглэлд явагдах ёстой. Эхнийх нь гэмт хэрэгтнийг хорих газарт ял эдэлж байх хугацаанд нь өөрийгөө "нийгмийн хог шаар" гэж бодох ойлголтыг нь өөрчлөх, хоёр дахь нь ялаа эдэлж суллагдсаны дараа тэднийг нийгэмшүүлэх гэсэн зорилгыг агуулна. Эдгээр үйл ажиллагаа нь цогцоор, НҮБ-аас баталсан "Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд"-д /Наад захын жишиг дүрмүүд- НЗЖД/ тусгагдсан "Хоригдлуудтай харилцахдаа, тэдний нийгмээс тусгаарлагдсан байдлыг нь биш, харин тэд нийгмийн гишүүн хэвээрээ байгаа гэдгийг тодотгож харьцах хэрэгтэй" /Дүрэм-61/

гэсэн реинтеграцийн зарчимд нийцсэн байх ёстой. Энэ зарчим ангуулга нь "хоригдлуудыг нийгмийн амьдралд буцааж оруулахад олон нийтийн байгууллагууд, хорих байгууллагын хамтын ажиллагаа шаардлагатайг тодорхойлсон байна

Ялтнуудын дунд үйлчилдэг "шоронгийн уламжлал, заншил", "бичигдээгүй хууль", "овгоруудын хууль" зэргийг дэлгэрүүлэхийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ мөн чухал үүрэгтэй. Хууль гэхээсээ илүү манай нөхцөлд дэг жаяг гэвэл илүү тохиромжтой болов уу. Олон жил ял эдэлсэн, гяндан онцгой дэглэмээр дамжсан бол илүү эрх ямба эдлэх эрхтэй ч гэх юм уу, эсвэл хүнд зүйл ангитай бол бусдаас илүү байр сүүрьтай байна гэх ойлголтыг байхгүй болгох, багасгах арга хэмжээнүүдийг авах нь зүйтэй. Зорилго нь рецедив гэмт хэрэгтнүүд, ялангуяа тэдний дундах толгойлогчдын бусдад нөлөөлөх нөлөөллийг багасгахад /нэр хүндийг багасгах/ чиглэгдэх ёстой. Энэ үйл ажиллагаа дараах 2 чиглэлд явагдах нь зүйтэй. Үүнд:

- Хорих ангийн ажилтнуудын зүгээс ялтны дунд тусгайлсан хүмүүжлийн ажил явуулах,
- Ялтнуудын дундах овгор, толгойлогчдын нэр нөлөөг багасгахад чиглэсэн гүйцэтгэх ажлын арга хэмжээ зохиох.

Хэрвээ эхний үйл ажиллагааны чиглэл нь сэрэмжлүүлэх */предупреждения/* криминологийн тусгай арга хэмжээнд хамаарах бол хоёр дахь арга хэмжээ нь урьдчилан сэргийлэх */профилактический/* шинжтэй ба гэмт хэргийг арилгах */предотвращения/*, цаашилбал түүнийг таслан зогсоох үйл ажиллагаатай нягт холбоотой. Энэ үйл ажиллагааны субьект нь хорих ангийн удирдлага, албан хаагчид тэр дундаа хорих ангийн гүйцэтгэх алба байна.

Хорих газарт гэмт хэрэгтнүүдийн холбоо сүлбээг зохион байгуулалтын хэлбэрт оруулахаас сэргийлэхэд чиглэсэн хууль зүй-зохион байгуулалтын арга хэмжээ нь ялтнуудын дунд гэмт хэрэгтнүүдийн "бичигдээгүй хууль"-ийг дэлгэрүүлэхээс сэргийлэх, тэдэнд тусгайлсан хүмүүжлийн ажил зохиоход таатай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор гэмт хэрэгтнүүдийн дундах овгор, толгойлогчид, тэдний гар хөл бологсдыг бусад ялтнуудаас тусгаарлахад чиглэнэ. Энэ арга хэмжээ нь зохих хууль тогтоомжид үндэслэгдэж явагдах нь тавьсан зорилгодоо хүрч эрэг үр дүн гаргах баталгаа болох тул, энэ чиглэлээр эрүүгийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал эрх зүйн шинжтэй урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамаарна гэж үзэж байна.

Пенитенциар гэмт хэрэгтэй тэмцэх чухал хэрэгсэлд /арга/ ялтнуудын гаргасан зөрчил бүрт цаг тухайд нь, зохих ёсоор хариуцлага тооцох сайн боловсруулж төлөвлөсөн сахилгын механизм ихээхэн үүрэгтэй. Ялтанд хүлээлгэх сахилгын хариуцлага нь тухайн хүний гаргасан сахилгын зөрчил, гэм буруу, учруулсан хохирол зэрэгтэй уялдах

ёстойгоос гадна хүмүүжлийн шинжтэй байх нь ач холбогдолтой. Үүнтэй холбоотойгоор хорих байгууллагын албан хаагчдын сурган хүмүүжүүлэх болон сэтгэл зүйн ур чадварыг дээшлүүлэх асуудал чухал юм. Хорих байгууллагын албан хаагчид ялтан хоорондын болон "гал" хоорондын харьцааны зөрчилдөөнтэй байдлыг зөв оношилж, хурцадмал байдлыг зөөлрүүлэх, гэмт хэрэг гаргахад хүргэж болзошгүй нөхцөл байдлыг хязгаарлахад шаардлагатай мэдлэгтэй байх ёстой байдаг. Түүнчлэн шаардлагатай тохиолдолд дээрх зорилгоор гүйцэтгэх ажлын арга, хэрэгслийг ашиглаж болно.

Ялтнуудын дунд сахилга бат, дэг журмыг бататгах, зөрчилдөөнтэй байдлыг шийдвэрлэх, гэмт хэрэг, зөрчил гарахаас сэргийлэхэд өөрийн үзэл бодол, зан байдлаараа засарч хүмүүжиж буйгаа харуулж буй ялтнуудын сайн дурын байгууллагыг дэмжих, хөгжүүлэх арга хэмжээ их ач холбогдолтой гэж үзэж байна.

Хорих газарт гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа нь эрүүгийн хариуцлага буюу ял шийтгэл ногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд үүсдэг эрүүгийн эрх зүйн харилцааны хүрээнд хэрэгждэг. Иймээс урьдчилан сэргийлэх ихэнх арга хэмжээ эрүүгийн, эрүүгийн байцаан шийтгэх болон шүүхийн шйидвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжоор тогтоосон үндэслэл, журмаар хэрэглэгддэг. Хорих ангийн удирдлагаас хэрэглэж болох эрүүгийн эрх зүйн нөлөөллийн арга хэмжээний хамгийн боломжтой нь эрүүгийн хууль тогтоомжийн сурталчилгаа юм. Энэ арга хэмжээ ялтнуудад Монгол улсын Эрүүгийн хуулинд тусгагдсан үйлдэл, эс үйлдэхүйн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг буюу төр иргэдээ буруу зүйл хийхээс сэрэмжлүүлж, тэднийг үүсч болох хүнд үр дагавраас хамгаалж байгаа гэдгийг мэдээлж тайлбарлахад оршино.

Монгол улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн зарим зүйл заалт, тухайлбал зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэг байгуулсаны төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 37-р зүйлийн 37.2, онц аюултай гэмт хэрэгтэнд тооцох нөхцөлийг тодорхойлсон 24-р зүйлийн 24.1, шүүхээс ял оногдуулахдаа харгалзан үзэх хүндрүүлэх нөхцөл байдлыг тодорхойлсон 56-р зүйл зэрэг олон заалтууд урьдчилан сэргийлэх шинж чанартай.

Сэрэмжлүүлэх нөлөөтэй дараагийн хууль бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 127-р зүйлийн 127.1-д хууль тогтоомж, хорих ангийн дэглэм, журмыг зөрчсөн ялтанд хүлээлгэх сахилгын шийтгэлийн төрлүүдийг тодорхойлсон. Мөн 127-р зүйлийн 127.6-д зааснаар сахилгын зөрчил гаргасан ялтны хорих ял эдлүүлэх дэглэмийг чангаруулах боломжтой .

Хорих байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтад хийсэн дүн шинжилгээ эрүүгийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжийн суртал ухуулга нь ялтнуудыг хэрэг зөрчил гаргахаас татгалзахад нөлөөлөх чадвартай нийтлэг урьдчилан сэргийлэх болон нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хэрэглэгддэг байна.

Хорих байгууллагын зүгээс ялтнуудын дунд хууль тогтоомжийг тайлбарлан

ойлгуулахдаа ялтнуудын өөрсдийн оролцоо, тэдний мэдэх практик жишээнд тулгуурлах нь ихээхэн үр дүнтэй байна. Энэ нь нэг талаас урьд нь засрашгүй этгээд гэж үздэг байгаад хорих ангийн зүгээс явуулсан хүмүүжлийн ажлын үр дүнд засарч хүмүүжиж байгаа ялтнууд, хууль дүрмийг сахин биелүүлсэний үндсэн дээр хугацаанаасаа өмнө суллагдсан ялтан, эсвэл ялаа эдэлж дуусахаас хэдхэн сар, хоногийн өмнө эрүүгийн хариуцлагад дахин татагдсан ялтны асуудал зэрэг тогтоосон хууль дүрмийг сахин биелүүлэх нь тухайн хүнд илүү үр өгөөжтэй гэдгийг практикаар нотлох боломжтой жишээ баримтуудад тулгуурлан явуулахад зохимжтой байна.

Гэхдээ хууль зүйн урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүн хууль тогтоомжийг тайлбарлан ойлгуулах суртал ухуулгаас гадна, тэрхүү хууль дүрмийг амьдралд хэрхэн хэрэгжүүлж байгаагаас ихээхэн хамаарна гэдгийг мартахгүй байх нь чухал юм. Өөрөөр хэлбэл бодит байдалд хэрэг зөрчил гаргасан ялтанд хууль дүрмийн дагуу зохих хариуцлагыг хүлээлгэхгүй орхих нь ялтнуудын зүгээс хууль дүрэм нь зөвхөн "айлгах" чанартай буюу цаасан дээр л байдаг зүйл гэж үл тоох байдал үүсэх үндэслэлтэй.

Албан ёсоор анхааруулах арга хэмжээ нь хорих ангийн удирдлагын зүгээс гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр санаархаж байж болзошгүй ялтанд гэмт хэрэг үйлдэхээс татгалзах, гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хүлээх эрүүгийн хариуцлагын тухай сануулахыг ойлгоно.

Албан ёсны анхааруулах арга хэмжээ нь нийгэмд, тэр дундаа гэмт хэрэг үйлдсэн гэмт хэрэгтнүүдийг нийгмээс тусгаарлах зориулалт бүхий хорих ангид тэр бүр гэмт хэрэг гарахаас сэргийлж, гэмт хэрэг үйлдэх санаархлаас татгалзуулж чадахгүй нь ойлгомжтой. Гэхдээ энэ арга хэмжээ багахан хэмжээний буюу цөөн ч гэсэн ялтан хорих ангид гэмт хэрэг үйлдэхээс татгалзсан эерэг үр дүн гарахад л хангалттай бөгөөд хорих ангийн удирдлага, албан хаагчдын хийдэг ажлыг илүү хууль зүйн үр дагавартай болгоно.

Гэмт хэрэг үйлдэхээс сайн дураар татгалзахад хүргэх арга хэмжээ үр дүнтэй байх нь олон нөхцөл байдлаас шалтгаална. Энэ арга хэмжээ нь бүртгэгдэхгүй тул тэдгээрийн тоон үзүүлэлтийг гаргаж дүн шинжилгээ хийх боломжгүй байна. Хорих ангиудын албан хаагчидтай ярилцаж байхад ойролцоогоор тэдгээрийн 10 орчим хувь нь хэрэг зөрчил гаргахаас сайн дураар татгалзахад хүргэх арга хэмжээг практикт хэрэглэж үр дүнд хүрч байсан тухай ярьсан. Гэхдээ ихэнх тохиолдолд энэ үйл ажиллагаа хэлбэрийн төдий явагддаг сул талтай.

Гэмт хэрэг үйлдэхээс сайн дураар татгалзахад хүргэх арга хэмжээний агуулга нь сэтгэл зүй-сурган хүмүүжүүлэх нөлөөллийн арга хэрэгслийн үндсэн дээр гэм буруутай үйлдлээ туйлд нь хүргэхээс татгалзахад хүргэх зорилгоор гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж буюу завдаж буй этгээдийн сэтгэл зүйд нөлөөлөхөд оршино.

Пенитенциар гэмт хэрэг үйлдэхээс сайн дураар татгалзахад хүргэх арга хэмжээ нь ихэвчлэн гүйцэтгэх ажлын нөлөөллийн арга хэмжээний тусламжтайгаар зөрчил

гаргагч ялтан болон түүний ойрын хүрээллийн хүмүүс руу чиглэгдэж хэрэгждэг. Хорих ангийн албан хаагчид ойр дотны хүмүүс /энд ялтантай хамт хорих ял эдэлж байгаа дотно харилцаатай бусад ялтан мөн хамаарна/, найз нөхөд, гэр бүлээр нь дамжуулж / тэдэнд мөн сэтгэл зүй- сурган хүмүүжүүлэх нөлөөллийн арга хэмжээ хэрэгжүүлсэний үндсэн дээр/ зөрчил гаргагчид нөлөөлж гэмт хэрэг үйлдэхээс сайн дураар татгалзахад хүргэх боломжтой бөгөөд энэ нь зөрчил гаргагчид төдийгүй нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан түүний ойр дотны хүмүүст мөн гэмт хэрэг үйлдэхээс татгалзахад хүргэх эерэг үр дагавартай гэж үзэж байна.

Пенитенциар гэмт хэрэг үйлдэхээс сайн дураар татгалзахад хүргэх арга хэмжээг урьдчилан сэргийлэх ярилцлагын хэлбэрээр явуулж болох юм. Энэ ярилцлагыг гэмт хэрэг үйлдэхээр санаархаж байгаа ялтан төдийгүй түүнд эерэгээр нөлөөлж чадах бусад хүмүүстэй хийх боломжтой.

Хорих ангийн гүйцэтгэх алба нь бэлтгэгдэж байгаа болон үйлдэхээр завдаж байгаа гэмт хэргийг эрт үед нь илрүүлэх үүрэгтэй. Одоогийн байдлаар ийм нөхцөл байдалд ихэнх тохиолдолд гэмт хэрэг үйлдэхээс сайн дураар татгалзахад хүргэх арга хэмжээг биш, харин гэмт хэргийг таслан зогсоох арга хэмжээг хэрэгжүүлдэг байна. Хорих ангийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны үр дүнг таслан зогсоосон болон илрүүлсэн гэмт хэргийн тоон хэмжээтэй шууд уялдуулж тооцдог, гарахаас сэргийлж чадсан гэмт хэргийн тоон үзүүлэлтийг тооцож гаргах боломжгүй өнөөгийн практикт хорих ангийн албан хаагчдын үйл ажиллагааг буруутгах аргагүй юм. Гэхдээ гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх зорилгын хүрээнд тодорхой тохиолдолд, гэмт хэргээс сайн дураар татгалзахад хүргэх арга хэмжээг хэрэглэх боломж байгаа эсэхийг харгалзан үзэх нь зүйтэй гэж бодож байна.

Бидний үзэж байгаагаар хорих байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь хөнддөг, нилээн төвөгтэй, олон талт арга хэмжээ болох пенитенциар гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх, таслан зогсоох асуудлыг гүнзгийрүүлж судлах зайлшгүй шаардлагатай.

Пенитенциар гэмт хэрэг, түүний шалтгаан, нөхцлийг арилгах, урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэргийг таслан зогсоох, хязгаарлах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, хууль тогтоомжид тулгуурлах нь гарах үр дагаварт нь эерэгээр нөлөөлөх ач холбогдолтой гэж үзэж байна.

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛГААНД ДАХЬ ЯЛТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЗАРИМ АСУУДАЛ



Одонхорлоогийн Батсайхан
ШШГС-ийн багш ахмад

Амьдралын [illegible]аялагийг үйлдвэрлэхэд чиглэгдсэн хүмүүсийн үйл ажиллагааг бид хөдөлмөр гэж нэрлэдэг. Нийгмийн амьдралд хүнийг бүх талаар нь төлөвшүүлэн хөгжүүлэх, амьдрах боломж нөхцлийг нь дээшлүүлэхэд хөдөлмөр чухал хүчин зүйл болдог нь зах зээлийн эдийн засгийн тогтолцооны өнөө үед улам тодорхой болж байна. Хөдөлмөрийн явцад хүндэвтэр буюу хөдөлмөрийн бэрхшээлийг давах чадвар, хүч, энерги, идэвх санаачлага, тэсвэр хатуужил, зориг эрмэлзэл, мөн хамт олон ч чанар хувийн сонирхолд захируулах чадвар зэрэг зоригийн шинжүүд төлөвшин тогтож зан төлөвт угшсан сөрөг шинжүүд шахагдан арилах замаар эерэг уур амьсгал үүсэх үндэслэл бий болдог. Тохиолдлын шинжтэй хөдөлмөр ялтныг хүмүүжүүлэх биш улам залхааж харин тодорхой нөхцөлд зохиогдсон зөв зохион байгуулалттай хөдөлмөр ялтныг хүмүүжүүлэх зөв хэрэглүүр болж сая чадна. Хорих ял эдлүүлэх үйл ажиллагааг нийгмийн хөгжлийн чиг хандлага, эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан, ялтныг нийгэмшүүлэх ажиллагаанд хөдөлмөрийн оролцоог өргөжүүлэх, хөдөлмөрийн хүмүүжлийн үр нөлөө ялтанд хэрхэн нөлөөлж байгаад үнэлэлт дүгнэлт өгч үүргээ хангалттай биелүүлсэн, ямар нэг сахилгын зөрчил гаргаагүй ялтнуудыг хөхүүлэн дэмжиж ажиллахыг боловсронгуй болгох шаардлага тавигдаж байна.

Монголын төр гэм буруутай этгээдийн хэргийг шүүн хэлэлцэхдээ төрт ёсоо дээдлэн ялд унагаж түүний ялыг эдлүүлж ирсэн өнө эртний түүхтэй. 1924-11 сард хуралдсан Улсын анхдугаар их хурал, мөн онд хуралдсан МАН-ын 3-р их хурлаас Монгол улсын хорих ял эдлүүлэх байгууллагын практик үйл ажиллагаа эрх зүйн зохицуулалтын үндсэн чиглэл зарчмыг тодорхойлж өгсөн байна.

Тухайлбал: Гянданд хоригдож бүхий хэрэгтэн ардыг үйлдвэрт сургах, сургаж гэгээрүүлэх, аливаа шүүхийн тогтоолгүйгээр хэнийг ч хорихгүй байх, гяндан хорооны байдал нэн муу байгааг даруй сайжруулах насанд хүрээгүй хөвгүүд охид хэрэгт холбогдох аваас гянданаа хорихгүйгээр гэгээрүүлэх, аливаа хэрэгтэн ардын дотроос хүн төлөв засрах байдалтайгий нь гянданаа хорихгүйгээр үйлдвэр хийлгэвэл зохих зэргийг онцлон заажээ. Эндээс үзэхэд Монгол улсад хорих ял эдлүүлэх байгууллага анх үүссэн цагаасаа гэм буруутай этгээдийн эрхийг хүндэтгэн, хорихоосоо урьтаж хөдөлмөрөөр хүмүүжүүлэх тэдэнд мэргэжил эзэмшүүлэх хөдөлмөрийн дадлага олгох ажил эрчимтэй

зохиогдож байсан түүхэн баримтууд олон байна. Тухайлбал: 1966, 1993, оны хуулиудад" ялтныг албадан хөдөлмөрлүүлэх," 1981 оны хуульд "ялтан заавал хөдөлмөрлөх", 1996 оны хуулинд "хорих байгууллага ялтныг албадан хөдөлмөрлүүлж, эрхэлсэн үйлдвэрийн чиглэлээр түүнд дадлага олгох", 2002 оны **"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хууль"**-д "ялтны хөдөлмөрийг хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журамд нийцүүлэн зохион байгуулахаар зааж,жирийн дэглэмтэй хорих ангийн ялтныг хорих байгууллага өөрийн болон хувь нийлүүлсэн, хамтарсан аж ахуйн нэгжид, эсхүл бусад аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан зохих хяналттай ажиллуулах, чанга, онцгой дэглэмтэй хорих ангийн ялтныг хорих анги зөвхөн өөрийн үйлдвэрлэл дээр харуул хамгаалалттай нөхцөлд ажиллууллахаар" тус тус заасан байна

2008-2011 онд "Ялтны гэм хорын хохирол барагдуулалтыг нэмэгдүүлж, талбөр барагдуулалтанд хяналт тавьж ажиллах хөтөлбөр"-ийг ШШГЕГ-ын даргын 2008.10.20-ны өдрийн А/102 дугаар тушаалаар батлуулан үйл ажилллагаандаа мөрдлөг болгон ажилллаж байна.Уг хөтөлбөрийн хүрээнд төлбөртэй ялтныг хугацааны өмнө тэнсэн суллахгүй байх, төлбөртэй ялтныг хөдөлмөрт хамруулах, ажилллагааг явуулж байна. Хорих ангид үйлдвэрлэлийн чиглэлийг 2008 онд шинэчлэн тогтоож өгснөөр нийт ялтны 70-75 % ажлын байраар хангаж, 2010 онд 55-65% нь хорих ангийн аж ахуй үйлчилгээ, хөрөнгө оруулалттай барилга байгууламжинд ажиллаж, тухайн орлогоос хохирогчийн хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг арга хэмжээ авч байна. ШШГЕГ-ын даргын 2010.05.18-ны өдрийн а/37 дугаар тушаалаар "Ялтны хөдөлмөрийн норм, норматив тогтоох болон цалин хөлс тодорхойлох журам"-ыг баталж ялтанд хийсэн хөдөлмөрт нь тохирсон цалин хөлс олгож байна. Ялтныг ажлын байраар хангах, хөдөлмөрийн хүмүүжил бий болгох зорилгоор ялтны хүнсний хэрэгцээний төмс, хүнсний ногоог өөрийн хүчээр тарьж, хэрэгцээндээ хэрэглэж хэвшсэн байна. Мөн 2009 онд "Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв"-ийг байгуулж хорих ангиудаас нийт 300 ялтныг Хоирх 421-р ангид төвлөрүүлэн сургасан байна. Хорих ял эдлүүлэх үйл ажиллагаанд хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг үе үеийн нийгэм улс төрийн онцлогт тохируулан ШШГТухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулж иржээ. Тухайлбал: Социалист бүтээн байгуулалтын үед хөдөлмөрөөр хүнийг хүмүүжүүлнэ гэсэн уриатайгаар мөн төлөвлөгөөтэйгээр хөдөлмөр эрхлүүлж байсан байна. 1990 оноос хойш нийгмийн тогтолцоо өөрчлөгдөж чөлөөт хөдөлмөрийн зах зээлд шилжсэнээр хорих байгууллагын нийгэмд үйлчлэх бүтээлч үйл ажиллагааны хомсдол бий болжээ. Өнөө үед ялтныг хөдөлмөрлүүлэх, хөдөлмөрөөр нь хүмүүжүүлэх ажиллагаа дутагдалтай байна. Хорих анги ялтны дунд хууль, тогтоомж, журмын дагуу сургалт явуулж, хөдөлмөрийн дадлага олгож, хөдөлмөрлүүлж байгаа хэдий ч, эдгээрт хамрагдаж байгаа ялтнууд тооны хувьд бага ажлын байрны хомсдол байсаар байна.

Гадаадын зарим хорих ангиудын хөдөлмөр эрхлэлтийн байдал

ХБНГУ

ХБНГУ-ын Шоронгийн тухай хуулийн зорилго нь хорих ялын нээлттэй хэлбэр ялтныг хэвийн амьдралд эргүүлэн оруулах, хуульд захирагдах, өөрийн үйлдлийн аливаа хариуцлагыг хүлээх, хэвийн ажиллаж амьдрахыг хангаж хариуцахад сургадаг.Тус улсад харьцангуй хөнгөн гэмт хэрэг үйлдсэн цөөн жилийн хорих ялтай ялтнуудыг нийгэмд дасгах, хөндийрүүлэхгүй байх зорилгоор суллагдахаас нь өмнө "нээлттэй" ангид байлгадаг.

Хорих ангийн нээлттэй хэлбэр нь хуанлийн 21 өдрийн өмнөөс, богино хугацааны хорих хэлбэр нь хорих байгууллагаас гадуур өдөрт хэдэн цаг ажил эрхлэх боломж олгодог, харин ажил хөдөлмөр эрхлэх дэглэм нь хорих ангийн хяналтаас гадуур хөдөлмөр эрхлүүлдэг

Хорих байгууллагын захиргаа, нийгмийн ажилтнууд хөдөлмөрийн биржтэй нягт харилцан ажиллаж, аж ахуйн аль чиглэлийн байгууллага өргөжин тэлж байгааг харгалзан тэнд ажиллах мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр сургалтын материаллаг баазыг бүрдүүлж байдаг.

Япон Улс

Япон улс нь "Суллагдагсадад тусламж үзүүлэх тухай", "Шоронгийн тухай хууль" болон бусад эрх зүйн актуудаар энэхүү харилцааг зохицуулдаг байна.

Хоригдлыг хүмүүжүүлэх үндсэн арга хэрэгсэл нь биеийн хүчний хөдөлмөр гэж үздэг. Хоригдлууд нь өдөрт 8, долоо хоногт 44 цаг ажилладаг байна.

Англи улсын Воттон шорон

Воттоны хорих ангид ялтан зөрчил гаргасан тохиолдолд сахилгын байранд хорих ойлголт байдаггүй. Засан хүмүүжүүлэх ерөнхий арга нь биеийн хүчний ажлууд юм. Хөдөлмөр нь заавал албадлагын биш бөгөөд өдрийн нийт ажлын цаг нь 6 цаг байдаг. Хөдөлмөрийн хөлс нь хийснээрээ байдгаараа бусад аль ч шоронгоос ялгаатай. Ялтнуудын үйлдсэн гэмт хэргийн болон хүчирхийллийн хор уршгийг өөрсдөөр нь ойлгуулах зорилгоор байнгын тусгай хичээл, сургалтууд явагддаг.

Оросын Холбооны Улс

ОХУ-ын эрүүгийн ял гүйцэтгэх тухай хууль тогтоомжид зааснаар ялтныг цалин хөлстэй хөдөлмөрт татан оролцуулсан хугацааг улсад ажилласан хугацаанд оруулж тооцох буюу хөдөлмөр эрхэлсэн ялтан жил бүр цалинтай амралт авах эрхтэй. Үүнд хөдөлмөр хүмүүжлийн колонид ял эдлэгсдийн амралтын үргэлжлэх хугацаа ажлын 18 хоног, засан хүмүүжүүлэх бусад байгууллагад ял эдлэгсэд ажлын 14 хоног тус тус цалинтай амрахаар хуульчилжээ: дээрхи орнуудын хувьд ялтныг хөдөлмөр эрхлүүлэх асуудлыг тодорхой

зааж өгсөн байна. Энэ нь :

- Хорих байгууллагаас гадуур хөдөлмөр эрхлэх,
- Хорих байгууллага дотор буюу сулагдахаас өмнө хөдөлмөр эрхлэх
- Гэрээгээр хөдөлмөр эрхлэх гэх мэтчилэн тусгаж өгсөн нь ажил хийлгэх, хөдөлмөр эрхлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна.

Судалж үзсэн гадаадын улсуудад :

- Эрүүгийн хууль тогтоомжоо шинэчлэх
- Хорих ял эдлүүлэх байгууллагын тухай хууль тогтоомжид өөрчлөлт хийх, хоригдлыг ажил хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай баримт бичиг гаргах зэрэг арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

Дүгнэлт

Ялтныг дэглэмийн ялгаагаар ангилж хөдөлмөрлүүлэх үйл ажиллагааг явуулж байгаа нь өнөөгийн нийгмийн шаардлагад төдийлөн нийцэхгүй, ялтныг хөдөлмөрийн үр нөлөөгөөр хүмүүжүүлэх, иргэний амьдралд бэлдэх, мэргэшүүлж дадлагажуулахад болон нийгмийн гишүүн гэдгээ ухамсарлан ойлгоход учир дутагдалтай байдал байсаар байна. Зарим улс оронд яам агентлаг тодорхой төрлийн ажлыг хорих байгууллагын захиргаанд олгох үүрэг хүлээдэг байна.

Жишээлбэл: байгууллагын албан өрөөний тавилга бэлтгэх, эсвэл олон нийтийн байгууллагуудтай харилцан орон гэргүй болон халамжийн төвд зориулан хэрэгцээт эд зүйлийг хийх хэлбэрээр ажиллаж болдог байна. Гадаадын зарим орны туршлагыг авахдаа ялтныг хөдөлмөрлөх, нийгэмд ажиллаж, гэр бүлийнхэнтэйгээ холбоотой байх боломж олгохыг харгалзах. Мөн хорих байгууллагын ажилтнууд ялтныг ажилтай, завгүй байлгах талаар арга замыг эрэлхийлж, бүтээлчээр сэтгэн бодох шаардлагатай юм. Ялтны хөдөлмөр эрхлэлтйиг нэмэгдүүлэх, ажиллах боломж нөхцлийг бий болгох, хөдөлмөрийн үр нөлөөгөөр хүмүүжлийн түвшинг дээшлүүлэхээр ялтны дундаас гарах зөрчил, гэмт хэргийг бууруулахад оршино.

ТАТВАРЫН ӨР БАРАГДУУЛАЛТ, ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ



Хушааны Энхбаатар
ШШГЕГ-ын ШГГ-ын дэд дарга бөгөөд мэргэжлийн удирдлагын хэлтсийн дарга, хурандаа

Татвар төлөх нь хүн бүрийн үүрэг заясан үндсэн үүрэг байхаар Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулан тунхагласан билээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь иргэний, захиргааны болон эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх үүрэг бүхий төрийн байгууллага бөгөөд иргэний, захиргааны хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх Шийдвэр гүйцэтгэх газар, эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх Тогтоол гүйцэтгэх газар гэсэн бүтэцтэй үйл ажиллагаа явуулж байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн хөндөгдсөн эрхийг шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн сэргээх, учирсан хохирлыг арилгах, нөгөө талаас төлбөр төлөгчөөс төлбөр гаргуулах ажиллагааг хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд албадан гүйцэтгэх ажиллагааг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэдэг онцлогтой бөгөөд үүнтэй холбоотой талуудын гаргасан өргөдөл, гомдол, маргааныг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэхэд цаг хугацаа, чирэгдэл багагүй гарч, улмаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад бусдын хууль ёсны эрх, ашиг сонирхолыг хамгаалах, шуурхай, энэрэнгүй байх зарчим цөөнгүй тохиолдолд алдагдаж байгааг үгүйсгэх аргагүй юм.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь нутаг, дэвсгэрийн онцлог нөхцөл байдлаас шалтгаалан тойргын журмаар шүүхийн шийдвэрийг гүйцэтгэдэг бөгөөд улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар нийт 189 тойрогт шийдвэр гүйцэтгэгч ажиллаж байгаагаас нийслэлд 68 шийдвэр гүйцэтгэгч ажиллаж дундажаар орон нутагт нэг шийдвэр гүйцэтгэгчид 118, нийслэлд нэг шийдвэр гүйцэтгэгчид 127 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байна.

Төсвийн орлогыг бүрдүүлэх, татварын өр барагдуулах ажиллагаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага багагүй анхаарал хандуулж, энэ төрлийн шүүхийн шийдвэрийг зохих үр дүнд хүргэх чиглэлээр сүүлийн жилүүдэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Татварын ерөнхий газрын даргын хамтарсан тушаалаар "Ажлын хэсэг" байгуулан,

тусгай төлөвлөгөө гарган хамтран ажилласнаар зохих үр дүнгээ өгч байгаа юм.

Улсын хэмжээнд нийт 12410 гүйцэтгэх баримт бичгийн 157.2 тэрбум төгрөгийн төлбөр, тэтгэлэг барагдуулахаас төрийн байгууллагын нэхэмжлэлтэй 69.3 тэрбум төгрөгийн 1965 гүйцэтгэх баримт бичиг шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаагийн 35.2 тэрбум төгрөгийн 161 гүйцэтгэх баримт бичиг нь татварын байгууллагын нэхэмжлэлтэй байна.

Нийт гүйцэтгэх баримт бичгийн 2.0 хувь, мөнгөн дүнгийн 17.0 хувийг татварын байгууллагын нэхэмжлэлтэй гүйцэтгэх баримт бичиг эзэлж байна.





Татварын байгууллагын нэхэмжлэлтэй нийт өрийн 94.0 хувийг өндөр үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичиг эзлэж байна. Тухайлбал: "Эм Жи Эйч" ХХК 11.0 тэрбум төгрөг, "Жамп" ХХК 6.7 тэрбум төгрөг, "Монгол газар" ХХК 4.8 тэрбум төгрөг, "Алтандорнод Монгол" ХХК 9.6 тэрбум төгрөг, "Жэй ба Э" ХХК 615.7 сая төгрөг, "Ханын материал" ХХК 207.2 сая төгрөгийн татварын өртэй гэх мэт.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу төлбөр гаргуулах чиглэлээр дараахь ажиллагааг явуулж байна. Үүнд:

• төлбөр төлөгчид эд хөрөнгө байгаа эсэх талаар хуульд заасан журмаар мэдээлэл олж авах, төлбөр төлөгчийн мөнгөн хадгаламж болон харилцах данснаас хасалт хийх, эд хөрөнгө болон биед үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, албадан барьцаалах хураах, худалдан борлуулах;

• төлбөр төлөгчөөс эд хөрөнгийн тухай мэдүүлэг авах, өртэй этгээдийн бүртгэлд бүртгэх;

• төлбөр төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос суутгал хийлгүүлэх;

• төлбөр төлөгчийн бусдад байгаа өмч хөрөнгөөс хуульд заасан журмын дагуу төлбөр гаргуулах;

• шийдвэрт нэр заасан тодорхой эд хөрөнгийг төлбөр төлөгчөөс гаргуулж төлбөр авагчид шилжүүлэх, эсхүл тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх;

• хуульд заасан бусад үйл ажиллагаа.

Гэвч төлбөр төлөгч хуулийн этгээд нь он удаан жил үйл ажиллагаа явуулаагүй, төлбөрт гаргуулах эд хөрөнгөгүй, төлбөрийн чадваргүй, төлбөр төлөхөөс санаатайгаар зайлсхийх, эд хөрөнгөө бусдад барьцаалах, шилжүүлэх, битүүмжилсэн эд хөрөнгийг үрэгдүүлэх, төлбөр төлөгч-хуулийн этгээдийн харилцах дансны талаарх мэдээллийг арилжааны банк ирүүлэхгүй байх, татвар төлөгч хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэлгүй, үүсгэн байгуулагч /захирал/ нар гэрийн хаягаар хуулийн этгээд үүсгэсэн, оршин суух тодорхой хаяггүй зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан Шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хуульд заасан албадлагын арга хэмжээ зохих үр дүнд хүрэхгүй байна.

Хуульд заасан үндэслэл, журмын дагуу төлбөр барагдуулах ажиллагааг тухай жилд гүйцэтгэвэл зохих төлбөрийн хэмжээгээр тооцон хэсэгчлэн төлөх төлбөрийн хэмжээг тогтоодог боловч төлбөр төлөгчөөс тогтоосон графикийг зөрчсөнөөс өр төлбөр ихээр хуримтлагдаж, он дамжин үргэлжилж, удаашрах нэг нөхцөл болж байна. Тухайлбал:

• Төлбөр төлөгч "Жамп" ХХК нь 6.7 тэрбум төгрөгийн татварын өрийн үлдэгдэлтэй бөгөөд тус компаний өмчлөлд байсан ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын 24 ширхэг тусгай зөвшөөрлийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн боловч төлбөр төлөгч "Жамп" ХХК-ний захирал Л.Цэрэндаваа нь ашиглалтын 3 тусгай зөвшөөрлийн эрхийг 2011 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр өөрийн охин компани болох "Жамп алт" ХХК-ний эзэмшилд хууль бусаар тусгай зөвшөөрлийн эрхийг шилжүүлсэн байна.

Төлбөр төлөгчийн шүүхийн шийдвэр биелүүлэхээс зайлсхийсэн дээрх санаатай үйлдлийг Цагдаагийн байгууллагад шилжүүлж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 258 дугаар зүйлээр эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулсан боловч Чингэлтэй дүүргийн прокуророос эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзан шийдвэрлэсэн тул дээд шатны прокурорт гомдол гаргаж улмаар холбогдох эрүүгийн хэргийг сэргээлгэн, мөрдөн байцаалтанд буцаалгаад байна.

• Төлбөр төлөгч "Алтандорнод Монгол" ХХК нь 9.7 тэрбум төгрөгийн татварын өрөөс гадна шүүхийн шийдвэрээр иргэд, байгууллагад их хэмжээний өр төлбөртэй тул шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар төлбөрт орж ирсэн мөнгө нийт төлбөр авагч нарт

хувь тэнцэгдэн олгогдож, улмаар дийлэнх эд хөрөнгө нь арилжааны банкинд үүргийн гүйцэтгэлд барьцаалагдсан байдгаас төлбөр гаргуулахад хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэж байгаа юм.

• Сүхбаатар дүүргийн шүүхийн 2011 оны шийдвэртэй төлбөр төлөгч "КПЖВ" ХХК нь 20.1 сая төгрөгийн татварын өртэй боловч бусдад шүүхийн шийдвэрээр 114.4 сая төгрөгийн өртэй, "Монгол нэхмэл" ХХК-ний байранд түрээсээр байрладаг, үйлдвэрийн тоног төхөөрөмж Голомт банкны зээлийн барьцаанд байдаг байна.

• "Эм Жи Эйч" ХХК, "Олон овоот" ХХК-ууд нь татварын өрийг хэсэгчлэн барагдуулах хүсэлт гаргаж байгаа боловч компаний удирдлага тогтвортой бус төлбөрийн мөнгийг тогтоосон хугацаанд барагдуулахгүйгээс өндөр үнийн дүнтэй татварын өр, төлбөр төлөгдөхгүй байна.

• Хан-Уул дүүргийн шүүхийн 2010 оны 845 дугаар шийдвэр мөн шүүхийн 2011 оны 507 дугаар шийдвэрээр "Бөхөг" ХХК-иас 177.4 сая төгрөгийн төлбөрийг татварын байгууллагад олгохоор шийдвэрлэжээ. Гэтэл "Бөхөг" ХХК-ний өмчлөлийн 16 ширхэг шувууны аж ахуйн байр нь Хаан банкинд үүргийн гүйцэтгэлд барьцаалагдсан, өмчлөлд өөр эд хөрөнгө тогтоогдоогүй, уг үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулахаар үнэлгээ тогтоолгосон боловч төлбөр авагчаас шинжээчийн үнэлгээний хөлсийг төлөөгүйгээс шалтгаалан үнэлгээний тайланг гардан аваагүй тул албадан дуудлага худалдаа зохион байгуулах боломжгүй болжээ.

• Баянзүрх дүүргийн шүүхийн 2010 оны 542/А дугаар шийдвэртэй "Жэй ба Э" ХХК нь 615.7 сая төгрөгийн татварын өртэй бөгөөд гүйцэтгэх хуудас 2003 онд захирлаар ажиллаж байсан гэх Эрдэнэчимэгийн хаягаар бичигдэж тус байгууллагад иржээ. Уг хаягт компани үйл ажиллагаа явуулдаггүй, захирлаар ажиллаж байсан гэх Эрдэнэчимэг нь 2006 онд компаниас гарсан, 100 хувийн хөрөнгө оруулагчаар бүртгэгдсэн Zhou Qing 2011 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр БНХАУ-ын Да Лиан хотын эмнэлэгт зүрхний өвчний улмаас нас барсан гэсэн баримт авагдсан байх жишээтэй.

Түүнчлэн төлбөрөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр цагдаа, прокурор, шүүхийн байгууллагад холбогдох материалыг шилжүүлдэг боловч хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалздаг, төлбөр төлөгч-хуулийн этгээдээс цаг хугацаа хожих, өөрт ашигтай нөхцөл байдлыг бий болгох зорилгоор удаа дараа нэхэмжлэлийн шаардлагаа өөрчлөн шүүхэд нэхэмжлэл гаргаж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлдэг.

Жишээ нь: төлбөр төлөгч "Монфорте" ХХК-ний өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийг албадан дуудлага худалдаанд борлуулах явцад эд хөрөнгийн үнэлгээтэй холбогдуулан удаа дараа гомдол гаргаж холбогдох шүүхээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааг 4 удаа түдгэлзүүлжээ.

Төлбөр төлөгч-хуулийн этгээдийн эзэмшилд байгаа тусгай зөвшөөрлийн захиран зарцуулах эрхийн шилжилт хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон ч ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмших эрхийн хугацаа дууссанаар холбогдох байгууллагаас олгогдсон тусгай зөвшөөрлийг хүчингүйд тооцож, цуцлагдаж байна.

Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч-хуулийн этгээдийн эзэмшлийн тусгай зөвшөөрлийн эрхийг худалдан борлуулах зорилгоор хөндлөнгийн үнэлгээний байгууллагаар үнэлгээ тогтоолгоход хүндрэлтэй, шинжээчийн үнэлгээний хөлс, зардлыг талууд шийдвэрлэдэггүй, худалдан борлогдоогүй тохиолдолд төлбөр авагч байгууллага төлбөрт тооцон авахаас татгалздаг зэрэг нөхцөл байдлаас шалтгаалан албадан дуудлага худалдаагаар тусгай зөвшөөрлийн эрхийг борлуулах боломжгүй нөхцөл байдал өнөөдөр бидэнд тулгараад байгаа юм.

Цаашид шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгар буй дээрх хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд:

- Хууль тогтоомж, эрхийн актыг боловсронгуй болгох /шүүхийн шатанд хариуцагчийн эд хөрөнгийг заавал битүүмжилдэг болгох, эрүүгийн хэрэг үүсгэсэн нөхцөлд тухайн сэжигтний эд хөрөнгийг заавал хамгаалдаг байх/

- Хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлж, хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх,

- Хуулийн болон татварын байгууллагуудын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргаж, хамтран ажиллах,

- Боловсон хүчний мэдлэг, чадвар, мэргэшлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр давтан сургалтанд байнга хамруулах,

- Төрийн байгууллагуудыг нэгдсэн мэдээлэл хангалтгүй байгаа тул нэгдсэн мэдээллийн сүлжээнд холбох,

- Эрсдлийг урьдчилан тооцож, урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажлыг зохион байгуулах

- Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг талуудад ил тод нээлттэй болгох,

Энэхүү зөвлөгөөнөөс татвар төлөгч нарт чиглэсэн тодорхой зөвлөмж, хуулийн байгууллагуудын хамтын ажиллагааны чиглэлээр үнэтэй санал, санаачлага гарч байна.Үүнд ажил хэрэгчээр хандаж, хэрэгжүүлэн ажиллахыг хүсэж, энэ ажилд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага бүхий талаар дэмжиж, хамтран ажиллах болно.

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРЛЫГ НӨХӨН БАРАГДУУЛАХ АЖИЛЛАГААНЫ ТӨРИЙН БОДЛОГЫН ТҮҮХЭН ХӨГЖИЛ



Пүрэвийн Гантөмөр

ШШГС-ийн тэнхимийн эрхлэгч, хошууч

Эртний Хүннүгийн анхны ердийн хэв хуульд "ялд унасан хүнийг үйлдвэрлэл, гар урлалын ажилд зүтгүүлдэг" байсан тухай баримт нь бий.

Манай орчин үеийн түүхчдийн үзэж байгаагаар Сяньби улсын хаан нь янз бүрийн зарлиг буулгаж байсны дээр Таньшихуайн /141-181/ үеэс эхлэн төрийн бичмэл хууль цаазтай болсон байна. Гэвч тэр үеийн хууль цаазын зүйл нь манай үед хадгалагдан үлдсэнгүй. Гагцхүү зарим түүхэн эх сурвалжийн дотор, тухайлбал, эртний хятадын "Зүүн Хань улсын түүх" зохиолд Таньшихуай "хууль цааз хэрэглэн зөв бурууг шийдэж байсан бөгөөд зүрхлэн зөрчигчид байсангүй" гэсэн байдаг байна.

Их засаг хуулийн тухай түүхэн эх сурвалжуудад өгүүлснээр Эзэн Чингис хаан "бүх улсын дотор хулгайг цээрлүүлж, худлыг мохоож, үхүүлэх ёстойг үхүүлж, яллах ёстойг яллаж байхыг" их заргач Шихихутугт зарлиг буулгаж, улмаар "хэргийн үнэн үндэс баримтыг олж, гэмт хэрэгтэн юуны учир яллагдах болсон, гэрч баримтыг түүнд мэдүүлж, ял тогтоон, хуульд нийцүүлэн шийтгэ" хэмээжээ.

Монголын нууц товчоонд Чингис хаан дайн байлдаанд үрэгдсэн хүмүүсийн ар гэрийнхнийг тэтгэх зорилгоор өнчдийг тэтгэх сан байгуулж байсан баримт байдаг. Жишээлбэл: "Хуйлдар анд алалдан байлдах цагт урьтаж ам нээж байлдсан гавьяа бий тул, түүний хөвгүүд, ач нарт, өнчдөд олгох, өршөөл тусламжийг хүртээсүгэй" §217; "Нарийн Тоорилын эцэг Цагаан гуа чин зоригийг барьж байлдсаар Даланбалжудын байлдаанд Жамухад алагджээ. Одоо эцгийн гавьяаг хүртэж өнчдийн тусламжаас авч бай" §218 гэжээ.

Их засаг хуульд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг том бага хэмээн үзэж, ял оногдуулахдаа харгалзаж байсны дээр" хулгайлагсадыг алах бөгөөд түүний гэргий ба мал хөрөнгийг хурааж, хулгайлуулагсдад өгмой" гэсэн заалт байсан нь гэмт хэргийн хохирогчийг тогтоож, учирсан хохирлыг нөхөн төлүүлж байсан баримт мөн. Тухайлбал гэмт хэргийн хохирлыг том, бага хэмээн үзэж ял оногдуулахдаа харгалзаж байв. Жишээ нь : "Том хулгайчид үхэх ял оногдуулна. Гэвч хулгайч ... нэг хонь хулгайлсан гэх мэтийн бол тухайн газар нь хэдэнтээ баривчилж, өдий төдий шийдэмдэнэ." /В.Рубрук/[1] гэжээ.

[1] Сайшаал. Чингис хааны товчоон. Хөх хот., 1987. 49-52-р зурвас.// 2002онд Н.Мөнхсоёмбо "Их засаг хууль" хэсгийг крилл үсэгт хөрвүүлэв/ Зох.

Түмэдийн Алтан хааны цаазад:" хүн албаас гурав жанчиж, тэргүүн есөөр торгож, нэг хүнээр ор босго" мөн хүмүүсийн хэрүүл зодооны завсраар шударга хүн орж алагдвал торгох, занчих шийтгэлээс гадна "хүн тэмээ аль нэгээр ор босго" гэж тус тус заасан нь гэмт хэргийн улмаас хохирогч этгээдийн хохирлыг барагдуулах хэлбэр байжээ гэж дүгнэж болно. Мөн ор босгох талаар Мичин жилийн их цааз /1620/, Монгол Ойрадын Их цаазад мөн орсон нь сонирхол татаж байгаа юм. Гэхдээ Х VII зууны үед хууль цаазын зохицуулалт, хамгаалалтын арга хэрэгсэл боловсронгуй болсон той холбоотойгоор ор босгох заалт нь дараагийн хуулиудад "ор өгөх", "цөм /бүгдийг авч өгөх/ авч өгөх", "хагаслан авч өгөх", "...ид, идтүгэй" гэх зэргээр уламжлагдан, улам баяжиж ирснийг тэмдэглэх хэрэгтэй юм.

Манжийн ноёрхлын үед гадаад монголд зорчуулсан хууль цаазын гол эх сурвалж нь "Зарлигаар тогтоосон гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг" /1789, 1817, 1848/ мөн. Уг хуульд "аливаа хэрэг халдаж торговол зохих малыг цөмийг баруун жургаанд[2], бичиг хүрсэн өдрөөс эхлэн...тушаах" тухай дурдсан нь торгуулийн эд хөрөнгө шууд манжийн хааны санд ордог байсныг гэрчилж байна. Гэвч Монголын дотоод бодлогыг "Халх журам" хуулиар зохицуулж ирсэн учраас гэмт хэргийн хохирогч, түүний хохирлыг барагдуулах тухай асуудлыг ихэвчлэн уг хуулиар зохицуулж байсан гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Монголын хаант улсын гол хууль болох "Зарилгаар тогтоосон монгол улсын хууль зүйлийн бичиг" /1915-1918/ -ийн "Хүний амин" хэмээх хуульд " ...хохирогч хүний ам бүлд 20 лан хүртэл мөнгө гаргаж өгөх, яс хувцаслах мөнгө гаргуулах */оршуулгын зардыг гаргуулах/* тухай заажээ[2]. Мөн хуульд хулгайн төлбөр гаргуулах талаар: нэгэн зүйл, Аливаа хулгай, худлын сүйтгэлийг уг хулгайн нэрийн дороос хөөн гаргуулахаар хэрэв төлөх чинээгүй болвоос түүний ураг төрөл ба харъяат захирах тайж, сумын занги, эрхлэх захирах даргад тулгаж төлүүлэхтүн. Үнэхээр төлж үл чадах нь болвоос сум, отог, багаас нийгэмчлэн төлүүлэгтүн" гэжээ.

1921 онд Богдын Засгийн Газрыг халсан Ардын Засгийн Газар нь хуучин засгийн газрын хууль цаазыг өөрчлөх, халах талаар хэд хэдэн чухал арга хэмжээ авсаны дотор 1923 оны хоёрдугаар сарын 13-ны өдрийн хурлаар аливаа хүний хийсэн хулгай сүйтгэлийг түүний төрөл, төрөгсөд болон хошуу, аймагт нь халдаан төлүүлдэг байсан урдын шударга бус журмыг халж, тухайн сүйтгэлийг гагцхүү гэмтэн этгээдэд өөрт нь хариуцуулах болгов.[3]

1926 онд Монгол Улсын эрүүгийн анхны хууль болох "Шүүх цаазын бичиг"-ийн ерөнхий ангийг нэгдүгээр сард Засгийн газрын 1 дүгээр хурлаар, тусгай ангийг арван нэгдүгээр сард Улсын III дугаар Их хурлаар баталжээ. Эл хуулийн Хорин гуравдугаар бүлэгт заасан Улсын ба ард олны хөрөнгийг сүйтгэх гэмт хэргүүдэд /165§,166§, 167§,

[2] Б.Содовсүрэн. Хувьсгалын өмнөх монголын төр ба хууль цааз. /1911-1920/. УБ., 1989. 57-р тал.

[3] Д.Сангидагзан. Хувьсгалын ардчилсан шатан дахь ардын төрийн үндсэн чиг үүргүүд. (1921-1940).УБ.,1974.110 –р тал.

168§/ ял шийтгэхийн зэрэгцээ "хувийн хөрөнгө, хогшлоос тэрхүү хохирлыг нөхөн төлүүлэх"-ээр анх тогтоожээ.

1929 оны "БНМАУ-ын Шүүх цаазны бичиг"-ийн зөвхөн 170 дугаар зүйлд: "Улсын ба ард олноор байгуулсан хоршооны зэрэг газрын юмыг агуулсан байшин саваас буюу зөөх тээх дор мөнхүү газруудын эрхэлсэн сахисан албан ажлын хүмүүс зоргоор авч хэрэглэх ба арилжих, солих зэргээр элдэв арга хэрэглэж ашиглаваас хохирол сүйтгэлийг төлүүлэх"-ээр зааж, үйлдсэн дээрх хэрэг дээр хөрөнгийг хураах ялаар заажээ.

1934 оны "БНМАУ-ын Шүүх цаазын бичиг" хуулийн Ял шийтгэлийн тухай Дөрөвдүгээр бүлэгт: учруулсан гэм хорыг арилгах үүргүүдийг даалгах ялын шинэ төрлийг тогтоосон байна. Энэ хуулийн зүйл 29-д: "Гэмт хэрэг үйлдэхдээ өдүүлсэн гэм хорыг уул этгээдээс өөрийн хичээл зүтгэлээр буюу учруулсан хохирлыг нөхөж гүйцэтгэхээр шийтгэгсдэд тулган даалгахыг шүүх таслах газраас сурган хүмүүжүүлэх ба нийцэх зүйлд хэмээн үзвээс тийнхүү тогтоож болно. Шүүн таслах газраас энэхүү хэмжээг тогтоосон шийтгэсэн бөгөөд хохирсон этгээдээс иргэний нэхэмжлэлийг цаашид үл явуулах болно" гэж заажээ. Мөн энэ хуулийн 27-д "Хөрөнгө хураахад уул хөрөнгө зүйлийн мөрдөн байцаах газраас битүүмжилсэн, хамгаалах арга хэмжээ авсаны хойно шийтгэгдэгсдээс хийсэн бусдад төлөх өр шир ба хүлээсэн үүргийг улсаас хүлээнэ. Хураагдсан хөрөнгөөс төлж гүйцэтгэх ба зохих бүцаан нэхэмжлэн мэдүүлснийг улсаас төлж гүйцэтгэхдээ зөвхөн уул бэлэн байгаа хөрөнгийн хэмжээний дотор багталцуулан гүйцэтгэх.

Үүнд: юуны урд ажлын хөлс ба үр хүүхдийн тэжээлийн мөнгийг нэхэмжлэн гүйцэтгэх. Дараа нь албан татвар төлөх дутагдлуудыг нөхөн төлнө. Түүний дараа бусад албан газрын нэхэмжилснийг гүйцэтгэж, эцэст нь бусад нэхэмжилснийг гүйцэтгэ[illegible]гэжээ[4].

1935 онд Улсын Бага Хурлын тэргүүлэгчдийн 30 дугаар тогтоолын 5 дугаар зүйлээр батлагдсан Бүгд Найрамдах Монгол Ард Улсын аливаа эрүүгийн хэргийг хэрхэн байцаах ба шийтгэх тухай хуулийн хорин долдугаар зүйлд: "тоо хэмжээ зэргийг харъяалах байцаагчаас чухамхүү төлбөр сүйтгэл ба түүний байдлыг харгалзан тогтоож өгөх" ба барьцаалагдсан этгээд оргон зайлсан бол барьцаалагдсан хөрөнгө хогшлыг "төлбөр сүйтгэл"-д олгох зэргээр заажээ.

БНМАУ-ын 1942 оны Эрүүгийн хуульд гэмт хэргийн хохирогчийн эрх ашгийг хамгаалах талаар урд өмнөх хуулиудад заасан үндэслэлүүдээс өөр нэмэлт ямар нэгэн шинэ зүйл нэмж хуулыгаагүй байна.

1949 оны наймдугаар сард Улсын бага хурлын тэргүүлэгчдийн 9 дүгээр зарлигаар батлагдсан "Шүүхийн зохион байгуулалтын тухай хууль"-ийн 6 дугаар бүлгийг "Шүүхийн гүйцэтгэгч нар" гэж нэрлээд, "иргэний талаар гаргасан шийдвэр, магадлалууд

[4] Д.Адъяабазар. Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил. // хуучин монголоос хөрвүүлж, тайлбартайгаар эмхтгэсэн/ I дэвтэр. УБ.,1998.

ба эд хөрөнгийг гаргуулах тухай асуудалтай холбогдсон эрүүгийн хэргийг шийтгэсэн тогтоолуудыг биелүүлэх ажлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нараас гүйцэтгэнэ" гэжээ. Мөн ардын хэсгийн шүүхээс гаргасан эд хөрөнгийг төлүүлэх асуудалтай холбогдсон шүүхийн шийдвэр магадлал ба шийтгэсэн тогтоолуудыг биелүүлэх ажлыг сумдын захиргаанаас гүйцэтгэнэ" гэжээ. Энэ цаг үеэс эхлэн хуулийн байгууллагын тогтолцооны хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид хохирогчийн эд хөрөнгийн хохирлыг арилгах ажилд хүчин зүтгэж эхэлсэн гэж болно.

1961 онд БНМАУ-ын Эрүүгийн хууль нь "тоталитаризмаас авторитар дэглэмд шилжих үед (1953-1965) боловсрогдсон боловч"[5] эрүүгийн материаллаг ба процессын эрх зүйн онолын сэтгэлгээ, хууль зүйн техникийн өндөр түвшинд боловсрогдсон хууль гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй юм. Энэ уламжлал 1987 оны эрүүгийн хуульд ч гэсэн хадгалагдан үлдсэн гэхэд болно.

Харамсалтай нь социализмын үеийн хууль тогтоомжууд нь хохирогчийн зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, хохирлыг арилгах механизм бүрдээгүй учраас тунхагийн шинжтэй байсан юм.

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн *Арван зургадугаар зүйлийн* 14 дэх хэсэгт зааснаар иргэн нь :"Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх" эрхтэй, *Арван есдүгээр зүйлд:*" Төрөөс... хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж тус тус заажээ.

2002 оны эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хуульд дээрхи зарчмууд тусгалаа олсон байна. Эдгээр хуулиудад хүний эрх, эрх чөлөөг хангах, түүний дотор гэмт хэргийн хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн Тухайлбал: шүүгдэгч бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөөгүй бол тэнсэхгүй байх, ялтан хохирлоо нөхөн төлөөгүй , гэм хорыг арилгаагүй бол хорих ялыг хугацаанаас өмнө тэнсэн суллахгүй байх гэх мэт шинэлэг заалтууд орсон хэдий ч хохирогч хохирсон хэвээр үлдэх явдал байсаар байна.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллагад учруулсан хохирлыг барагдуулах, энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй гүйцэтгэх үүднээс хорих ял эдэлж байгаа ялтны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажлын байраар хангах улмаар хөдөлмөр хөлснөөс хохирогчийн хохирлыг аль болох түргэн шуурхай нөхөн төлөгдөх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2008-2012 онд "Ялтны гэм хорын хохирол барагдуулалтыг нэмэгдүүлж, төлбөр барагдуулалтанд хяналт тавин ажиллах хөтөлбөрийг"-ийг ШШГЕГ-ын даргын 2008 оны А/102 тоот тушаалаар батлан гаргаж, хэрэгжилтийг харъяа нэгжүүд болон ял эдэлж буй ялтнуудад сурталчлах ажлыг тухайн хорих ангиуд дээр зохион байгуулан ажиллаж байна.

[5] Монгол Улсын түүх. Тавдугаар бот. (XX зуун) Хоёр дахь хэвлэл. УБ., 2004. 284-р тал.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр:

- төлбөртэй ялтанг хугацааны өмнө тэнсэн суллахгүй байх
- ялтанг ажлын байраар хангаж, нийгэмд зөв хүн болгон төлөвшүүлэх, тэдэнд мэргэжил олгох
- ялтны ахуй хангамж, амьдрах орчин сайжирч, тодорхой орлоготой болгох
- ялтны төлбөрийн мөнгийг хохирогчдод олгох ажиллагааг шуурхай олгох талаар бодит үр дүнг гаргахаар тодорхой асуудлыг дэвшүүлэн ажиллаж байна.

Засгийн газрын 2008 оны 51 дүгээр тогтоолоор "Хорих ангиудын үйлдвэрлэлийн чиглэлийг шинэчлэн тогтоосны дагуу ШШГЕГ-ын даргын 2008 оны А/08 тоот тушаалаар "Ялтны хөдөлмөрийн норм, хөдөлмөрийн хөлсний үнэлгээг тогтоох түр журам"-ыг батлан гаргаж мөрдлөг болгон ажиллаж байна.

Ялтны зан байдлыг төлөвшүүлэх, мэргэжил, боловсрол эзэмшүүлэн хөдөлмөрт татан оролцуулах, хохирлоо нөхөн төлөх чадвар эзэмшүүлэх, хорих ангиас суллагдсаны дараа нийгмийн амьдралд байр сууриа олж амьдрахад нь дэмжлэг үзүүлэх зорилго бүхий "Ялтныг нийгэмшүүлэх ажлын хөтөлбөр"-ийг 2008-2011 онд хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг зохион байгуулаад байна.

Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд иргэний эрх, ашиг сонирхлыг хамгаалах, түүнийг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүднээс шүүх эрх мэдлийн байгууллага, төрийн байгууллагуудын тогтолцоог шинэчлэн зохион байгуулахад ач холбогдол бүхий хуулиудыг хэрэгжүүлж эхлээд багагүй хугацаа өнгөрөөд байна. Уг шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үүрэг оролцоо улам бүр өсөн нэмэгдсээр байгаа энэ цаг үед бидний хувьд ч гэсэн шийдвэрлэвэл зохих, нэн чухалд тооцогдож буй асуудлын нэг нь гэмт хэргийн болон захиргааны хууль бус шийдвэр, үйл ажиллагаанаас иргэнд учруулсан хохирлыг барагдуулах ажиллагаа байдаг.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хохирогчийн эд хөрөнгийн эрх ашгийг хамгаалах ажиллагааг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид үүрэг болгоогүйгээс гэмт этгээдийн эд хөрөнгийг эрэн сурвалжлах, олж тогтоох, хамгаалалтанд авах ажиллагаа хангалттай хийгддэггүй. Зөвхөн гэмт хэрэг, түүнд холбогдогчийг илрүүлэх чиглэл рүү түлхүү анхаарснаас гэм буруутай этгээд нь шүүхийн шийдвэр гарахаас өмнөх шатанд эд хөрөнгөө нуун дарагдуулах, бусдад шилжүүлэх, худалдан борлуулах, улмаар шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх шатанд төлбөр төлөгч хувьд ногдох ямар нэгэн эд хөрөнгө, орлогогүй, төлбөрийн чадваргүй бөлсон байдаг.

Хуульд "...хорих ангид ял эдэлж буй ялтны төлбөрийг түүнд ногдох эд хөрөнгөөс төлүүлж, үлдэгдэл төлбөрийг ялтны хөдөлмөрийн хөлснөөс сар бүр суутгал хийж шийдвэр гүйцэтгэх албаны дансанд төвлөрүүлж байх"[6]-аар заасан. Гэвч практик

[6] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 66 дахь зүйлийн 66.2 дахь заалт

гэмт хэрэг үйлдэж бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад ял эдлэгсдийн ихэнх хувь нь төлбөрийн чадваргүй, хөрөнгө орлогогүй, оршин суух тодорхой хаяггүй, ганц бие байдаг. Хорих ангид ял эдэлж байгаа ялтны хувьд удаан хугацаагаар хорих ялыг биечлэн эдэлдэг бөгөөд тэдгээр нь хувьд ногдох хөрөнгө, орлогогүйгээс энэ төрлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл хангалттай биелдэггүй. Энэ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг.

Өнөөдөр хорих ангид нийт улсын хэмжээнд төвлөрсөн 23 хорих ангид 5069 ялтан ял эдэлж байгаагаас бусдад 77,8 тэрбум төгрөгийн төлбөртэй 2234 ялтны судалгааг сар бүр хорих ангиас авч 426 ялтанд холбогдох 591.5 сая төгрөгийн хохирлыг барагдуулаад байна. 2007 онд 3028 ялтны 68,9 тэрбум, 2008 онд 2874 ялтны 75,1 тэрбум, 2009 онд 2234 ялтны 77,8 тэрбум төгрөгийн хохирлын бүртгэлтэй байна.[7]



төлбөртэй ялтны хохирлын хэмжээ

Ялтнаас учруулсан хохирлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хохирлын хэмжээ нь 2.7 тэрбум төгрөгөөр өсчээ. Нийт ял шийтгүүлсэн ялтнаас учруулсан хохирлын 75.6 тэрбум төгрөгийн хохирол нь өмчлох эрхийн эсрэг гэмт хэрэг / Эрүүгийн хуулийн 145-155 зүйл/ бөгөөд 97,1 хувийг эзэлдэг. Үүнээс бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирол 58,1 тэрбум буюу 74,6 хувийг эдэлж байна. Өөрөөр хэлбэл нийт гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 74 хувийг залилангийн гэмт хэрэг, 26 хувийг бусад гэмт хэрэг эзэлж байна. Энэ нь залилангийн гэмт хэрэг сүүлийн үед ихээр үйлдэгдэх болсонтой шууд холбоотой.

[7] ШШГЕГ-ын даргын "Хохирогчийн эрх ашгийг хамгаалах нь үндэсний чуулган"-д тавьсан илтгэл.,2007

ХОРИХ АНГИД ЯЛ ЭДЭЛЖ БУЙ ТӨЛБӨРТЭЙ ЯЛТНЫ СУДАЛГАА

/ ГЭМТ ХЭРГИЙН АНГИЛЛААР/





Манай оронд зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн энэ үед эдийн засгийн болон бусад төрлийн хүнд гэмт хэрэг олноор гарч, түүний үр дагавар нь олон хүнийг хамрах боллоо дээрх тооноос харахад өмчийн эсрэг гэмт хэрэг 97,1 хувийг эзэлж байна. Үүний нэг тод жишээ бол Хадгаламж зээлийн хоршоодын эздийн үйлдсэн гэмт хэрэг юм. Олон иргэдийг хохироосон энэ гэмт хэргүүдийн хохирогчдын эрх ашгийг хамгаалах үүднээс Улсын Их Хурлаас Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай нэг удаагийн үйлчлэлтэй хуулийг боловсруулан баталсан билээ.

Уг хуулийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор зохих байгууллагад санал оруулснаар Монгол Улсын Засгийн газраас 2007 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 242 дугаар тогтоолоор "Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах журам"-ыг батлуулж, хэрэгжүүлж эхлээд байна.

Уг эрх зүйн зохицуулалттай холбоотойгоор ялтнаас бусдад учруулсан хохирлоо нөхөн төлөх явдал өмнөх онуудаас нэмэгдэж байгаа хэдий боловч хүнд, онц хүнд

гэмт хэрэг үйлдэж бусдын амь бие, эрүүл мэндэд хохирол учруулснаас үүссэн гэм хорын толбөр биелэгдэхгүй удааширч, иргэд хохирсоор байгаад дүгнэлт хийж, энэ чиглэлээр онцгойлон анхаарал хандуулах зайлшгүй шаардлага бидний өмнө тулгараад байна.

Хохирогчдод нөхөн төлбөр олгох үүднээс *Гэмт хэргийн улмаас хохирсон иргэнд нохон төлбөр олгох тухай* хуулийн төсөл боловсруулагдсан бөгөөд хуулийн төсөлд төсвөөс гадна "Хохирол барагдуулах сан" байгуулах, үүнд төрийн оролцоо зайлшгүй шаардлагатай байгаа талаар оновчтой саналуудыг тусгасан нь хэрэгжил шийдэлээ олвол ихээхэн ач холбогдолтой зүйл болно.

Гэмт хэрэг үйлдсэний улмаас бусдад учруулсан хохирлыг барагдуулах ажиллагаанд нөлөөлж буй нөлөөллийг дүгнэж үзвэл:

- **Сүүлийн жилүүдэд шунахай, залилангийн шинжтэй гэмт хэргийн гаралт эрс өсч, иргэд өөрсдөө хуулийн мэдлэг, дутмагаас бараг "сайн дураар" шахуу гэмт хэргийн хохирогч болох эрсдэлд орж байна. Энд урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй байна.**
- **Гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж байгаа ялтныг ажлын байраар бүрэн хангах боломж хомс байна.**
- **Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагааны шатанд гэмт этгээдийн эд хөрөнгийг эрэн сурвалжлах, олж тогтоох, хамгаалалтанд авах ажиллагаа төдийлөн хангалттай хийгдэггүй.**

Хууль тогтоомжинд хохирогчийн эрх ашгийг хамгаалах, бусдад учруулсан хохирлыг арилгах асуудлыг зарчмын хувьд тунхагласан боловч хэрэгжүүлэх механизмыг тодорхойлон хуульчлаагүй, эрүүгийн ялын бодлогод цээрлүүлэх хандлагыг түлхүү барьжээ. Монгол улсад хэрэгжиж байгаа хууль тогтоомжид хохирогчийн эрх ашгийг хамгаалах, бусдад учруулсан хохирлыг арилгах асуудлыг зарчмын хувьд тунхагласан боловч хэрэгжүүлэх механизмыг тодорхойлон хуульчлаагүй, эрүүгийн ялын бодлогод цээрлүүлэх хандлагыг түлхүү барьж байгаа нь ажиглагдаж байгаа бөгөөд гэмт хэргийн цар хүрээ, зохион байгуулалт нэмэгдэж, түүнд өртөгсөд, хохирогсодын тоо эрс өсөж байгаа нь дээрх тоо баримтуудаас тод харагдаж байна. Иймд эрүүгийн ялын бодлогод хохирлыг барагдуулах бодлогыг шинэчлэн тогтоож өгөх нийгмийн шаардлага байна.

Өнөөдрийн байдлаар Хорих ангид ял эдэлж буй ялтны төлбөл зохих 77.8 тэрбум төгрөгийн 70.0 тэрбум орчим нь хадгаламж зээлийн хоршоо, банк санхүүгийн гэмт хэргийн холбогдогсодод ногдож байгаа бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн хохирлыг барагдуулах тогтолцоог бий болгох хэрэгтэй нь харагдаж байна. Тиймээс гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох нийгмийн шаардлага байгааг онцлон дурдаад энэ талаархи саналаа энэхүүсэтгүүлээр дахин хүргэх болно

"ТОРГОХ ЯЛЫН ХЭРЭГЖИЛТ, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТОРГУУЛИЙН АРГА ХЭМЖЭЭ ОНОГДУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ"



Цэдээгийн Баяртбаатар
ШШГСургуулийн "Маршал" клубын тэргүүн, сонсогч

Ял нь гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийн үндсэн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөөг хязгаарласан хязгаарлалт бөгөөд гэмт үйлдлийнх нь нийгэмд учруулсан хор аюул болон гэмт этгээдийн хувийн байдлыг харгалзан ялыг сонгох боломжтой байдаг.

Ял нь гэмт явдалтай тэмцэх чухал хэрэгсэл болдог ба тэмцлийн бусад хэлбэр үр дүнгээ өгөхгүй байгаа тохиолдолд хэрэглэдэг төрийн албадлагын хамгийн хатуу хүнд хэлбэр юм. Монгол улсын эрүүгийн хуульд

1.Торгох

2.Албадан ажил хийлгэх

3.Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах

4.Эд хөрөнгө хураах

5.Баривчлах

6.Хорих

7.Цаазаар авах зэрэг 7-н төрлийн ялыг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэхээр хуульчилсан.Монгол улсын Эрүүгийн хуулинд хуульчлагдсан торгох ялыг Монголын уламжлалт эрх зүйн эх сурвалжуудад тогтоосон хэмжээгээр гэм буруутай этгээдэд шүүх эрх бүхий албан тушаалтнаас ноогдуулах эд хөрөнгө, мөнгө болон малаар торгож шийтгэж байжээ. Чингисийн "Их засаг", "Түмэдийн Алтан хааны цааз", "Халхын үйсэн дээр бичсэн цааз", 1640 оны Монгол Ойрадын "Их цааз", "Халх журам" зэрэг цаазын бичиг есөөр болон таваар торгох ялыг өргөн хэрэглэж байжээ.[1]

"Жинхэнэ дагаж явах хууль, дүрэм"-ийн бүтцийг ажиглавал торгох ялыг өргөн хэрэглэж байжээ. Энэ нь мөн л монголчуудын уламжлалд хууль цаазын сэтгэлгээ болон манжийн хууль цаазад тулгуурласны илрэл бөгөөд дүрмүүдэд ес суурьтай малаар торгох ялыг түлхүү хэрэглэж гэм буруутай этгээдийн хөрөнгийн байдлыг харгалзан торгох ял ногдуулж байсан нь уг ял бодитой хэрэгжих эх үндэстэй болжээ. Тухайлбал: "Аливаа хулгай худлыг эрхлэн барих түшмэл, цэргийн ард нэгэнт барьж олсон хулгай худлын морь, мал, эд юмыг шингүүлэн авч зоргоор хувааж биедээн шингүүлэх болбаас түшмэлийг

[1] Б Баярсайхан. Хууль зүйн тайлбар толь (Монгол Улсын төр, эрх зүйн түүх). УБ. 2003 он. 242 дахь тал..

нэгэн есөн мал торгосугай". гэжээ.

Уг дүрмүүдэд буй торгох ял дараахь онцлог шинжтэй бөгөөд энэ нь манжийн хууль цаазын эх сурвалжтай шууд холбоотой юм. Энэхүү ял нь: нэгд, мөнгөн утгаар хэрэгждэггүй торгох ялын зүйл нь эд хөрөнгө, мал байсан, хоёрт, гэмт этгээдийн материаллаг эрх ашгийг хөндөхөөс өөр ямар нэгэн эрхэнд хязгаарлалт тогтоон хэрэгжүүлдэггүй байв.

Малаар торгох ял дараахь хэлбэртэй байсан.

- Бод малаар буюу адуу, үхрээр торгох. Энэ торгуулийн хэлбэр нь есөөр торгох торгуулийн нэгэн адил тодорхой тооны хэмжээ заадаггүй, харин монголын уламжлалт эрх зүйн эх сурвалжид торгуулийн малыг шууд морь, үхэр гэж зааж өгсөн байдаг бол Манжийн үеийн "Монгол цаазын бичиг"-т гунан үхэр ав, долоон морь, нижгээд үхэр, морь ав гэх зэргээр ялын нэр, хэмжээг тогтоож өгсөн байна. Энэ торгуулийн хамгийн их хэмжээ арав хүртэл байх бөгөөд түүнээс дээш хэмжээ есөөр хэмжигддэг байна. Харин "Халх журам"-д зуугаас гурван зуун мал хүртэл торгох заалт байдаг.

Харин уг дүрмээр зөвхөн "мал" хэмээн нэрлэж торгохоор заасан байна.

- Ес суурьтай торгууль. Энэ нь цаазын бичгээр тогтоосон тоогоор 9 мал болгон түүнийгээ гурав, тав, долоо, ес дахин үржүүлэн төлдөг торгуулийн уламжлалт хэлбэр юм. Бидэнд уламжлан ирсэн цаазын бичигт есөөр торгох ялын хэмжээг зааж өгсөн байдаг.

.Цаг хугацаа хувьсан өөрчлөгдөхийн хирээр торгох ялын торгуульд авах зүйлийн хэв шинж өөрчлөгдсөөр өнөөгийн нийгэмд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд үнэт цаас буюу мөнгөөр торгодог болоод байгаа юм.Зөвхөн манай улс төдийгүй гадны улс орнууд торгох ялыг Эрүүгийн хуулиндаа хуульчилж өгсөн байдаг боловч өөрсдийн гэсэн онцлогтойгоор хүлээлгэдэг байна.Зарим нэг улс орны торгох ялыг оногдуулах хэв шинжээс дурьдвал:

АНУ-д торгох ялыг ямарч ангиллын гэмт хэрэгт оногдуулах боломжтой, үндсэн болон нэмэгдэл ялын чанартайгаар түгээмэл хэрэглэгддэг ялын төрөл бөгөөд хүнийг санаатай алсан зэрэг онц хүнд хэрэгт цаазаар авах, хорих ялыг үндсэн ялын чанартайгаар, торгох ялыг нэмэгдэл ялын чанартай хэрэглэдэг.

Шүүхийн шийдвэрт торгуулийн мөнгийг нэн яаралтай төлөх эсвэл зохих хугацаарьтайгаар төлөхийг заадаг. Торгуулийн мөнгө 30-90 хоногийн дотор төлөгдөөгүй бол энэ ял биелэгдээгүйд тооцдог байна[2]

Итали улс: торгох ялыг шүүхээс оногдуулдаг мөнгөн төлөөсийг улсын орлогод хураахыг хэлдэг бөгөөд торгуулийн хэмжээ 10 мянгаас 10 сая лир байна. Эрүүгийн хуулийн ерөнхий ангид зааснаар "...шунахай сэдэлттэй үйлдэгдсэн тодорхой гэмт хэрэгт торгох ялыг оногдуулахаар заагаагүй байсан ч шүүх нэмэгдэл ялын чанартай хэрэглэж болно" гэжээ.

Япон улс: Япон улсын Эрүүгийн хуулийн 15 дугаар зүйлд "..мөнгөн торгуулийн хэмжээ 10000 иенээс дээш байна, хөнгөрүүлэх нөхцөл байдал байгаа бол 10 иенээс бага байж болно", 17 дугаар зүйлд "...бага хэмжээний торгууль нь 1000-10000 хүртэл иен

[2] А.Лхагва.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй УБ.2009 он.315 дахь тал

байна"гэжээ. Японд сүүлийн 5 жилд 1.2 сая хүн шүүхээр ял шийтгэгдсэн ба торгууль төлөх чадваргүй болсон бол албадан ажил хийлгэх газарт торгуулийн хэмжээнээс хамааарч 2 жил хүртэл хорьж ажиллуулдаг. Торгох ял нь үндсэн болон нэмэгдэл ялын чанартай хэрэглэгддэг бөгөөд торгуулийн хэмжээ нь гэмт хэрэг үйлдсэн хувь хүн болон хуулийн этгээдэд өөр өөр байдаг[3].

Франц улс: 1810 оны Эрүүгийн хуульд торгох ялын талаар анх заасан байдаг бөгөөд өнөөдөр хамгийн өргөн хэрэглэдэг ялын төрөл болжээ. Зөвхөн хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэгт тэр дундаа шунахай сэдэлттэй үйлдэгдсэн, өмчийн эсрэг гэмт хэрэгт голчлон торгох ялыг хэрэглэдэг.

Торгох ял нь ердийн мөнгөн торгууль, өдрийн орлогоор хэмжигдэх торгуулийн өдөр гэсэн 2 төрөлтэй байх ба гэмт хэргийн ангилалтаас хамааарч ердийн торгуулийн хэмжээ нь 20,000-50 сая евро байна. Торгуулийн өдөр гэдэг нь гэмт этгээдийн өдрийн орлогоос суутгаж улсын орлогод хураах явдал бөгөөд дээд хэмжээ нь өдөрт 2000 хүртэл евро, нийт 360 өдрөөс хэтрэхгүй байхаар тотоожээ[4]

Хуулийн этгээдэд гэмт хэргийн ангилалтаас хамааарч 50.000-250 сая хүртэл еврогийн торгууль оногдуулдаг ба торгууль төлж чадахгүй бол хуулийн этгээдийг албадан татан буулгах, хувь хүнийг бол 6 сар хүртэл хорих ялаар солино. Харин 18 насанд хүрээгүй этгээд, 65 нас хүрсэн этгээдэд оногдуулсан торгуулийг хорих ялаар сольж болохгүй, торгох ялын биелэлтэнд татварын цагдаа хяналт тавихаар заажээ.

Дэлхийн улс орнууд торгох ялыг өөрсдийн нийгмийн байдалтай уялдуулан онцлогтой оногдуулдаг нь харагдаж байгаа юм

.Харин Монгол улсын Эрүүгийн хуульд хуульчилж өгсөн торгох ял нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамааралтай байдаг бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хэргийн учруулсан хор уршгаас хамаараад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгодог.Эрүүгийн хуулийн 226-н зүйлийн 146-н зүйлд буюу 64.4%-д торгох ялыг оногдуулахаар хуульчилсан байна[5].

Өнгөрсөн жилийн байдлаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 108000 байсан бол 2011 оноос тус хэмжээг 30%-иар нэмэгдүүлж 140400 төгрөг болгож нэмсэн. Ард иргэдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ тодорхой түвшинд нэмэгдсэн нь баярлууштайч нөгөө талаараа эрүүгийн хуулинд хуульчлагдсан торгох ял нь хөдөлмөрийн хөлснөөс хамааралтай байдаг учир торгуулийн хэмжээ асар их өсөх сөрөг хандлагатай юм. Торгуулийн хэмжээ өссөнөөр торгох ялын биелэлт эрс буурахад нөлөөлж байгаа юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын сүүлийн 5-н жилийн торгох ялын бодит биелэлтийн судалгааг авч үзэхэд:

---

[3] А.Лхагва Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй УБ хот 2009 он 321 дахь тал

[4] Тус номын 324 дахь тал

[5] Гэмт явдалтай тэмцэх асуудал сэтгүүл №1 УБ хот 2009 он 9-р тал

- 2008 оны торгох ялын биелэлт:Нийт 431 гүйцэтгэх хуудасны 235 нь буюу 54.5% нь бодьтой биелсэн.Биелүүлбэл зохих мөнгөн дүн 2218751.6 Бодитой биелүүлсэн мөнгөн дүн - 1224217.1 Биелэлтийн хувь – 55,2% Биелэгдээгүй үлдсэн мөнгөн дүн - 994534.5

- 2009 оны торгох ялын биелэлт: Нийт 182 гүйцэтгэх хуудасны 126 нь буюу 69.2% нь бодьтой биелсэн. Биелүүлбэл зохих мөнгөн дүн – 765781.5 Бодитой биелүүлсэн мөнгөн дүн – 285470.7 Биелэлтийн хувь – 37.3% Биелэгдээгүй үлдсэн мөнгөн дүн - 480310.8

- 2010 оны торгох ялын биелэлт: Нийт 248 гүйцэтгэх хуудасны 131 нь буюу 52.8% нь бодьтой биелсэн. Биелүүлбэл зохих мөнгөн дүнгээр124178.5 Бодитой биелүүлсэн мөнгөн дүн – 404827.3 Биелэлтийн хувь52.8% Биелэгдээгүй үлдсэн мөнгөн дүн - 836957,7-

- 2011 оны торгох ялын биелэлт: Нийт 307 гүйцэтгэх хуудасны 232 нь буюу 52.8% нь бодьтой биелсэн. Биелүүлбэл зохих мөнгөн дүнгээр 1646440.4 Бодитой биелүүлсэн мөнгөн дүн 1037834.1 Биелэлтийн хувь 75.6% Биелэгдээгүй үлдсэн мөнгөн дүн - 608606.3

- 2012 оны 01-р сарын торгох ялын биелэлт: Биелүүлбэл зохих мөнгөн дүнгээр 862023.3 Бодитой биелүүлсэн мөнгөн дүн 103664.4 Биелэлтийн хувь18,6% Биелэгдээгүй үлдсэн мөнгөн дүн - 758358.9

- 2012 оны 1-р улирлын торгох ялын биелэлт: Биелүүлбэл зохих 141 гүйцэтгэх хуудаснаас Бодитой биелүүлсэн 44 гүйцэтгэх хуудас биелэлтийн хувь 32.2%. Биелүүлбэл зохих мөнгөн дүнгээр 994296,3 Бодитой биелүүлсэн мөнгөн дүн 226581,2 Биелэлтийн хувь 22.8% Биелэгдээгүй үлдсэн мөнгөн дүн - 767715.1[6].

Дээрх судалгааны дүнгээс харахад ялын бодит биелэлт хангалтгүй бага хувьтай байгаа нь харагдаж байгаа юм.Торгох ялын биелэлт хангалтгүй байгаа нь Эрүүгийн хуульд торгох ялыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тогтоосон нь уг доод хэмжээ өсөхийн хирээр оноох торгуулийн ялын хэмжээ даган өсч байгаа, шүүхээс төлбөрийн чадваргүй этгээдэд торгох ял оногдуулж байгаа зэрэг бодит шалтгаануудтай холбоотойгоос гадна тухайн ялтны нуугдмал хөрөнгийг илрүүлэх, хөрөнгө битүүмжлэх ажиллагааг шийдвэр гүйцэтгэгч нараас хангалтгүй хийж байгаатай ч мөн холбоотой байдаг байна[7].

Хөдөлмөрчдийн цалингийн доод хэмжээг өсгөх нь гарцаагүй зөв. Гэхдээ үүнийг Эрүүгийн хуульд хамааралтайгаар нэмэх нь утгагүй гэдгийг хуульчид хэлдэг.

Тухайлбал, хулгайн үйлдэл 140 мянган төгрөгөөс доош хохиролтой бол Эрүүгийн хэрэг үүсгэхгүй. Иргэд халааснаас эсвэл орон байрнаасаа энэ хэрийн хохирол амсахад төр Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэхгүй харин Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу торгоод өнгөрч байгаа юм. Гэмт этгээд 130 мянган төгрөгийн эд зүйл хулгайлсан байхад 10 мянгаар торгоод суллана гэсэн үг. Үнэндээ, гэмт хэрэгтэй холбоотой хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамаарааД нийслэлд 140 мянган төгрөгөөс доош үнэтэй эд зүйл хулгайлдаг бүлэглэл бий болоход хүргээд байгаа юм.Өнгөцхөндөө хэрэг

[6] ШШГЕГ-н хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны мэдээ

[7] http://criminology.blogmn.net

үйлдсэн хүнийг хашрааж буй мэт дүр зураг харагдаж байгаа боловч цаанаа олон олон сөрөг үр дагавар дагуулдаг. Шуудхан хэлэхэд торгуулийн ял тухайн шийтгүүлсэн хүндээ хүнд тусдаг. Өмгөөлөгч нар үүнийг хийсэн хэрэгт нь тохирсон ял биш гэж үздэг. Тэгээд ч ял авсан этгээд торгуулийн мөнгөө төлөхийн тулд дахин хэрэг үйлддэг нь судалгаагаар нэгэнт батлагдсан[8].

Ер нь их хэмжээний торгууль төлөх ялаар шийтгэгдсэн ялтан гэмээ залруулсан нь цөөхөн. МУ-н эрүүгийн хуулийн 76-р зүйлд: Шийтгэх тогтоол биелүүлэх хугацаа өнгөрсөн тохиолдолд энэ хугацаанд өрөө төлөхгүй бол хорих ялыг биечлэн эдлэхээс өөр сонголтгүй болгож байгаа юм.Иймд торгох ялыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс шууд хамааралтай байгааг өөрчлөх нь зүйтэй юм.

Үүнээс гадна торгох ялыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай бас нэг асуудал нь Монгол улсын Эрүүгийн хуулийн хорин гуравдугаар бүлэгт хуульчлан зүйлчилж өгсөн Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг.Тус гэмт хэргийг өнөөгийн байдлаар хувь хүн гэхээсээ илүү хуулийн этгээд буюу аж ахуй нэгж байгууллага үйлддэг.

Учир нь Монгол улс байгалийн нөөц баялаг ихтэйгээрээ дэлхийд дээгүүр байр эзэлдэг.Тиймдээ ч гадны болон дотоодын уул уурхайн компаниуд ихээр сонирхож улсаас тэдгээр компаниудад тусгай зөвшөөрөл лицензийг хязгаарлалтгүйгээр олгосоор байгаа юм.Тусгай зөвшөөрөл лицензтэй үйл ажиллагаа явуулан байгалийн баялгийг ашигласан хэрнээ тус газраа нөхөн сэргээлтийн ажил хийдэггүй орхигдуулдаг. Байгаль орчны яамнаас холбогдох газруудтай хамтран 2009-2010 онд уул уурхайн олборлолт болон бусад үйл ажиллагаанаас эвдрэлд орж орхигдсон газрын тооллогыг Хэнтий, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Өмнөговь, Дархан Уул, Дорнод, Дорноговь, Говьсүмбэр, Дундговь, Сүхбаатар, Төв, Булган,Сэлэнгэ гэсэн 15 аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хийжээ. Эдгээрээс хамгийн их эвдрэлд орсон аймгууд нь Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Архангай, Дархан Уул, Хэнтий гэсэн 6 аймаг байгаа юм[9].



[8] www.FACT.mn

[9] Байгаль орчны яамнаас гаргасан 2010-2011 оны судалгааны эмхэтгэл

2010 оны байдлаар нөхөн сэргээлт хийгдээгүй нутаг

Аймаг	Нэгж талбар	Нөхөн сэргээлт хийгдээгүй газар /га/
Архангай	8	449.4
Хэнтий	47	402.1
Өвөрхангай	11	561.9
Баянхонгор	235	708.9
Өмнөговь	48	75
Дорноговь	93	28

Дээрх хүснэгтээс харахад нийт 434 нэгж талбарт 1872.01 га газар нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдсон байна. Харин 2011 оны дүнгээр Дархан Уул, Дорнод, Дорноговь, Говьсүмбэр, Дундговь, Сүхбаатар гэсэн аймгуудын 14 сумын 51 нэгж талбарт 690.3 га талбай, Төв, Булган, Сэлэнгэ аймагт 6 сумын 31 нэгж талбар 1422.15 га нөхөн сэргээгдээгүй орхигдсон байна. Нэгдсэн дүнгээр дээрх 15 аймгийн 56 сумын нутаг дэвсгэрт 2009-2010 онд нийтдээ 566 нэгж талбарт 3984.46 га газар эвдрэлд орж орхигджээ[10].

Судалгаа, тоо баримт юуг харуулж байгаа нь ойлгомжтой. Тухайн хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомж , болон нөхөн сэргээлт хийлгэх хяналт сул Эрүүгийн хуулинд хуулийн этгээдэд ял оногдуулах эрх зүйн зохицуулалт байдаггүй, зөвхөн торгох шийтгэл болон хариуцагч этгээдийг хорих ялаар шийтгэдэг тогтолцоо байдагтай хобоотой юм.Иймд олборлолт хийсэн газар нутагт нөхөн сэргээлт хийх нь зардал их гарах учир Эрүүгийн хуулинд заасан торгох ялаар шийтгүүлээд бага хэмжээний мөнгө төлөөд орхихыг хуулийн этгээдүүд илүүд үзэж байгаа юм. Эрүүгийн хуулинд заасан Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгийн торгох хариуцлага нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан байдаг нь хангалттай бус зүйл юм. Тиймээс Эрүүгийн хуулинд заасан Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн гэм буруутай этгээдэд оногдуулах торгох хариуцлагыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамааралтай байгааг өөрчлөх шаардлагатай.

Дүгнэлт

1.Монгол улсын торгох ялын биелэлт нь судалгаагаар хангалтгүй хувьтай гарч байгаа нь ялтны хөрөнгийн болон орлогыг судлалгүйгээр шууд оноох буюу төлбөрийн чадваргүй этгээдэд оногдуулж байгаа, мөн торгох ялын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамааралтай байдгаас тус хөдөлмөрийн хөлсний хэмжээ өсөхийн хирээр торгуулийн хэмжээ өсч байгаатай холбоотой юм.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өсөх явдал нь ард иргэдэд сайнаар нөлөөлөх ч эрүүгийн зарим гэмт хэргийг гэмт хэрэг биш болгож байгаа явдал харагдаж байгаа юм.Учир нь ард иргэд халааснаасаа болон бусад байдлаар 140400 төрөгнөөс доош эд юмс алдсан тохиолдолд Эрүүгийн хуулиар хамгаалагдахгүй гэсэн үг юм.Тухайн эд юмс хулгайлж иргэдэд хохирол учруулсан этгээдэд

[10] http://www.asu.news.mn

Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэх бус хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага гэх шалтгаанаар Захиргааны хариуцлагын тухай хуулиар бага хэмжээгээр торгуулаад өнгөрөх дүр зураг харагдаж байгаа юм.Улс орон хөгжихийн хирээр хөдөлмөр эрхлэгчдийн хөлсний доод хэмжээ өсөх нь гарцаагүй бөгөөд торгох ялын хэмжээ даган өсөж ялын цээрлүүлэлт хүчээ алдахад хүрэх сөрөг үр дагавартай юм. Иймд торгох ялын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамааралтай байгааг өөрчлөх нь зүйтэй юм.

2.Мөн Эрүүгийн хуулийн 23-р бүлэгт заагдсан Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн Эзэн холбогдогчид оногдуулдаг торгох ялын санкц нь 214-р зүйлийн 214.3-т онц их хэмжээний хохирол учруулсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 450-500 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан бөгөөд бусад заалтуудад дээд тал нь 250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр торгож байгаа нь хангалтгүй юм.Учир нь торгох ялын дээд хэмжээ нь 70сая 200 мянга болох бөгөөд тухайн олборлолт хийсэн хуулийн этгээд нь олборлолт хийсэн газраа нөхөн сэргээлт хийхэд шаардагдах хөрөнгө нь торгуулийн дүнгээс их тогтоогддог учир нөхөн сэргээлт хийхээс татгалзан торгуулийн мөнгийг төлөөд үлдэх боломжийг нээж өгч байгаа нь харагдаж байгаа юм. Иймд уул уурхай ашигт малтмалын үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдэд торгох ялыг оногдуулахдаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамааралтай байгааг сольж байгаль орчныг нөхөн сэргээхэд шаардлагатай мөнгөн дүнгээр торгодог болгох нь зөв зүйтэй зүйл юм.

Санал

1. Торгох ялын хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамааралтай байгааг сольж, тухайн этгээдийн өдрийн орлогын хэмжээгээр торгох

2.Торгох ялыг оногдуулахдаа ялтны эдийн засгийн байдлыг харгалзан оногдуулж байх.

3.Эрүүгийн хэрэгт тухайн этгээдийн хөрөнгийн байдлын тухай мэдээллийг дэлгэрэнгүй бодитой байдлаар тусгаж байх /мөрдөн байцаагч нар шүүхэд торгох ял оногдуулах боломжтой гэсэн тодорхойлолтод гаргаж өгч байх/.

4. Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтныг тогтмол орлоготой болгох үүднээс ажлын байраар хангах үйл ажиллгаанд төрийн болон төрийн бус байгууллагуудыг татан оролцуулах, урамшууллын тодорхой арга хэмжээ авах мэдээлэл солилцох

5.Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хүлээлгэх торгох шийтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамааралтай байгааг өөрчилж сүйдсэн газар нутгийг нөхөн сэргээхэд шаардлагатай мөнгөн дүнгээр торгож байх.

6.Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг үйлдсэн байгууллага хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг цуцлах хуулийн орчин бий болгох

ХОРИХ БАЙГУУЛЛАГААС СУЛЛАГДАГСДЫГ НИЙГЭМШҮҮЛЭХЭД ШШГБ-ЫН ОРОЛЦОО, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА



Цэдэвсономын Очгэрэл
Хорих 415-р ангийн дарга, дэд хурандаа, докторант

1.Хорих байгууллага дахь нийгэм сэтгэл зүйн ажил, цаашдын чиг хандлага

Түүх судлаачдын үздэгчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь1921 оны 7 дугаар сарын 10-ны өдрөөс Ардын түр засгийн газрын шийдвэрээр "Гяндан салаа" нэртэйгээр байгуулагдсан байдаг. Тэр цаг үеэс өнөөдрийг хүртэл хорих ял шийтгэгдсэн хоригдогсдыг хорих орчин нөхцөл, хөдөлмөр эрхлэлт, сургалттай холбогдсон үйл ажиллагаа тухайн цаг үеийн нийгмийн тогтолцооны онцлогоос шалтгаалан харилцан адилгүй хэрэгжүүлж ирсэн. Өнөөгийн ардчилсан, чөлөөт нийгмийн тогтолцоо бүхий улс орнуудад үндсэн хууль болон олон улсын эрх зүйн бичиг баримтаар хүний эрх, эрх чөлөөг дээдлэн баталгаажуулахын зэрэгцээ нийгмийн хамгийн үнэт зүйл болох хүний хөгжлийг эрхэм зорилго болгож байгаа ба энэ нь тухайн улсын хорих байгууллагын үйл ажиллагаанд хоригдогсодыг нийгэмшүүлэх ажлыг оновчтой зөв зохион байгуулах байдлаар хэрэгжиж байна.

Хууль Зүй Дотоод хэргийн яамны харьяа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тогтолцоонд нийгмийн ажилтан хэмээх албан тушаалтан нь нийгмийн шаардлагаар 2003 оны сүүлчээр бий болсон бөгөөд өнөөдрийн байдлаар хорих ангиудын хэмжээнд 82 нийгмийн ажилтан ажиллаж байна.

Дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдөхийн зэрэгцээ нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагааны талаар судалдаг манай эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагууд тодорхойлж байгаачлан нийгмийн ажил гэдэг нь: нийгэм болон хүмүүсийн сайн сайхны төлөө тэдгээрийн харилцаан дахь бэрхшээлтэй асуудлуудыг илрүүлж шийдвэрлэхэд туслах, хүнийг чадваржуулах, хөгжүүлэх явдлыг дэмжих мэргэжлийн үйл ажиллагаа юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь нийгэмшүүлэх ажлыг олон улсын жишигт нийцүүлэн Монгол улсын нөхцөлд тохиромжтой байдалд хэрэгжүүлэх зорилгоор 2000 онд Хууль Зүй Дотоод хэргийн сайдын тушаалаар "Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр", 2010 онд "Хорих байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн үйл ажиллагааны заавар"-ыг батлан гаргасан бөгөөд одоо эдгээр бичиг баримтыг хэрэгжүүлэхээр идэвхийлэн ажиллаж байна.

Хорих байгууллагын нийгмийн ажил буюу хоригдогсдод нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх ажлыг дараах хэлбэрээр хэрэгжүүлж байна.

Үүнд:

1.Хоригдогсдыг бүхий л талаас нь судлан, холбоо тогтоох

2.Хорих ял эдлэх, хоригдох явцад тулгарч буй ахуйн орчны болон бусад бэрхшээлийг даван туулахад дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, яриа таниулга хийх

3.Хоригдогсдын хувийн нөөц боломжийг илрүүлэх, тэдгээрийг чадваржуулах, хөгжүүлэх, сургалтуудыг зохион байгуулах

4.Хоригдогсдын сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөх, нөлөөллийн үйл ажиллагааг дотоод болон бусад албад, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлэх.

5.Хоригдогсдын хуулиар хориглоогүй эрхийг хангах, түүнийг гэмт хэрэг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх

6.Хоригдогсдыг нийгэмд суллагдан гарахад бэлтгэх, нийгмийн харилцаанд ороход сэтгэл зүйн болон эрх зүйн дэмжлэг үзүүлэх

2.Хоригдогчдыг суллагдан гарахад бэлтгэх үйл ажиллагаа

Хорих байгууллагын нийгмийн ажлын онцлог чухал хэсэг нь хоригдогсдыг нийгэмд суллагдан гарахад бэлтгэл үйл ажиллагаа юм.

Ялын хугацаа дууссан болон тэнсэн суллагдах нөхцлийг хангасан хоригдогсдыг нийгмийн амьдралд гарахад нь бэлтгэх ажлыг дараах хэлбэрээр зохион байгуулна. Үүнд:

1.Нийгмийн амьдралд гарах буюу бие дааж нийгмийн харилцаанд оролцоход шаардагдах бүхий л төрлийн мэдээллээр хангах

2.Үүсэн гарах бэрхшээлийг хэрхэн давах, гэр бүл орчинтойгоо хэрхэн харьцах талаар зөвлөгөө өгөх

3.Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран бичиг баримтжуулах, ажлын байр олгоход холбон зуучлах.

4.Суллагдахаас 6 сарын өмнө судалгаанд авч, нийгэмд гарахад нь бэлтгэх төлөвлөгөө гарган мэргэжлийн болон бусад сургалтанд хамруулах

3. Суллагдагсдыг нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулалтын ажилд оруулах санал /түүнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын оролцоо/

Хорих ангиас суллагдсан хүмүүсийн зүгээс дахин гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй суллагдсаны дараа нийгэмд байр сууриа олж чадахгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

2010 оны эцэст хорих ял эдэлж байсан 5700 ялтнаас анх удаагийн шийтгэлтэй 2751, дахин давтан шийтгүүлсэн 2949 байна.



Нас	Тоо
18-34 настай	3178
35-54 настай	2382
55-69 настай	117







Ялтны дунд явуулсан судалгаанаас /ярилцлагын чиглэлээр/ үзэхэд дахин гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж буй дараах шалтгаан нөхцлөөс дурьдвал:

1. Хүлээж авах орчин байхгүй.

- Очих газаргүй, орон гэргүй, төрөл садангүй

2. Амьдралын буюу амьжиргааны эх үүсвэр байхгүй

- Ар гэр нь өрхийн орлогогүй, хөрөнгийн чадваргүй

3. Суллагдаж буй хүмүүсийн хувийн онцлогтой холбогдолтой шалтгаан:

- Иргэний бичиг баримтгүй
- Боловсролгүй, мэргэжилгүй
- Амьдралын зорилгогүй, идэвхгүй, этгээд гаж сонирхолтой, донтой

4. Нийгмийн болон эдийн засгийн тогтолцоотой холбоотой шалтгаан:

- Ажилгүйдэл,
- Ядуурал
- Улс төр, эдийн засгийн хямрал гэх мэт.

Хорих ял шийтгэгдсэдийг суллагдахад бэлтгэх, хүлээж авах нийгэм эрх зүйн орчныг бүрдүүлэх, улмаар нийгмийн идэвхтэй зөв гишүүн болгон төлөвшүүлэх нь тэдгээрийг дахин гэмт хэрэг, захиргааны зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ хувийн болон гэр бүлийн цаашилбал нийгмийн хөгжилд үр дүнгээ өгөх ажил болох нь гарцаагүй юм.

Хорих ялаас хугацааны өмнө тэнсэн сулласан, хугацаа дуусч суллагдсан, хорих ялыг хойшлуулсан, тэнсэн харгалзсан хүмүүстэй хэрхэн ажиллах, тэдгээртэй холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэх зарчмаар дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх саналтай байна.

а.Хорих анги дахь хоригдогсдыг нийгэмшүүлэх суллагдахад бэлтгэх ажлыг мэргэжлийн түвшинд үр дүнтэй зохион байгуулах.

б.Суллагдахын өмнө буюу дараа амьдрах ухааны болон мэргэжлийн сургалтад хамруулж бие дааж амьдрах чадвар эзэмшүүлэхэд анхаарах.

в.Суллагдсан хүмүүсийг хүлээн авахад терийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь хамгаас чухал гэж үзэж байна.

Мөн гэмт хэрэгт холбогдон улмаар хорих ял эдэлсэн хүмүүсийг төлөвшүүлж хөгжүүлэхэд чиглэсэн ажил нийгэмд асар чухал ач холбогдолтой арга хэмжээ гэдгийг төрийн болон төрийн бус байгууллагууд бүхий л түвшинд дэмжих явдал чухлаар тавигдаж байна.

Суллагдагсдыг нийгэмшүүлэх тогтолцоог бүрдүүлснээр хүрэх үр дүн, нийгэм эдийн засгийн ач холбогдол талаас нь дурдвал:

- Нийгмийн харилцааг хамгаалах нөхцөл зарим талаас нь бүрдэнэ.
- Давтан гэмт хэрэг үлйдэх явдал буурна.
- Нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах бүтээн байгуулагч иргэн төлөвшинө.

Нийгмийн ухамсар



Нийгмийн соёл Нийгмийн төлөвшил

Нийгмийн ухамсар, соёл, төлөвшилд сөргөөр нөлөөлж буй шалтгааныг олж илрүүлэн арилгах боломж бүрдэнэ.

Суллагдсан хүнийг хүлээн авахад төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог дараах байдлаар тодорхойлж болох юм.

1.ШШГБ-нь хоригдогчийг нийгэмшүүлэх нийгэмд гарахад нь бэлтгэх

Хорих ял эдэлж байх хугацаанд шоронжиж байна гэж үзвэл үүнийг таслан зогсоох чиглэлээр:

- Стандартыг хянах /орчны/
- Нийгэмшүүлэх ажлыг эрчимжүүлэх
- Төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх
- АБХ-ийн асуудлыг цогц хэлбэрээр шийдвэрлэх
- Бусад буюу мэдээлэл өгөх

2.Цагдаагийн байгууллага нь суллагдсдад хууль зүйн талаас нийгмийн харилцаанд ороход зөвөлгөө өгөх гэмт хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх

3.Иргэний бүртгэлийн байгууллага :

Суллагдахын өмнө буюу дараа бичиг баримтжуулах шаардалагатай лавлагааг гаргаж өгөх

4.Орон нутгийн засаг захиргааны байгууллага :

- Харъяа иргэдийн дунд судалгааны хүрээнд хорих ялаар шийтгэгдсэн хүмүүсийн судалгааг нарийвчлан гаргаж төрсний гэрчилгээ, бусад шаардлагатай бичиг баримтаар хангах
- Ар гэрт нь хандсан нийгмийн ажлын үйлчилгээг зохион байгуулах
- Сум хорооны нийгмийн ажилтан суллагдагсдыг хүлээн авах, хорооны байцаагч, нийгмийн ажилтан нартайгаа холбоотой ажиллах, тэднийг ажилд зуучлах
- Тухайн орон нутагт оршин буй хорих байгууллагын үйл ажиллагаа хоригдогчийн нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх зэрэгт хамтран ажиллах
- Суллагдсан хүмүүсийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд нийгмийн халамжийн болон хөдөлмөрийн газрууд олон нийтийн байгууллагууд бусад төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах зэрэг маш чухал үүрэгтэй оролцох.

5.Төрийн бус байгууллагууд: Дээрхи үйл ажиллагааг дэмжин хамтарч ажиллах

6.Нийгмийн халамжийн болон хөдөлмөрийн байгууллагууд: Суллагдсан хүмүүст мэргэжлийн боловсрол олгох ажлын байраар хангахад зуучлан дэмжих, орон байр болон бусад нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжиж оролцох.

Эндээс дүгнэхэд суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх зорилгоор дээрхи төрийн болон төрийн бус байгууллага нь хамтын ажиллагааны гэрээ байгуулах эсхүл хамтарсан ажлын зөвлөл, баг байгуулан ажиллах замаар нягт хамтарч ажиллах тодорхой тохиолдолд хариуцлага хүлээлгэх тогтолцоог бий болгож ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

Хорих байгууллага суллагдагдсдын дундаас тодорхой хэсгийг буюу оршин суух

хаяггүй, амьжиргааны эх үүсвэргүй, төрөл садан, ар гэргүй, хүмүүсийг хүлээн авах төв бий болгох. Энэ төвийн санхүүжилтийг төсвөөс болон хандив тусламжийн эх үүсвэрээс шийдвэрлэх ба хэрэгжүүлэх байгууллагаар энэ чиглэлд ажиллаж чадах төрийн бус байгууллагыг ажиллуулах.

Суллагдагсдыг хүлээн авах төв нь:

- Сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх
- Мэргэжлийн сургалтын холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах,
- Ажлын байранд зуучилж өгөх,
- Бичиг баримтжуулах орон гэртэй болгох бусад бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэж өгөхөд туслах,
- Цагдаагийн байгуулагатай хамтран урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийх зэрэг үйл ажиллагаа хийдэг байвал зохино.
- Үйл ажиллагааны зохион байгуулалт санхүүгийн, харилцаа зэргийг судалгаа явуулж хэлэлцэн шийдвэрлэх
- Ажил олгогч төрийн болон төрийн бус байгууллагуудад тавигдах шаардлагад хорих байгууллагаас суллагдагсдыг ажлын байраар ханган ажиллуулах талаар шийдвэрлэх,
- Хувь хүнийг ажилд ороход болон бусад бүхий л тохиолдолд материал бүрдүүлэхэд урьдах ял шийтгэлийн нарийвчилсан тодорхойлолтыг бус сум, хорооны нийгмийн ажилтан, хэсгийн байцаагчийн тухайн хувь хүний сэтгэл зүй, цаашдын хөдөлмөрийн чадварын түвшинг тогтоосон тодорхойлолтыг үндэслэн авдаг тогтолцоог бий болгох,
- Нийгмийн ухамсарт нөлөөлөх зорилгоор суллагдагсдыг нийгэмшүүлэх орчинг бүрдүүлэхэд шаардлагатай сургалт, сурталчилгааны ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол явуулах,
- Дээрхи ажлуудыг үр дүнтэй зохион байгуулах зорилгоор санал бүрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг бий болгох:

ГЭР БҮЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗАРИМ ТУЛГАМДСАН АСУУДАЛ[1]



Сайнбуянгийн Баасандорж
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн
231-р дамжааны сонсогч

“Хайраар бялхсан хурим, итгэлээр дүүрэн гэрлэлт бүхэн гагнаж цутгасан ган болдноос ч илүү бат бөх байх болтугай”.

Судалгааны хэрэгцээ шаардлага:

Хүний эрх, эрх чөлөөг дээдлэх үзэл санаанд суурилсан эрх зүйн шинэтгэл Монгол улсад сүүлийн 15 жилд хийгдэж өнөөч үргэлжилсээр байна. Шинэтгэлийн үр дүнд Монгол улсад хүний эрхийг хамгаалах эрх зүйн үндэс бүрдсэн. Гэхдээ үүнийг хараахан эрх зүйт төрийн шаардлагад нийцсэн хүний эрхийг хамгаалах тогтолцоотой болсон гэж үзэх боломжгүй юм. Эрх зүйт ёсны гол зорилго бол хувь хүнийг хамгаалах явдал юм.

Бид төрөлх Монгол орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм байгуулах эрх зүйт төрийг төлөвшүүлэх эрхэм зорилгыг Үндсэн хуульдаа тунхагласан билээ. Өнөөдөр хүний эрх олон янзын хэлбэрээр зөрчигдөж байгаа бөгөөд түүний дотор гэр бүлдэх гишүүдийн эрх далд нууц хэлбэрээр хамгийн их зөрчигдөх болсон байна.

Монголчууд “Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас” гэлцдэг нь нийгмийн хөгжилд хэн хувь нэмэр оруулах, энэ үйл явцыг хаанаас, ямар дараалаар хувь хүн жолоодох ёстойг тун оновчой тодорхойлсон гэж болно.

Гэр бүл өөрөө хүний хөгжлийг анхдагч орчин. Гэтэл гэр бүлийн нэг гишүүн нь нөгөөгийнхөө эрх, хууль ёсны ашиг сонирхолыг зөрчиж, махбод, сэтгэл санаа, бэлгийн болон эдийн засгийн хүчирхийлэл, дарамтанд оруулах явдал нийгмийн эмзэг асуудал, асар их хор уршиг бүхий сөрөг үзэгдэл болоод байгааг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, энэ сөрөг үзэгдлийн хохирогч нь ихэнхдээ эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настангууд болж байдгийг олон улсын байгууллагуудын албан ёсны баримт бичигт цөөнгүй дурдсан байдаг.

[1] Их дээд сургуулийн сонсогч, оюутнуудын дунд зохион байгуулагдсан “Хуулийн оюутан-2012” эрдэм шинжилгээний хурлаар тэргүүн байрт шалгарсан илтгэл

Хүний эрхийг хангах баталгаа түүнийг бүрэн хэрэгжүүлж чадах төр бол эрх зүйт төр гэж хүн төрөлхтөн бүгд санал нэгдэх байх.

Гэр бүлийн хүчирхийлэл Монгол орны хувьд ч түгээмэл байгаа бөгөөд сүүлийн үеийн судалгаагаар нийслэлийн анхан шатны шүүхээр таслан шийдвэрлэсэн хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн 20 орчим хувь нь гэр бүл, ахиун хүрээндэх хүчирхийлэлтэй байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гарсан аливаа хэргийг эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийг баримтлан бусад хэргийн жишгээр шийдвэрлэж байгаа нь гэр бүлийн хүчирхийлэл сэтгэл зүйн болон эдийн засгийн харилцан хамаарал бүхий хүмүүсийн хооронд үйлдэгддэг, хохирогч хүчирхийлэгчтэй нэг орчинд амьдарч түүний эрхшээлд байдаг төдийгүй, хүчирхийлэл нууц байдлаар удаан хугацааны туршид үргэлжилсэн шинжтэй үйлдэгддэг зэрэг өвөрмөц онцлогт нийцэхгүй байна.

Иймээс хүчирхийлэл үйлдэгчдэд хүлээлгэж байгаа хариуцлага, арга хэмжээ нь хохирогчын хохирлыг барагдуулах нь байтугай эргээд сөрөг нөлөө үзүүлэхэд хүрч байна. Ийм учир Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх олон улсын практик, хандлага, улс орнууд энэ асуудлыг шийдвэрлэх талаар ямар хууль баталж, үйл ажиллагаа явуулж байгаа талаарх мэдээллийг төрийн шийдвэр гаргагч болон орон нутгийн удирдлага, төрийн бус байгууллагууд, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх явдал чухал байгаа юм.

Гэр бүлийн хүчирхийллийн асуудал нь асар их хор хохирол учруулж, хүний эрхийг ихээхэн зөрчиж , цаашлан аюултай гэмт хэрэгч үйлдэгдэхэд хүрч байгааг анхаарах цаг нэгэнт болжээ. Манай улсад албан бус судалгааны хүрээнд гурван гэр бүл тутмын нэгд гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр байгаа гэж үзэж байна.

Судалгааны зорилго, зорилт:

Хүний эрх тэр дундаа гэр бүлийн гишүүдийн эрх зүйн байдал гэр бүлийн хүчирхийлэл гэж юу болох ямар сөрөг нөлөөтэй гэдгийг судалж хүний эрхэд ноцтой зөрчил бий болгож байгааг хууль зүйн шинжлэх ухааны үүднээс хандан эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хууль тогтоомж, хэрэгжилтийг хянах бүтэц, механизмыг судлан түүнийг хэрхэн үр нөлөөтэй болгох талаар санал гаргах гол зорилго тавьж байна.

Зорилгын хүрээнд зорилт нь:

Дээрх зорилгыг дараах зорилтын хүрээнд судалсан болно.

1.1. Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт

1.2. Гэр бүлийн хүчирхийлэл дэлхий дахинд тархсан байдал

2.1. Монгол улс дахь гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн байдал

2.2. Гадаад орнуудын гэр бүлийн хүчирхийллийн байдал, түүний эрх зүйн

зохицуулалтууд түүнийг өөрийн оронтой харьцуулан үзсэн тухай

3.1. Гэр бүлдэх хүчирхийллийн тухай НҮБ-ийн зөвлөмж түүнд Монгол улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нийцсэн байдал

Судалгааны арга, арга зүй:

Энэхүү судалгааг хууль зүйн норматив болон, судалгааны ерөнхий арга болон харьцуулалтын аргыг ашигласан болно.

Судлагдсан байдал:

Гэр бүлийн хүчирхийлэл харьцангуй шинэ ойлголт бөгөөд энэ талаарх ойлголт иргэдийн дунд ховор төдийгүй уг асуудал нь өөрөө их зөрчилтэй байдалтай байдаг.

Гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар НҮБ-н эмэгтэйчүүдийн хөгжлийн сан санхүүжүүлэн Иргэдийн Алъяанс төв, Хүний эрхийн хөгжил төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвүүд судлагаа хийсэн байна. Мөн Монголын нээлттэй нийгэм хүрээлэн, Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбоо, Хүний эрхийн үндэсний комисс энэ талаар судалгаа явуулсан байна.

Гэр бүлийн эрх зүйн зарим тулгамдсан асуудал

Нэгдүгээр бүлэг

1.1. Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт

Хүний эрх гэдэг бол хүн болж төрснийхөө ачаар бий болдог, хүн бүрт заяасан эрх бөгөөд хүний эрхийн гэрээнд нэгдэн орсон, соёрхон баталсан аливаа улс орны төр засгийн газар хүний эрхийг хамгаалах, түүнд чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байдаг.

Сүүлийн жилүүдэд Монголчуудын дунд **“гэр бүлийн хүчирхийлэл”** гэсэн нэр томъёо харьцангүй танил сонсогдох болж энэ чиглэлээр иргэд, төрийн албаны ажилтанууд ярьж, бичих болжээ.

Түүгээрч барахгүй төрөл бүрийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд ч гэр бүлийн хүчирхийлэлийн талаар төсөл хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах сонирхол өссөн байна.[1] Өртөгч субъектүүд нь ихэвчлэн бага насны хүүхэд, өндөр настангууд, эмэгтэйчүүд байдаг байна.

Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь нөгөөгөө хүч хэрэглэн эрх мэдлээ давамгайлж, бие махбодь, сэтгэл санаа, бэлгийн харилцаа, эдийн засгийн хувьд хохирол учируулж,

[1] Гэрбүлийнхүчирхийллээсурьдчилансэргийлэхаргазам. Монголынноэлттэйнийгэмхүрээлэн, Монголынхуульчэмэгтэйчүүдийнхолбоо, Хүчирхийлэйнэсрэгүндэснийгтев. УБ2003он Гэрбүлийнхүрээндэхүчирхийлэлхувьхүмүүсийнхооронднотоодасуудал, зөвхөндоодтүвшний хүмүүсийн амьдралд байдаг мэтээр үздэг нийгмийн сэтгэл зүйд өөрчлөлт гарч байна.

доромжлон, хүч хэрэглэж байдаг гэр бүлийн хүчирхийлэл нь нийгэмд бодьтойгоор оршин хувь хүн, нийгмийн тодорхой хэсгийн эрх ашгийг зөрчиж байгааг гэр бүлийн хүчирхийлэл гэж тодорхойлсон байна.[2]

Гэр бүл дэх хүчирхийлэл нь хүний хувийн амьдрал, амин хувийн нууцтай холбоотой байдаг тул маш эмзэг асуудал.[3]

1.2. Гэр бүлийн хүчирхийлэл дэлхий дахинд тархсан байдал

➢ Дэлхий Банкны үнэлгээгээр, аж үйлдвэр хөгжсөн орнуудад өрөнхий үзүүлэлтээрээ 15-44 насны эмэгтэйчүүдийн үхлийн 19 % нь хүчиндэлт болон гэр бүлийн хүчирхийлэлээс болсон байна. Энэ нь нас барж буй энэ насны 5 эмэгтэйн нэг нь хүчирхийлэлийн үйлдлийн үр дагавар болох бэртэл, өвчинөөр амь үрэгдэж байна.

➢ Англид 2000 оны 10 сард явуулсан судалгаагаар, 60 секунт тутамд гэр бүлийн хүчирхийлэлийн хэргээр цагдаа дууддаг байна. Цагдаа өдөрт 1300, жилд 570000 гаруй тооны гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой утасны дуудлагад хариу өгдөг байна.

➢ АНУ-д эмэгтэйчүүдийн 40% нь доромжлолд өртөж байна.

➢ Японы эмэгтэйчүүдийн 59% нь хамтран амьдрагчийнхаа зүгээс бие махбодийн хүчирхийлэлд өртөж байна. Японд улсын хэмжээний анхны санал асуулгын дүнд эмэгтэйчүүдийн 14% нь хамтран амьдарч байгаа залуудаа эмнэлгийн тусламж шаардлагатай болтол зодуулжээ.

➢ Энэтхэг болон Шири-Ланкад жил тутамд 5000 гаруй эмэгтэй инжнээс болж аллагын хохирогч болж байна. Энэтхэгт явуулсан социологын санал асуулгад 90000 энэтхэг эмэгтэй оролцжээ. Тэдний 56 орчим хувь нь гэр бүлийн хүчирхийлэлийн тодорхой нөхцөл байдалд байдаг гэжээ. Ер нь эмэгтэйчүүдийг буруутгаж болох 6 нөхцөл байдлын ядаж аль нэг нь заавал болж байдаг байна. Үүнд: хүүхдийг муу арчилсан, ажахиугаа муух өтлөх , хань ижилээсээ урвасан хэмээн сэжиглэгдэх, эцэг эхэд үл хүндэтгэл илэрхийлэх , хоол муу хийдэг гэх зэргээр.

➢ Статистикчдын үнэлгээгээр, дэлхийд жил тутам 600 сая эмэгтэй янз бүрийн хэлбэрийн доромжлол, хүчирхийлэлээс үүдсэн зуурдын үхлээс болж нас барж байна.

Жишээ нь: Орос оронд жил бүр 14000 орчим эмэгтэй гэр бүлийн хүчирхийлэлээс болж нас барж байна. Харьцуулалт хийхэд Афганистан дахь дайны арван жилд 13000 мянга орчим Орос цэрэг нас барсан. 1997 онд Литвад 16-аас дээш насны эмэгтэйчүүдийн 63% нь эр нөхрийн зүгээс үйлдсэн бие махбодын буюу сексийн хүчирхийлэлийн хохирогч болсон байна. Тажикстанд эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь гэр бүлийн хүчирхийлэлд

[2] Хүний эрхийн олон улсын нэр томъёоны гарын авлага Х.Виктор Кондэ.

[3] Annual Report on Equal Opportunities For Women and Men in the European Union 2000 ,Report From the Commission to the Council, tne Europen Parliament

өртөж, эхнэрүүдийн 47 орчим хувь нь эр нөхөрийнхөө хүчиндэлтэнд өртсөн байна.[4] Харамсалтай нь, гэр бүлийн хүчирхийлэлд зааг хязгаар үгүй юм. Хүчирхийлэл хэмээх энэ нийгмийн энэ эмгэгийг үндсээр нь устгахад хүч чармайлтаа чиглүүлэх нь зүй ёсны асуудал болсон байна.[5]

Хоёрдугаар бүлэг

2.1. Монгол улс дахь гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн байдал

Монгол улсын Үндсэн хуулинд хүн бүр тэгш эрхтэй гэж тусгаж [6] өгсөн ба **Хүний эрхийн түгээмэл тунхаглалын гуравдугаар зүйл** Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй.[7] **Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактад** энэ пактад оролцогч улсууд түүнд заасан иргэний болон улс төрийн бүх эрхийг эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш эрх эдлүүлэх эрхтэй.[8] гэж мөн **Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад** оролцогч улсууд арьс үндэс, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн байдал, нөхцөл байдлаар ялгаварлахгүйгээр энэхүү пактад тунхаглан зарласан эрхийг хэрэгжүүлэх баталгаа гаргах нь зүйтэй. [9] гэж олон улсын гэрээ конвенцуудад тусгаж өгчээ. Монгол улсын Үндсэн хуульд олон улсын гэрээ хүлээсэн үүргээ өөрийн хууль тогтоомжын нэгэн адил дагаж мөрдөнө гэж заасан нь бодит байдал хэрэгжихгүй байна **энэ бол Монгол улсын өнөөгийн байдал.**

Гэр бүлийн хүчирхийлэл нь Монгол орны хувьд ч нэлээд түгээмэл байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд гарсан гэмт хэрэг, зөрчил гэр бүл, аж ахуйн хүрээнд үйлдэгдэх явдал өсөж байгаа нь гэмт хэрэг гарах орчин нууцлагдаж, аж ахуйн хязгаарлагдмал хүрээнд үйлдэгдэж байгааг нотолж байна. Гэр бүлийн хүчирхийлэл нь эмэгтэйчүүд, хүүхдийн эрх ашгийг ихээхэн хохироож байдгаараа нийгмийн хамгийн эмзэг асуудлын нэг мөн.

Гэтэл хууль хяналтын байгууллагад мэдэгдээгүй, нууцлагдмал байдлаар үйлдэгдэж, үргэлжилсээр байгаа хүчирхийлэлийг бид бодиттоогоор, албан ёсоор хэлж чадахгүй байгааг бас харгалзан үзэх ёстой.

НҮБ-н Эмэгтэйчүүдийн сангаас явуулсан "Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба эрх зүйн орчин, Монгол Улс "судалгаанд сүүлийн 3 жилийн байдлаар Улаанбаатар хотод

[4] Гэр бүл, ахуйн хүрээндэх хүчирхийлэл, түүний эрх зүйн зохицуулалт, өнөөгийн байдал, хууль тогтоомжыг боловсронгуй болгох асуудал П.Цэцгээ.

[5] Региональная информационная кампания ФНИФЕМ

[6] Монгол Улсын Үндсэн хууль УБ хот 1992 он

[7] Хүний эрхийн түгээмэл тунхаглал

[8] Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пакт

[9] Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт

гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, хүчиндүүлсний улмаас 1037 охид, эмэгтэйчүүд шүүх эмнэлэгт хандсанаас 326 хэргийг нийслэл, дүүргийн шүүх шийдвэрлэжээ.

Гэр бүлийн хүчирхийлэл гарах шалтгааныг авч үзвэл гэр бүлийн хэрүүл маргаан 51,2%, хардалт 24,8%, архидалт 24%-ийг эзэлжбайна.[10]

А. Хүчирхийлэл үйлдэгчид:

Улаанбаатар ходот гэр бүлийн хүрээнд гарсан гэмт хэргийн судалгаанаас үзвэл хүчирхийлэгч нь нөхөр 64.1% , салсан нөхөр 2.8%, хамтран амьдрагч 3.4% , үерхдэг найз 7.1% , эцэг 4.9% зэрэг байна.[11]

б. Насны байдлаар авч үзвэл:

Хамгийн их хувийг 25-39 насныхан 44.2% эзэлж байгаа бөгөөд үүнээс 25-39 насныхан 20.9%-ийг , 30-34 насныхан 23.3%-ийг тус тус эзэлж байна. 40-өөс дээш насны эрчүүд бага бус хувийг эзэлж байгаа нь гэр бүлийн хүчирхийлэгч нь голчлон дунд орчим насныхан байдаг гэсэн дүгнэлт өгч боломгүй байна. **Харин ахих тусам ухаан сууж байх хүмүүс эсрэгээр 25 наснаас дээш нас ахих тусам хувийн жин өсөх хандлагатай байна.[12]**

В. Боловсролынтүвшингээрньавчүзвэл:

Гэр бүлийн хүчирхийлэгчдийн 33.4% нь бүрэн бус дунд, 31.6% нь бүрэн дунд боловсролтой хүмүүс байна. Дээд боловсролтой хүмүүсийн дунд ч гэр бүлийн гишүүдээ дарамтлах, эхнэрээ зодох, хорьж цагдах явдал бодит амьдралд их байдаг. Судалгаанаас үзхэд гэр бүлийн хүчирхийлэлийн улмаас хохирогчдын талаас илүү хувь нь хүчирхийлэгчийн эхнэр, 10 орчим хувь нь ээж нь байна.[13]

Г. Гэмт хэрэгт эзлэх хувь:

Гэр бүлийн хүчирхийлэгчид эхнэр болон ээж, охин, найз бүсгүй, эгч дүүгийнхээ эрүүл мэнд, бие махбодид нь халдан амь насыг нь зэрлэгээр хохироох явдал шүүхийн шийдвэрлэсэнний тэрүүгийн гэмт хэргийн 50-иас илүү хувийг эзэлж байна. **Үүнд:** Бие махбодийн дарангуйллын цаана гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй бүх эмэгтэйчүүд сэтгэл санааны хохирол эдэлдэг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Эхнэр болон найз бүсгүй, охиноо алхаар буюу хүнд гэмтэл учируулахаар занал хийлэх, хэрцгий харьцсаны улмаас эхнэрийнхээ амь насаа хорлоход хүргэсэн гэмт хэрэгч гарсан байна.[14]

Д. Шийтгэгдсэн байдал:

---

[10] Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлийн тоо баримт , ХЭҮТ,

[11] Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба эрх зүйн орчин. Монгол Улс НҮБ-ийн эмэгтэйчүүдийн сан. УБ 2002 он

[12] "Хууль дээдлэх ёс"ХЗҮТ 2005 он

[13] Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба эрх зүйн орчин. Монгол Улс НҮБ-ийн эмэгтэйчүүдийн сан. УБ 2008 он

[14] "Хүний эрх ба хөгжил" сэтгүүл УБ 2001 он, №3

Улаанбаатар хотод хийсэн судалгаараар гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэнийхээ төлөө шийтгэгдсэн байдлыг үзвэл хүчирхийлэгчдийн 50 гаруй хувь нь 0-2 жилийн хорих ялаар шийтгэгджээ. Засан хүмүүжил хийлгэх талаар 0.5% шийтгэгдсэн байна. Харин сүүлийн жилүүдэд 6-аас дээш жилээр хорих ял эдэлж байгаа нь онц ноцтой гэмт хэрэг, өөрөөр хэлбэл, Эхнэрийнхээ амь насыг хохироох, хүнд гэмтэл учируулах явдал ихэссэнтэй холбоотой байна. Гэр бүлийн байнгийн дарамтанд байх эмэгтэйчүүд гэмт хэрэг үйлдэх болсон байна. Хүчирхийлэл дарамтаас залхсан тэвчих аргагүй байдалд хүрч амь насыг нь хөнөөж 15-аас дээш хорих ял эдэлж байна.[15]

Гэр бүлийн хүчирхийлэлд ихэвчлэн хүүхэд, өндөр настан, эмэгтэйчүүд хохирч болж байгаа ба тэдний эрх ашгийг мөн хамгийн их зөрчиж байгаа нь гэр бүлийн хүчирхийлэл юм. Учир нь хүчингийн гэмт хэргийн хуульчлагдаагүй хэлбэрүүд болох гэрлэгсдийн, ураг төрлийн болзооны хүчингийн өнөөгийн нөхцөл байдлыг сайн тодорхойлж үүнд дорвитой арга хэмжээ авагдахгүй байна.[16]

Одоо хүртэл гэрлэгчдийн хүчин , болзооны хүчингийн талаарх хуулийн ойлголт тодорхойлолт гараагүй мөн гэрлэгчдийн хүчин гэсэн нэр томъёо огт байхгүй байна. Ураг төрлийн хүчин гэр бүлийн хүрээнд өргөн байдаг хэмээн судалгаанд оролцогчдын 10 хүн тутмын 4 нь үзсэн бөгөөд хойд эцэг, дагавар охиноо хүчиндэх нь элбэг /76%/ гэж үзсэн байна. Хуулийн байгууллагуудын судалгаанд оролцогчдын үзсэнээр хүчингийн гэмт хэрэг гарах хамгийн гол үндсэн шалтгааныг бэлгийн боловсрол эзэмшээгүй явдал /90,7% гэж тодорхойлсон байна. Энэ нь бэлгийн боловсролын талаар мэдлэг дээшлүүлэх сургалт дутагдаж байгаагын нэг илрэл мөн юм.[17]

2.2. Гадаад орнуудын гэр бүлийн хүчирхийллийн байдал, түүний эрх зүйн зохицуулалтууд түүнийг өөрийн оронтой харьцуулан үзсэн тухай

Өрнөдийн ардчилсан орнуудад гэр бүлийн хүчирхийлэлийн асуудлыг дуугүй өнгөрөөхөө больж улс төрийн шинжтэй хэлэлцэх асуудлын тоонд оруулах үйл явц 70-аад онд феминистүүд, олон нийтийн идэвхтэнүүд, гэр бүлийн хүчирхийлэлд хохирогч эмэгтэйчүүдийн өөрсдийнх нь хамтын үйл ажиллагааны чармайлтын үр дүнд бий болсон байна.

1990 оноос бүх дэлхийн улс орнуудын засгийн газрууд гэр бүлийн хүчирхийлэлийг нийгмийн **"ноцтой асуудал"** хэмээн хүлээн зөвшөөрч, түүнийг шийдвэрлэх арга зам хайж эхэлсэн. Дэлхийн олон оронд гэр бүлийн хүчирхийлэлийн талаар явуулсан судалгаанаас тоо баримт нь ихэнх тохиолдолд эмэгтэйчүүд хүчирхийлэлийн хохирогч болдог гэдгийг

[15] "Хүний эрх ба жендэр "ХЭҮД. УБ 2002

[16] Хүчингийн гэмт хэргийн хуульчлагдаагүй хэлбэрүүд "Судлаач Л.Бадамцэцэг, ХЭҮТ-ийн ажилтан

[17] Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын хэрэгцээ ХЭҮТ-ийн ажилтан Ч.Гэрэлмаа

баталсан байна. **Жишээ нь:**

Их Британид бие хүний эсрэг гэмт хэргийн 25 хүртэлх хувь нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой байна. Мөн түүгээр барахгүй зөрчилийн талаарх цагдаагийн дуудлагын бараг 90 хувь нь нөхөр нь эхнэрээ, найз залуу нь найз охиндоо гаргасан түрэмгий зангийн дуудлага байсан нь илэрчээ.[18]

Өнөөдрийн байдлаар, дэлхийн 40 гаруй улс орон гэр бүлийн хүчирхийлэлийг хоргилсон ямар нэгэн хуультай байна. Дэлхий дахины туршилгаас асуудлыг хууль тогтоомжын замаар шийдвэрлэвэл ихээхэн үр дүнтэй байдаг. Гэхдээ олон улсын практикт авсан нэн чухал санамжууд.

1.Тусдаа бие даасан хууль байх нь илүү үр ашигтай. Хууль нь үйлчилдэггүй, де-юребаде-фактогийн хооронд ихээхэн хийдэлтэй орнуудад бас нэг ажиллагүй хууль гаргах нь утга учиргүй гэсэн санал байдаг. Харин хууль ядахдаа "бэлэг тэмдэг" болоод ч гэсэн байж байх нь гэр бүлийн хүчирхийлэлийн талаарх мэдлэгийгн эмэгдүүлж мөн гэр бүлийн хүчирхийлэлийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлж тэр дундаа тусдаа хууль байх нь энэ асуудлыг байгааг хүлээн зөвшөөрч байгаагараа тус нэмэр болж мэдлэг дээшлэх, гэр бүлийн хүчирхийлэлээс болж хохирогсдод хүчирхийлэлтэй тэмцэх арга замыг нь зааж өгдөг.

2.Тусад нь хууль боловсруулж гаргахын өмнө хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нэлээд их боломж байдаг. Үүнтэй холбогдсон, Тусгаар тогтносон орнуудын Холбооны гишүүн орнуудад өнгөрсөн үеэсээ залгамжлан авсан хууль зүйн хэрэгсүүлд бий. Жишээ нь олон улсын шинжээчдийн саналаар, чадварлаг хэрэглэвэл гэр бүлийн хүчирхийлэлийг багасгахад нөлөөлж чадах захиргааны баримчлах арга хэмжээ байна.[19] Лондоны их сургуулийн экологи, нийгмийн шинжлэх ухааны факультетын дэргэдэх хүүхэд, эмэгтэйчүүдийн талаарх хүчирхийллийг судлах Нэгдлийн профессор Лиз Келлийн тэмдэглэн хэлснээр хуулиуд чиглэлээрээ ялгаатай байдаг гэжээ. Тэрээр ингэж бичсэн байна.[20]

➢ Зарим хууль анхны удаа үйлдсэн эрх зүйн зөрчилд хамгаалалтын шийдвэр хэрэглэх боломжтой иргэн-эрх зүйн арга хэмжээгээр хязгаарлагдаж /Финлянд, Испани/ эсвэл гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хэмээн буруутгагдсан этгээдийг хүүхдүүдтэйгээ харьцахыг нь хязгаарлах арга хэмжээгээр хязгаарлагддаг.

➢ Өөр бусад хуулиуд хамгаалалтын шийдвэр хэрэглэх боломж ба дотоод хэрэг эрхлэх байгууллагуудын бүрэн эрхийг өргөтгөсөн. /Австри, Ирланд/

➢ Зарим хуулиуд иргэний байцаан шийтгэх болон эрүүгийн байцаан шийтгэх арга

[18] Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлийн бүх хэлбэрийг устгах судалгаа УБ 2007 он

[19] Гадаад орнууд дахь гэр бүлийн хүчирхийлэл, түүний эрх зүйн зохицуулалдын байдал. Х Оюунцэцэг

[20] Western stantarts for fost communist women Egual Opportunities for Women and Men.

хэмжээнүүдийг нэгтгэн нийлүүлсэн /Кипр, Мексик, Никарагуа, АНУ-н зарим муж улс/

➢ Зарим хуулиуд эрүүгийн шинэ хэргүүдийг оруулсан буюу гэр бүлдээ үйлдсэн гэмт хэргийн төлөөх ял шийтгэлийн арга хэмжээг цуцалсан /Бельги, Франц, Испани, Швед/

➢ Нөгөө зарим хуулиуд нь хуульд хэрхэн өөрчлөлт оруулахыг, төрөөрөө тусламжын алба байгуулах, мөн түүнчлэн төрийг ашиглан төрийн нэрийн өмнөөс хүчирхийлэл үйлдэх үйлдлийг ор мөргүй арилгах, мөн урьдчилан сэргийлэх төсөлд хөрөнгө мөнгө гаргах тухайд хүлээх хариуцлагыг ч тусгаж өгсөн“ цомхон хуулиуд ”байдаг / Кипр, Австри, Дани, Финлянд, Швед/

Мөн Шинэ Зеланд, Австри хоёр улс нь гэр бүлийн хүчирхийлэлийн тухай нэлээд“шинэтгэн сайжруулагч” хуультай ажээ. ”Австрийн хууль, цагдаагийн байгууллагадаа, хэрвээ үнэхээр гэмт хэрэг үйлдсэн, мөн давтагдаж болзошгүй гэж үзэх бүхийл үндэслэл байгаа бол хүчирхийлэлийн нөхцөл байдалд гэм буруутай этгээдийг 10 хүртэлх хоног хорих бүрэн эрхийг олгосон. Үүний дараа эмэгтэйчүүд энэ хугацааг сунгуулахаар шүүхэд хандаж болно.[21] /Энэ хууль нь хохирогч эмэгтэйчүүд нь сэтгэл зүйн зөвөлгөө авах тусламж хүртэж харин эрэгтэйчүүд нь албадлагаар гэртээ эзгүй байх үедээ засан хүмүүжүүлэх курсэд сууж болох хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх теслийг хэрэгжүүлэхийг тусгаж өгчээ./ Шинэ Зеландын хууль, шүүхээс, хохирогч болон хүүхдүүдтэйгээ харьцах нь аюулгүй гэдгийг тогтоох хүртэл түрэмгийлэгч хохирогч болон хүүхдүүдтэйгээ харилцаа холбоогүй байх зайлшгүй шаардлагатай гэдгийг дурдаж өгснөөрөө давуу талтай.

Бельги /1997/, Франц /1994/, болон Испани /1999/ гэсэн улс орнууд хууль тогтоомжиндоо гэрийн нөхцөл байдалд хүчирийлэл үйлдсэний төлөө илүү хатуу чанга ял шийтгэлийг тусгаж өгчээ

Гуравдугаар бүлэг

3.1. Гэр бүлдэх хүчирхийллийн тухай НҮБ-ийн зөвлөмж түүнд Монгол улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нийцсэн байдал

Доорх загвар хуулийг өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн болон иргэний хууль тогоомжуудын боловсронгүй бус байдлыг өөрчлөн сайжруулах буюу гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулиудыг боловсронгүй болгох зорилготой. Уг загвар нь хууль тогтоох байгууллагууд болон гэр бүлийн хүчирхийлэлийн салбарт хүйсийн өвөрмөц онцлогыг тусгасан, хүчирхийлэлтэй холбоотой бүх асуудлыг багтаасан хууль тогтоомж гаргахын төлөө үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад НҮБ-ээс зориулан гаргасан

[21] Annual Report on Equal Opportunities For Women and Men in the European Union 2000 ,Report From the Commission to the Council, tne Europen Parhament

байна. Энэ зөвлөмж хууль манай улсын гэр бүлийн хүчирхийлэлийн хуулинд хэр зэрэг тусгагдсан талаар харьцуулан хархад доорх дүгнэлт гарч байна.

А.Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуулийн зорилго

1.Эмэгтэйчүүдийг хүчирийлэх явдлыг үндсээр нь устгах тухай НҮБ-ын Тунхаглалд "эмэгтэйчүүдийг хүчирхийлэх гэдэг нь эмэгтэйчүүдэд бие махбодь, бэлгийн буюу сэтгэл санааны гэм хор буюу зовлон шаналал учруулж буюу учируулж мэдэх, бэлгийн харьцааны шинжтэй үндэслэлээр үйлдсэн хүчирхийллийн аливаа үйлдэл, мөн ийм үйлдэл хийхийг занал хийлсэн, албадсан, нийгмийн буюу хувийн амьдрал дахь эрх, эрх чөлөөг дур мэдэн хасах явдал мөн , хэмээн тодорхойлсон стандартыг сахин мөрдөхөд тустай гэжээ.

2."Эмэгтэйчүүд, тэр дундаа гэр бүлийн гишүүд буюу гэм хор учируулагч этгээдтэй ойр дотны харьцаатай эмэгтэйчүүдийг бэлгийн харилцааны шинжтэй үндэслэлээр хүчирхийлсэн үйлдэл бол гэр бүлдэх хүчирхийлэл мөн"гэдгийг хүлээн зөвшөөрөх.

3."Гэр бүлийн хүчирхийлэл бол бие хүн болоод нийгмийн эсрэг, уучлашгүй, тэвчишгүй ноцтой гэмт хэрэг мөн" гэдгийг хүлээн зөвшөөрөх.

4.Хүчирхийлэл хохирогчдыг хамгийн дээд хэмжээний эрх зүйн хамгаалалтаар хангах. Гэсэн заалтуудыг голлон авч бичлээ.[22]

Б.Зохицуулвал зохих харилцааны хүрээ

1. Гэр бүлийн хүчирхийлэлийн тухай хуулийн үйлчилэх хүрээнд дараах категориудын харилцааг оруулсан болно: эхнэр, хамтран амьдрагч, өмнөх эхнэр буюу хамтран амьдрагч, хамтран болон тусдаа аж төрдөг төрөл төрөгсөд, эгч дүүс, охид, эхчүүд, мөн гэрийн үйлчлэгч болон тэдний гэр бүлийн гишүүд.

2. Шашны буюу соёлын зан заншил нь хэн нэгэн эмэгтэйд тухайн хуулийн хүрээнд бүрэн хамгаалалт авахад нь саад болохыг Төрөөс зөвшөөрөх ёсгүй.

3.Хань нөхөр эсвэл ойр дотны харилцаатай өөр бусад этгээдийн талаар шүүх байгууллагад хандахыг хүссэн эмэгтэйд ямарч саад тотгор учирах ёсгүй.

4.Төрөөс тухайн хуулийн хүрээнд, тухайн улсын иргэний харъяалалгүй эмэгтэйчүүдэд бүрэн хамгаалалт олгох, мөн тухайн хуулиар, тухайн улсын иргэн бус эрэгтэйчүүдэд хуулийн хариуцлага ноогдуулах ёстой.

В.Гэр бүлдэх хүчирхийллийн шинжтэй үйлдэлүүд

Гэр бүлийн болон ойр дотны харилцаатай этгээд буюу этгээдүүд бэлгийн харьцааны шинж бүхий үндэслэлээр үйлдсэн, бие махбод, сэтгэл зүйн болоод бэлгийн харьцааны шинжтэй, хэл амаар доромжлох, айлган заналхийлээс эхлээд бие махбодид хүнд гэмтэл

[22].Western stantarts for fost communist women Egual Opportunities for Women and Men. Annual Report on Equal Opportunities For Women and Men in the European Union 2000 ,Report From the Commission to the Council, tne Europen Parliament

учруулах, хулгайлах, бэртээж гэмтээхээр заналхийлэх, айлган сүрдүүлэх, албадах, мөрдөж мөшгөх, хэл амаар доромжлох, орон байранд хүчээр буюу хууль бусаар нэвтрэн орох, шатаах, өмч хөрөнгө устгах, бэлгийн хүчирхийлэл, хүчээр гэр бүл болох, сүйт бүсгүйн инж сүй буюу төлөөстэй холбоотой хүчирхийлэл, бэлэг эрхтэнг бэртээж гэмтээх, янхандах замаар ашиглахтай холбоотой хүчирхийлэл, гэрийн үйлчлэгчийг хүчирхийлэх хүртэлх, хүчирхийлэлийн шинжтэй бүх үйлдэл, мөн тийм үйлдэл хийх оролдлогыг "гэр бүл дэх хүчирхийлэл"гэж үзэх ёстой. Манай улсад мөн энэ талаар тодорхой нарын зааж өгөөгүй байгаа юм.

Г.Гомдол гаргах механизм

Хүчирхийлэлийн хохирогчид, тэдний гэр бүлийн гишүүд, хүчирхийллийн гэрч, хүчирхийлэлийн хохирогчдын ойр дотнын хүмүүс, хүчирхийлэлийн хохирогчдод хоргодох байраар үйлчилсэн этгээдүүд, төрийн болон хувийн эмнэлгийн байгууллагууд, нийгмийн алба, хүчирхийлэлийн хохирогчдод тусламж үзүүлэх төвөөс гэр бүлийн хүчирхийллийн талаар цагдаад гомдлоо бүртгүүлэх эсвэл шүүхэд өргөдөл өгөх журмыг хуулинд тусгасан байх ёстой. Харамсалтай өнөөдөр манай гэр бүлийн хүчирхийллийн тухай хуульд нарын тодорхой огтхон ч зааж өгөөгүй бөгөөд цагдаагын байгууллагын үүргийг л оруулж өгсөн байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд дотоодын эрх зүйн орчин чухал үүрэгтэй бөгөөд шинэ тусгаар тогтносон орнууд шилжилтийн үед хийсэн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд энэ асуудлыг хийх хэрэгтэй байна. Эрх зүйн шинэчлэл, нийгмийн тулгамдсан асуудлыг зохицуулалтын хүрээнд зарим орон эмэгтэйчүүдийн тэгш байдлыг хангахад чиглэгдсэн төрийн бодлого, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх хэрэгтэй байна.[23]

Дүгнэх буюу санал

Дээрхи харилцааны эрх зүйн зохицуулалтыг боловсроигуй болгох хүрээнд дараах зүйлийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хүйсээр тодотгосон хүний эрх, халдашгүй байдлын асуудлууд зөрчигдсөн хэмээн дуулдах нь тун ч олон. Тухайлбал, нөхөртөө дарлуулсан эмэгтэй, хүчинд автсан бүсгүй гээд энэ сэдвийн гол хохирогч нь эмэгтэйчүүд байдаг. Охид бүсгүйчүүдийн байгалиас заяагдсан мөн чанар нь эмзэг турьхан төдийгүй гэнэн итгэмтгий байдаг нь үнэн. Байгалиас заяасан уг чанар нь нэг талаас хүчирхийлэлд өртөх өгөөш болдог. Нөгөө талаас эрчүүдээс ялгарах ялгуун төрх юм. Түүний дотор эмэгтэй хүн болгон өөрийн гэсэн ааш, зүс царайтай. Харин дээр дурьдсан хүчинд өртөмтгий сул тал бол баян, ядуу, тарган, туранхай бүх эмэгтэйд байдаг шинж.

Манай оронд охид эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах газар олон бий ч эрчүүдийн эрхийг хамгаалах газар гэж бараг дуулдаагүй. Байдагч юмуу? Үгүйч юмуу ёстой чөтгөр

[23] Гэр бүлийн эрх зүйн байдлыг шинэчлэх зарим асуудал УБ 2009 он

бүү мэд. Байдаг байсан ч үйл ажиллагаа нь тогтвортой биш хийгээд онцын нэмэргүй гэж эрчүүд маань хэлэх юм. Манай орны хувьд нийт хүн амын 70 орчим хувь нь эмэгтэйчүүд, харин үлдсэн нь эрэгтэйчүүд шүү дээ. Дийлэнх болсон эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөж байгаа тохиолдол олон байгаа учраас хамгаалах байгууллагууд ч нэлээд бий. Хамгийн сүүлд хийгдсэн судалгаагаар манай эмэгтэйчүүдийн 18-35 насныхан хүчирхийлэлд өртөх нь элбэг гэж тогтоогдсон байна.

Манайхан хүчирхийлэл гэхээр бэлгийн талаас нь ойлгодог. Үүнийг буруутгах арга ч үгүй юм даа. Хүчирхийлэлд өртөж байгаа эмэгтэйчүүдийн 50-аас дээш хувь нь бэлгийн хүчирхийлэлд өртөж байна. 90-ээд оны үед нөхрөөсөө жавтгий хүртэх хүүхнүүд олон байсан бол 2000 он гарсаар бэлгийн хүчирхийлэл тэр дундаа ажлын байрны бэлгийн дарамт шахалт газар аван хүрээгээ тэлсээр байна.

Бичих гэж байсан сэдвээсээ бүр хазайж орхилоо. Яншаа занг минь өршөө. Энэ удаад эрчүүдээ өмөөрөх гэж байсан юм. Дээр бичсэнийг уншсан эрчүүд маань нэгийг бодохгүй юу даа. Айлын охиныг жаргаанаа хэмээн найрж авсанаа нэг санаарай. Харин одоо эрчүүд хүчирхийлэлд хэр өртөж байна? Энэ сэдвийн хүрээнд өөрийн бодол, олж мэдсэнээ хуваалцья. Би эрэгтэй ахтайгаа ярилцлаа. Ах маань 38 настай. Жирийн нэгэн сайхан залуу.

❖ **Судлаач:** Танай эхнэр танийг алгадаж байсан уу?

Ах: Харин тийм, үе үе сарвайгаад л байдаг юм. Уур хүрээд л явчихдаг юм.

Энэ бол би ахтайгаа ярьсан богино яриа байлаа. Энэ маягаар 21-50 насны 70 –аад орчим эхнэртэй, 2-оос дээш жил үерхсэн найз бүсгүйтэй эрэгтэй найзуудаасаа асуугаад л байлаа. Миний найзууд гэхээр яахаараа ийм дарлуулчихсан байдаг юм.

Арай ч дээ гэж сэтгэл баахан хямарлаа. Өмөөрмөөр санагдчихлаа шүү. Юуны тулд хуулийн сургуульд сурдаг билээ. Тэгээд багш, эдийн засагч, хуульч, жолооч, гээд л тэрч бүү хэл төрийн алба хаагч танихгүй олон эрчүүдээс асуулаа. Тэгсэн яасан гээч, ёстой баларсан юм болсон. Бүгдэд нь эмэгтэй хүн ямар нэгэн байдлаар халдаж эрхийг нь зөрчсөн байгаа юм даа. Хор нөлөө их үзүүлж чадаагүй ч тухайн хүний амгалан байдалд халдаж, алгадах, хүзүү нүүрийг нь самардах, маажих, өшиглөх, бүр аймшигтай нь архи ууж агсан тавих эхнэр хүртэл байдаг юм байна. Архичин ээжээсээ айгаад аавынхаа ард нуугдсан уйлагнах хүү хичнээн өрөвдөлтэй вэ? Сайхан бүсгүйчүүд минь ээ, бодоод үз дээ.

Чиний хайртай залуу чамайг алгадаад авбал чи яах вэ? Сарвагнах нь сарвагнаж, салах нь сална. Үгүй юмаа гэхэд нэг хэсэгтээ тунирхаж айлгана биз дээ. Тэгсэн хэрнээ эр нөхрөө, хайртай залуугаа алгадчихаад өөрөө тунин сууна гэдэг чинь сүүтэй сахартай цай шиг нялуун санагдаж байна. Үүнийг сэтгэл судлал талаас нь ингэж тайлбарладаг юм байна. Эмэгтэйчүүд эрчүүдээс угаас хүч сул. Гэсэн ч эрчүүдээс дутахгүй, доор нь

орохгүй гэсэн далд ухамсар эмэгтэйчүүдэд байдаг юм байна л даа. Хэрүүлийн оргил шатанд уурандаа шатаад далд ухамсараа "Би чамаас мундаг илүү, бас хүчтэй" гэж бүсгүйчүүд цээжээ дэлдэн аавын хүүгийн хацар дээр тас хийтэл цохино.

Нэг талаас эрчүүдийн доор орох дургүйдээ ийм ухамсаргүй алхам хийдэг байх. Нөгөө хэсэг нь энэ намайг яаж ч чадахгүй гэж бат итгэгсэд хумсаа хурцалдаг байна. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр тэр танд хайртай, та ч бас түүнд хайртай гэсэн үг. Хайрын бэлгэ тэмдэг хүчирхийлэл гээд ойлгочихов доо, та нар минь. Тэгэхлээр бүсгүйчүүд ч гэсэн эрчүүдээ хүчирхийлдэг байх нь. Хатууг зөөлөн иддэг. Эрчүүдээ, бүсгүйчүүдээ ойлгомжтой тийм ээ. Ямар ч эмэгтэйтэй суусан хүчинд өртөх юм байна гэж сэтгэлээ бүү чилээ дээ, залуу минь. Салаад бас алгадахгүй эмэгтэй олно гэж сэрүүн битгий зүүдлээрэй.

Дараах саналуудыг дэвшүүлж байна.

1. Гэрлэгсдийн хүчин, болзооны хүчингийн талаарх хуулийн ойлголт тодорхойлолтыг гаргах, мөн Улсын дээд шүүхийн тайлбарт оруулах.

2. Манай улсын гэр хүчирхийллийн хуульд хүчирхийллийн хэлбэр гэж оруулж өгсөн ба тайлбар хийгээгүй байна. Сэтгэл зүйн хүчирхийлэл огт байдаггүй ба энэ талаар Украйн улсын гэр бүлийн хүчирхийлэлийн хуулинд тодорхой оруулж өгсөн байна. Үүнд гэр бүлийн нэг гишүүний үйлдэлтэй холбогдон гэр бүлийн нөгөө гишүүний сэтгэлд зүйд нөлөөлсөн үгээр гутаан доромжлох, заналхийлэх, мөрдөн мөшгих, айлган сүрдүүлэх замаар өөртөө итгэх итгэлгүй болгох, өөрийгөө хамгаалах чадваргүй болгох, сэтгэл зүйн эрүүл мэндэд нь хохирол учируулж болох буюу учируулсныг гэж тодорхой заажээ.

Мөн гэр бүл дэх бие махбодийн хүчирхийлэл, гэр бүл дэх бэлгийн хүчирхийлэл, гэр бүл дэх эдийн засгийн хүчирхийлэл, гэр бүл дэх сэтгэл зүйн хүчирхийлэл зэрэг тодорхойлолтуудыг хийж өгөх.

Жишээ нь: гэр бүл дэх бие махбодийн хүчирхийлэл гэдгийг гэр бүлийн нэг гишүүн нөгөө гишүүний зодох, хохирогчыг үхэлд хүргэж болох буюу үхэлд хүргэсэн бие махбодийн гэмтэл санаатай учируулсан, бие мах болон сэтгэл зүйн эрүүл мэндийг нь хохироосон, нэр төр, алдар хүндийг нь гутаасныг,

Жишээ хоёр: гэр бүл дэх бэлгийн хүчирхийлэл: гэр бүлийн нэг гишүүн нөгөө гишүүнийхээ бэлгийн халдашгүй байдалд хууль бусаар халдах, түүнчлэн гэр бүл дэх насанд хүрээгүй гишүүнийг эсрэг бэлгийн чанартай арга үйлдэл.

Жишээ гурав: гэр бүл дэх эдийн засгийн хүчирхийлэл: гэр бүлийн нэг гишүүн нөгөө гишүүнийхээ орон байр, хоол хүнс, хувцас хунар бусад эд хөрөнгө буюу хэрэгслүүдээс санаатайгаар салах, тэдгээрт хохирогч хуулиар тогтоосон эрхтэй, энэ түүнийг үхэлд хүргэж болох, бие махбод болон сэтгэл зүй эрүүл мэндэд нь нөлөөлснийг.

Жишээ дөрөв: Гэр бүл дэх сэтгэл зүйн хүчирхийлэл: гэр бүлийн нэг гишүүний

үйлдэлтэй холбогдон гэр бүлийн нөгөө гишүүний сэтгэл зүйлд нөлөөлсөн үгээр гутаан доромжлох, заналхийлэх, мөрдөн мөшгих, айлган сүрдүүлэх замаар өөртөө итгэх итгэлгүй болгох, өөрийгөө хамгаалах чадваргүй болгох, сэтгэл зүй эрүүл мэндэд нь нөлөөлснийг .

3. Family Court- Гэр бүлийн шүүх-Монгол улсын Үндсэн хуулинд тусгай шүүхүүдийг байгуулж болно гэсэн заалт бий.[24] Энэ ч үүднээс гэр бүлийн тусгай шүүхийг байгуулах боломж нь хуулиар нээлттэй болж байгаа юм. Гэр бүлийн дотоод асуудал гэсэн нэрийн доор хүчирхийлэл үйлддэг байдлыг таслан зогсооход ийм шүүхийн гол зорилго чиглэгдэж байгаа. Гадны олон оронд энэ төрлийн шүүх байдаг ажээ.

4. Монголын улсын гэр бүлийн тухай хуульд "сэтгэлийг" хуульчилж өгөх ёстой. Материаллаг байдал хуульчилж байгаа нь үр дүнд хүрэхгүй байна. Энэ бүх гаж буруу шалтгаан нь харилцаа холбоогүй байдал, хүмүүжлийн доголдол, дутмаг хайр энэрэл, ирээдүйдээ сэтгэл зовсон байдал гэх мэт олон зүйлээс хамаардаг.

5. Манай улсын хүн амын насны бүтэц идэршиж байгаатай холбоотойгоор дунд насны гэр бүлийн тоо өсөн Монгол гэр бүлийн цөмийг бүрдүүлэх хүн ам зүйн тооцоо байгаа тул нийгэм эдийн засгийн эерэг сөрөг үр дагаврыг урьдчилан харсан гэр бүлийн бодлого, үйл ажиллагааг боловсруулан төрөөс явуулах шаардлагатай байна. Гэр бүлд байнга тулгарч байдаг эдгээр бэрхшээлүүдээс үүдэн дийлэнх гэр бүлийн дотор байнгын хэрүүл маргаан, хөрөнгө мөнгө, эрх мэдэл, албан тушаал боловсролын ялгаа, хамаатан садан эцэг эх, ах дүүгийн дарамт, архидалт, ажилгүйдэл, хүчирхийлэл, гэр бүл салалт зэрэг олон сөрөг үр дагаварууд гарах болсон байна. Улс орнуудын нийгмийн хөгжил нь гэр бүлээс, гэр бүлийн хөгжил нь хүнээс, хүний хөгжил нь хүүхдээс шууд хамаарах болсноор гэр бүлийн ариун байдал, үнэт зүйлс, ёс билэгдэл, дэг журам зэрэг нь нийгмийн төдийгүй, хүүхдийн хөгжилд чухал байр суурийг эзлэх болсон нь харагдаж байна. Тиймээс гэр бүл болоход тохиромжтой насыг хуулинд нэмэж оруулах цаг иржээ. Насны доод хязгаарыг 21 насаар хуульчилж өгөх. Төлөвлөөгүй балчиг гэрлэлт ирээдүйн үр хүүхдийг өнчрүүлсээр байгааг та бүхэн бодох цаг болсон.

6. Гэрийн үйлчлэгчийг хүчирхийлэх хүртэлх, хүчирхийллийн шинжтэй бүх үйлдэл, мөн тийм үйлдэл хийх оролдлогыг "гэр бүл дэх хүчирхийлэл" гэж үзэх ёстой. Энэ талаах НҮБ-ийн зөвлөмж хуулинд оруулж өгсөн байх ба энэ нь хүний эрх талаасаа мөн орчин үеийн гэр бүлд байдаг асуудал үнэхээр гэрийн үйлчлэгч, асрагч хүмүүс гэр бүлийн гишүүнд тооцогдох ёстой хэдийгээр цусан төрлийн холбоогүй ч гэсэн учир хэрэв сул орхигдвол тэр хүмүүсийн эрхийг хамгаалж чадахгүйд хүрнэ.

---

[24] Монгол улсын хууль "Үндсэн хууль" УБ хот 1992 он

Дочин долдугаар зүйл

3.Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна.

Дөчин наймдугаар зүйл

1.Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.

7. Гэр бүл ахуйн хүчирхийллийн эсрэг хууль батлах санал: Энэ санал нь илүү өргөн утгыг агуулсан ба гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулийг үндсээр нь өөрчлөх гэж ойлгож болох юм. Энэ хууль батлагдах шаардлага зүй ёсоор гарч ирсэн бай на.

Үүнд: Юуны өмнө хуулийн зохицуулалтад хамрагдах субъектын хүрээг өргөн болгох. а.гэр бүлийн гишүүн, б.садан төрөл, в.хамтран амьдрагч гэсэн байдлаар учир нь гэрийн үйлчилэгч, хажуу өрөө хөлслөн суугч, гэрлэлтээ бүртгүүлээгүй хамтран амьдрагчид, гэр бүлээ цуцлуулсан бөгөөд хамт буюу тусдаа амьдарч байгаа боловч салсан нөхрийн зүгээс хүчирхийлэлд өртөгчид зэрэг нь гэр бүлийн гишүүн гэдэг нэр томъёонд хамаарахгүй байна.

Мөн энэ хуульд шүүх эрх мэдлийн байгууллагууд, төрийн бус байгууллагын эрх, үүрэг, иргэдийн оролцооны асуудлыг нарывчлан тусгавал зохистой.

Үүнд: Тусгаарлах шийдвэрийг шүүх:

а. Зөрчил гаргасан тохиолдолд

б.Шүүхээр хэрэг хэлэлцэгдэх явцад.

в.Хэрэг маргааныг эцэслэн шийдвэрлэх үе шатуудад гаргаж байхаар заасан.

Өөрөөр хэлбэл заавал гэрлэлт цуцлуулах тухай зэрэг нэхэмжлэл гарсан байхыг шаардахгүй гэсэн байдлаар.

Нэгдүгээр бүлэгт: "Нийтлэг үндэслэл"

- Хуулийн зорилт

- Хамрагдах этгээдүүд

- Зарчим, хуулийн нэр томъёо

Хоёрдугаар бүлэгт "Нийгмийн алба, түүнийүйлажиллагаанычиглэл"

Гуравдугаар бүлэгт

- Гэр бүл, ахуйн хүчирхийлэлтэй тэмцэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо эрх үүрэг.

Дөрөвдүгээр бүлэгт:

- гэр бүл, ахуйн хүчирхийлэлд өртсөн хохирогчын эрх, хамгаалах эрх зүйн арга хэлбэрүүд

Тавдугаар бүлэгт: Бусад зүйл гэсэн бүлгүүдтэй байвал зохино.

Энэ хуулийн санал гаргахад дараах зүйлс дээр анхаарав:

- Гэр бүл, ахуйн харилцааны хүрээнд эрх зүйн зөрчил гаргасан этгээдэд захиргааны

арга хэмжээг хянан ба торгууль хүлээлгэх хариуцлагыг хасах, учир нь зөрчил гаргагч этгээдэд торгууль хүлээлгэх хариуцлага ноогдуулсан тохиолдолд эмэгтэй хүн, хүүхдүүд зовж шаналах нь илүү олонтой байдаг.

• Өргөдөл хүлээн авахаас татгалзсанынх нь төлөө албан тушаалтанд захиргааны хариуцлага тооцох.

• Гэр бүл дэх эрх зүйн зөрчилийг үнэлэхдээ олон нийтийн үйл ажиллагаанд аюул эс учруулах ач холбогдол багатай байх гэсэн ойлголтыг хасах, учир нь хууль хамгаалах байгууллагууд заримдаа энэ үндэслэлд хөтлөгдөөд хохирогчид эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалздаг.

8. Төрийн хяналтын түвшинд: хүчтэй хэрэгсэл болох мэргэжлийн хяналтын тогтолцооноос нь төрөөс хүний эрхийг хангаж, баталгаажуулахад чиглэсэн үйлчилгээ үзүүлж чадаж байгаа эсэхийг огт хяндаггүй нь ноцтой дутагдал юм. Хэдийгээр хууль тогтоомж, стандартыг төрийн үйлчилгээнд дагаж мөрдөж байгаа эсэхийг мэргэжлийн хяналтаар шалгаж, үнэлдэг боловч хүний эрхийг хамгаалах, хүчирхийлэлтэй тэмцэх асуудлаар төрийн үйлчилгээний тодорхой стандарт, журам, хуульчилагдсан үйл ажиллагаа байхгүй байгаагаас мэргэжлийн хяналтын институтыг хүний эрхийг хамгаалах асуудлаар хууль тогтоомжын хэрэгжилтийг хянах боломжгүй болгожээ. Хэдийгээр хүний эрхийг хангах, баталгаажуулах асуудлаар дагнасан хууль тогтоомж батлагдан үйлчилж байгаа боловч эдгээр хуулийг хэрэгжүүлэх хэрэгжилтэнд хяналт тавих төрийн механизм нь хангалттай хуульчлагдаагүй байна.

Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хүний эрхийг хангах чиглэлээр хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд байгууллагын дотоодод хариуцлага тооцох механизм бүрдүүлэх.

Цагдаагын байгууллагын үйл ажиллагаанд эмэгтэйчүүд хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгж байгуулах.

9.**Шүүхийн хяналтын түвшинд:** Хүний эрхийг хангах үндсэн баталгаа болох шүүхийн хяналтын тогтолцоо нь эмэгтэйчүдийн хүчирхийлэлтэй холбоотой, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хуулийн хэрэгжилтийг хянах тал дээр туйлын хангалтгүй байна. Учир нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжын хүрээнд гэмт хэргийн шинжгүй хүчирхийлэлийг эрх зүйн зөрчилд тооцож хариуцлага хүлээлгэхээр заасан хэм хэмжээ огт байхгүй байгаа нь шүүх эрх мэдлийн байгууллагаас хүчирхийлэлтэй тэмцэх, хууль сахиулах байгууллага хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжыг хэрэгжүүлж байгаа эсэх боломжыг үгүйсгэж байна. Иймд хариуцлагыг тодорхой болгох зайлшгүй шаардлага байна.

10. Шүүхийн хяналттай холбоотой өөр нэг бэрхшээл бол Үндсэн хуулийн цэцэд хүний эрхийн зөрчилтэй холбоотой гомдол хүлээн авч шийдвэрлэдэггүй явдал юм.

Дэлхийн бусад орны жишгээс авч үзвэл төрийн байгууллага, албан тушаалтанаас хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангах , хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн талаар иргэд үндсэн хуулийн шүүхэд гомдол гарган шийдвэрлүүлдэг байна. Харин манай улсад ийм боломжгүйн улмаас төрийн байгууллага, албан тушаалтан хүний эрхийг хангах, хамгаалах үүргээ биелүүлээгүй тохиолдолд тавих хяналтын хүчтэй механизмгүй болоод байна.

Цоожтой хаалганы цаадах хүний эрхийн том зөрчил бол гэр бүлийн хүчирхийлэл юм. Эрх зүйт төр хөгжиж буй манай улсад иргэн бүрийн хууль ёсны эрх ашиг сонирхол хөндөгдөхгүй байх цаг ирнэ гэж итгэж байна.

ХҮНИЙ УХАМСАР БА УХАМСАРГҮЙ ОЮУН УХААН



Роломсүрэнгийн Оюунбадам
Монгол Улсын Гавьяат хуульч Шихихутуг дээд сургуулийн багш, хуульч, докторант

Нэрт сэтгэл судлаач З.Фрейд "Хүнийг дан ганц ухамсар биш ухамсаргүй оюун ухаан удирддаг юм биш үү гэсэн санааг анх гаргаж тавьсан байдаг[1]. Хүн бүрт сэтгэлийн хөөрөл, саатал, жаргал, зовлон, хайр, уйтгар, гуниг, уур, бухимдал ээлжлэн тохиолддог. Эдгээрийн дотор сэтгэлийн хүнд цохилт хүнийй сэтгэл зүйгээс амархан арилдаггүйг мэдэхгүй хүн үгүй бизээ. Сэтгэлийн хүнд цохилт нь хүний ухамсарлуу шахагдан ороод тэндээсээ сэтгэцэд идэвхитэй нөлөөлдөг. Ухамсартай үйлдэл энгийнээс нарийн хүртэл явагддаг. Тухайлбал жирийн нөхцөлд намайг хүн харж байгаа, ингэхгүй бол болохгүй, хүмүүс намайг дүгнэж байгаа гэх мэтээр ухамсартаа захирагдан жинхэнэ дүр төрхөө нууж байдаг. *Үүнийг хүний жинхэнэ ба "хуурамч дүр төрх" гэж нэрлэдэг.*

Тэгвэл ухамсаргүй үйлдэл нь хүний мөн чанарт байдаг бөгөөд хүнийг байдгаараа, чөлөөтэй, дураараа байлгахад чиглэгдэнэ. Хүний муу муухай үйлдэлд хүрээлэн буй орчин, нийгэм нөлөөлөх боловч хүний төрөлхийн мөн чанарт оршиж байдаг байна. Ёс зүй, ёс суртахуун лекцэнд хүний зан аашыг заяамал ба олдмол гэж хоёр ангилсан байдаг[2]. Энэ дэлхий дээр хүн өөртэй нь хамт төрсөн заяамал зан, ааш уур уцаар хэр хэмжээнээсээ хэтэрвэл ямар үр дагавар бий болдгийг энэ сэдвээр харуулахыг зорьлоо.

Доктор Г.Бат-Отгон хүний оюун ухааныг хүн сэрэхүй, араатан амьтны сэрэл мэдэрхүйг араатан сэрхүй гэж томёолсон[3] нь сэтгэл судлаач З.Фрейдын дэвшүүлсэн санаатай үндсэндээ ижил байна. Араатан амьтан догшин ууртай. Мал гэдэг амьтан бас ууртай.

- ✓ Тугалаа голсон үнээ.
- ✓ Ишгээ хаясан ямаа гэхчилэн

Амьд амьтан төдийгүй байгаль, дэлхий хүний таагүй үйлдлээс болж ууралдаг гэж үздэг. Усыг сайн сайхан юм бодож уух, усандаа залбирч уувал хүний биед тустай өнгө нь тунгалаг байдаг. Хараал хэлж муу муухай юм бодоод хархад усны өнгө булингартаж бараан өнгөтэй болдог гэсэн эрдэмтэдийн нээлтийг сонсож байв. Араатны уур ямар ч ухамсаргүй ямар ч хяналтгүй уур учраас араатан сэрэхүйдээ тохирсон уур гэж ойлгож болно. Хүн бол оюун ухаантай хүн сэрэхүйтэй амьтан. Уурлах уцаарлах гэдэг нь өнөөдрийн монголчуудын улаан хоолойн дээр нь бэлэн байдаг болжээ гэвэл маргах хүн гарахгүй байх.

[1,2] Сэтгэл зүйч Б.Уганцэцэг, Б.Золзаяа, Х.Хандсүрэн Харилцааны ёс зүй ба стресс менежмент 2007 он 4; 38 тал

[3] Доктор Т.Бат-Отгон. Хатан ухаан цуврал лекц. 2012 он

Уур гэж юу юм бэ? Хүний уур хэрхэн үүсдэг вэ? Цайны уур, бороо шүүдрийн уур зэрэг нь хөнгөн чанартай тул хөөрөөр замхраад алга болно. Хүний уурыг зарим судлаачид хөнгөн зангын илрэл гэж үздэг. Юм болгонд уурлаад байвал **ааш** болно. Өөрөөр хэлбэл байнга уурлаж байдаг хүнийг ааштай хүн гэж хэлдэг. Ааш нь цаашдаа хүндрээд **араншин болно**. Араншин томроод **авир болно.** Авир маш догшин байна. Авир хүндрээд **үзэн ядалт** болно. Үзэн ядалт нь хүндрээд **өшөө авалт** болно. Жишээ нь "хутгалаад алчих юмсан гээд бодоод яваад байсан. Тэр нь маш таагүй үед биелдэг тухай бичигч миний бие олон жишээ хэлэж чадна." Үзэн ядалт тэр хүнийг дотроос нь зоригжуулж өгдөг хамгийн адгийн уур юм.



Эрдэмтэн судлаачдын томьёолоороор хүн араатан сэрэхүйтэй амьтан тэр нь хэдийд яаж илрэх вэ? Согтуу хүн араатан шиг авир гаргадаг нь олонтаа тааралдаж байдаг.

Архи хэмээх хортой ундаа хүний оюун ухааныг (ухамсарыг) дарангуйлаад хүний далд байдаг араатан шинжийг нь гаргаад ирдэг гэж тайлбарлажээ. Хүн уураа барих жолоодох нь ухаантай байх гол шинж юм. Ухаантай байх нь хүн сэрэхүй, араатан сэрэхүй хоёрыг яаж тэнцүүлэхээс хамаарч байна. Хүн сэрэхүйгээ нэмээд араатан сэрэхүйгээ хасаад байвал уураа барьж чадна. Сэтгэлийн хөөрөл саатлыг тархи оюунаар удирдаж, ухаанаар шүүх ёстой

Өмнөх схемийг дахиад нэг харъя. Араатан болон мал амьтан ууралдаг догшин авирладаг. Гэвч тэдэнд үзэн ядалт, өшөө авах шинж чанар байхгүй. *Үзэн ядах, өшөө авах шинж чанар зөвхөн хүнд байдаг.* Энэ чанараараа амьд амьтны уурын хамгийн адаг нь хүний уур юм. Хүн уураа барьж чадвал энгийн уурыг үзэн ядалт өшөө авалтад хүргэхгүй байж болно. "Үг" гэдэг ид шидтэй хэл, ярианы хэрэглүүр *хүнээс хүнд, бодолоос бодолд, тархинаас тархинд, сэтгэлээс сэтгэлд нүүж явдаг. Монголчууд*

- ✓ *хүний сэтгэл эмзэг шүү*
- ✓ *хэлэх үгээ цэнээрэй гэж дуундаа хүртэл оруулсан нь бий.*

Ухаантай хүн гэдгийг цөөн үгээр хэлбэл хүн дандаа бусдаас сурах биш харин өөрөөсөө суралцах хэрэгтэй. Хүн болгон ухаантай байж чаддаггүй. Хүн босоо оршихын

мөн чанар нь **ухаан** юм. Ухааны мөн чанарыг олж харахгүйгээр биеээ засна гэж байхгүй. Ёс суртахуун, зан заншил гэж юу юу вэ?

Өнөөдөр ёс зүйг ажилтны хуульчийн, оюутны, сурагчийн гэх мэтчилэн дүрэм журмаар зохицуулж байна. Гэвч хичнээн сайн дүрэм, журам боловсруулж мөрдлөг болгосон ч олигтой үр дүнд хүрэхгүй байна. Монгол хүний ёс суртахуун улам бүр доройтсоор байгааг та бид харж байна. Хуульчид ёс зүйтэй байх ёстой гэдгийг хамгийн ихээр ярьдаг бас ёс зүйн талаар сайн мэддэг гэж боддог. Зарим хүн чамд ямарч ёс зүй алга би бол ёс зүйтэй хүн гэж ярьж байгаа нь сонсогдож байдаг. Ёс заншил, ёс суртахуун бол хүний биеэ авч явах хэм хэмжээ бөгөөд нийгэм, хамт олны дунд тогтсон зан үйл, ёс журамыг харгалзахыг шаарддаг. Энэ шаардлага нь тухайн хүний мөн чанартай байнга зөрчилдөж байдаг. Хүн дандаа өөртэйгээ ярьж, өөрөө өөрийгөө засаж байхад оршино.

- ✓ Биеэ мэдвэл хүн
- ✓ Бэлчээрээ мэдвэл мал болдог гэсэн ардын үг бий.

Хүн зөвхөн өөрөөсөө сурах биш бусдаас суралцах хэрэгтэй.

- ✓ Тэнэг хүн өөрийнхөө алдаан дээр сурдаг
- ✓ Ухаантай хүн бусдын алдаанаас суралцдаг гэсэн үг ч байдаг.

Мэдвэл зохихоо мэдээд, биеэ засаад ирэхээр хүн **мэдрэмжтэй** болдог. Хуульч хүний эзэмшвэл зохих гол ур чадвар бол мэдрэмж юм. Дотроосоо гэгээрээд ирэхээр хүн уураа барьдаг болно. Зөв зантай, зөв санаатй, зөв харьцаатай, зөв аж төрөх нь ухаантай хүний шинж мөн.